

1. ДЭЛХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

1.1. Дэлхийн эдийн засгийн чиг хандлага болон бодлогын асуудал

Дэлхийн ДНБ-ий өсөлт 2004 оны дундуур түр зуур саарсан боловч тайлант оны эхний улиралд үйлдвэрлэл болон худалдааны салбарын өсөлтийн удаашралыг үйлчилгээний салбарын өсөлт давж гарснаар ДНБ-ий өсөлтийг хурдасгав. Харин хоёрдугаар улиралд газрын тосны үнэ өсч, эдийн засгийн гол үзүүлэлтүүд бууран, эдийн засгийн нөлөө бүхий ихэнх орнуудад бизнесийн итгэл суларч, дэлхийн эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орох шинж тэмдэг илэрлээ.

Тайлант хугацаанд дэлхийн инфляци газрын тосны үнийн өсөлтийн үргэлжлэлээс шалтгаалан бага зэрэг өссөн боловч сүүлийн жилүүдэд дундаж түвшнээс төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Аж үйлдвэржсэн орнуудын хувьд, суурь инфляци ерөнхийдөө бага, инфляцийн хүлээлт тогтвортой, цалин хөлсний өсөлт дундаж хэмжээнд байв. Хөгжиж буй орнуудын хувьд инфляцийн нэлээд дарамттай байгаа бөгөөд тайлант онд ихэнх бүс нутгуудад өсөх төлөвтэй байна.

Хэдийгээр газрын тосны үнийн өсөлтөд голлон нөлөөлж буй хүчин зүйл нь зах зээлийн эрэлт боловч ирээдүйн нийлүүлэлтийг тойрсон геополитикийн үл ойлгогдох байдал мөн хүчтэй нөлөөлж байна. Энэ нь урт хугацааны фьючерс (futures) арилжааны үнэ болон богино хугацааны спот (spot) арилжааны үнийг бараг ижил хэмжээгээр өөрчлөгдөхөд хүргэж байна. Шатахууныг оролцуулаагүй түүхий эдийн үнэ 2004 оны турш тогтвортой байсан бол тайлант онд хүчтэй эрэлт, нийлүүлэлтийн хомсдолоос шалтгаалан өсч эхэлжээ.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал тааламжтай байна. Урт хугацааны хүү хэлбэлзэлтэй байгаа боловч дэлхий нийтийн хэмжээнд ер бусын доогуур байна. Корпорацуудын үйл ажиллагаа жигдэрч, тэдгээрийн ашиг нэмэгдсэнээс хамааран дэлхийн хөрөнгийн зах зээлийн нөхцөл эргээд сайжирч эхлэв. Мөн хөгжиж буй орнуудын эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайжирч, урт хугацааны хөрөнгө оруулагчид нэмэгдэж, санхүүгийн нөхцөл байдал тааламжтай болж байна.

Тайлант он болон 2006 онд дэлхийн ДНБ-ий өсөлт дунджаар 4.3 хувь байх төлөвтэй байна. 2006 оны эхээр дэлхийн эдийн засгийн өсөлт бага зэрэг удаашрах хандлагатай байгаа боловч газрын тосны үнийн өсөлтийн сөрөг нөлөөллийг багасгах макро эдийн засгийн тэлэх бодлого, санхүүгийн зах зээлийн тааламжтай нөхцөл, ялангуяа урт хугацааны хүүний бага түвшин болон корпорацуудын үйл ажиллагаанаас шалтгаалан цаашдаа өсөх төлөвтэй байна.

Улс орнуудын богино хугацаанд явуулах мөнгөний бодлого нь тэдгээрийн өөр хоорондоо ялгаатай эдийн засгийн мөчлөгөөс хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал, АНУ-ын хувьд ажиллах хүчний зах зээл дээр тулгарч буй бэрхшээлийг зохицуулах шаардлагатай байгаа боловч одоо баримталж байгаа хатуу бодлогоо үргэлжлүүлэх нь тохиромжтой. Хятад улс ч үүний нэг адил мөнгөний бодлогоо цаашид чангаруулах хэрэгтэй байна. Харин Евро бүс болон Японы хувьд одоогийн явуулж буй зөөлөн бодлогоо үргэлжлүүлэх нь зүйтэй гэж судлаачид үзэж байна.

АНУ болон Канад

Тайлант оны эхний хагаст АНУ-ын ДНБ-ий өсөлт хүчтэй хэвээр байсан нь иргэд, бизнесийн орлогын өсөлт сайн, ажиллах хүчний зах зээлийн нөхцөл тогтвортой сайжирсан, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал тааламжтай байсан болон хувийн орон сууцны үнэ өссөн зэрэгтэй холбоотой. Хэдийгээр бизнесийн болон хэрэглэгчдийн ирээдүйн хүлээлт тааламжтай хэвээр байгаа боловч газрын тосны үнийн өсөлтийн үргэлжлэл нь ойрын үед эдийн засгийн өсөлтөд илүү сөргөөр нөлөөлөхөөр байна.

Газрын тос болон бусад түүхий эдийн үнэ өссөний улмаас 2005 оны эхний хагаст АНУ-ын инфляци 3.0 хувьтай байсан бол суурь инфляци өөрчлөгдөөгүй 1.7 орчим хувьд хэлбэлзэв. Гэвч эдийн засгийн өсөлт боломжит хэмжээнээс хэтэрсэн, бодлогын хүү ихэнх тохиолдолд тооцоолсноос доогуур байсан тул Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ өсгөх бодлогоо үргэлжлүүлэн баримтлав.

Газрын тосны өндөр үнэ, “Катрин” зэрэг байгалийн гамшгаас шалтгаалсан хүмүүсийн шилжилт хөдөлгөөн зэрэг нь хувийн хэрэглээнд сөргөөр нөлөөлж, тайлант оны хоёрдугаар хагаст ДНБ-ий өсөлт хүлээгдэж буй түвшнээс доогуур байхаар байна. Гэвч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хэвийн, ашигт ажиллагаа нь өндөр, зарим салбарт хөрөнгийн хуримтлал хангалтгүй байгаа зэрэг нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, улмаар 2006 онд өсөлт эргээд сэргэх байдал ажиглагдаж байна.

Газрын тосны үнийн өсөлт болон АНУ-ын эдийн засгийн өсөлт 2005-2006 онд бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад өндөр байх зэргээс шалтгаалан тайлант онд урсгал дансны алдагдал өсч, ДНБ-ий 6.0 хувиас давж гарахаар байна. Цаашид америк долларын ханш сулрахгүй, төсвийн тогтвортой бодлого баримтална гэж үзвэл урсгал дансны алдагдал 2010 он хүртэл энэ түвшинд байх төлөвтэй байна.

Канадад цалингийн түвшин эрс нэмэгдсэн, хувийн орон сууцны үнэ өссөнтэй уялдан хэрэглээ ихэссэн нь бодит ДНБ-ийг өсгөх гол хүчин зүйл болжээ. Хэрэглээний барааны үнийн өсөлт хязгаарлагдмал байгаа бөгөөд суурь инфляци 2.0 хувиас бага байна. Ажиллах хүчний зах зээлийн хатуу нөхцөл, нэгж хөдөлмөрийн хөлс өсч байгаа зэргээс үүдэн үнийн динамикийг анхааралтай судалж зохицуулах хэрэгтэй болсны улмаас Канадын Төв банк мөнгөний тэлэх бодлогоо зогсоожээ.

Засгийн газрын төсвийн ашиг ойролцоогоор ДНБ-ий 0.5 хувийг эзэлж байгаа бөгөөд ирэх жилүүдэд Засгийн газрын цэвэр өрийн ДНБ-д эзлэх харьцаа тогтвортой буурах төлөвтэй байна.

Баруун Европ

Евро бүсийн эдийн засагт 2004 оны хоёрдугаар хагаст сэргэх шинж тэмдэг илэрсний дараа дотоод эрэлт дорвитой нэмэгдээгүй ч цэвэр экспортын хүчтэй дэмжлэгтэйгээр тайлант оны эхний хагаст ДНБ-ий өсөлт дунджаар 1.25 хувьтай болов. Евро бүсийн эдийн засгийг орон тус бүрээр авч үзвэл ялгаатай хэвээр байна. Тухайлбал, Испани, Францад дотоод эрэлт харьцангуй их байхад Герман, Италид сулавтар байлаа. Дотоод эрэлт сул байгаагаас Евро бүсийн инфляцийн дарамт бага байв. Газрын тосны үнийн өсөлттэй холбоотойгоор инфляци 2.0 хувиас илүү байгаа ч суурь инфляцийн өсөлт мэдэгдэхүйцээр удааширчээ.

Тайлант онд Евро бүсийн төсвийн алдагдал ДНБ-ий 3.0 хувьтай тэнцэхээр байгаа бол Франц, Герман, Грек, Итали, Португали зэрэг улсын төсвийн алдагдал энэ хязгаараас хэтрэхээр байна.

Баруун Европын цаашдын төлөв байдал тодорхой бус байна. Эдийн засгийн ирээдүйн итгэлийн үзүүлэлтүүд буурсан боловч экспорт болон үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд ерөнхийдөө сайжирчээ. Түүнчлэн ашигт ажиллагаа нэмэгдэж, цалин хөлсийг зохистой тогтоосноор корпорацуудын үйл ажиллагаа жигдрэн, өнгөрсөн мөчлөгүүдтэй харьцуулахад ажиллах хүчний байдал илүү сайн байлаа. Урт хугацааны хүүгийн түвшин өмнөх үетэй харьцуулахад харьцангуй бага, дэлхийн эдийн засаг өссөн, сүүлийн үед еврогийн ханш суларсан зэрэг нь Баруун Европын орнуудын эдийн засгийг дэмжих болно. Эдгээр хүчин зүйлстэй холбоотойгоор тайлант оны хоёрдугаар хагаст Евро бүсийн эдийн засаг аажмаар сэргэв. Тухайлбал, ДНБ 2005 онд 1.2 хувь, 2006 онд 1.8 хувиар өсөхөөр байна.

Япон

Хувийн секторын дотоод эрэлт сэргэж, тайлант оны эхний хагаст Японы эдийн засаг хүчтэй тэлэв. Сүүлийн 7 жилд анх удаа ажиллагсдын тоо нэмэгдэж, цалин өссөнөөр ажиллах хүчний зах зээл идэвхжиж хувийн хэрэглээ нэмэгдэх үндэс болсон бол корпорацуудын ашигт ажиллагаа нь бизнесийн хөрөнгө оруулалтыг хүчтэй өсгөжээ. Өмнө нь Хятад болон Азийн хөгжиж буй орнуудад гаргадаг экспорт эдийн засгийн өсөлтийнх нь гол хөдөлгүүр байсан бол одоо энэ байдал өөрчлөгдөж, цэвэр экспорт эдийн засгийн өсөлтөд бага хувь нэмэр оруулах боллоо.

Тайлант оны хоёрдугаар хагасын байдлаар ДНБ-ий дефлятор жилийн 0.9 хувь, суурь инфляци жилийн 0.2 хувиар тус тус буурч дефляци бага зэрэг үргэлжилсэн байна. Хэдийгээр хурд нь саарч байгаа боловч газрын үнийн уналт үргэлжилсээр байна. Иймд дефляцийг бүрэн зогсоох хүртэл Японы Төв банк мөнгөний тэлэх бодлогоо үргэлжлүүлэн явуулах нь чухал юм.

Сүүлийн жилүүдэд банк болон корпорацийн үйл ажиллагааг сайжруулахаар хийгдсэн чухал алхамууд нь эдийн засгийн өсөлтийг хангах хөрсийг бий болголоо. Ялангуяа, Санхүүгийн Зохицуулах Агентлаг банкуудын талаархи зохицуулалтаа бага зэрэг сулруулсан нь эргээд банкуудын зээлдэгчтэйгээ илүү ажиллах нөхцлийг бүрдүүлж өгчээ. Энэ үйл ажиллагаа болон эдийн засгийн мөчлөгийн сэргэлтийн үр дүнд томоохон банкуудын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2 дахин гаруй багассан бол корпорацуудын өрийн түвшин болон илүүдэл хүчин чадал буурч банк болон корпорацуудын активын өгөөж өссөн байна.

Урьдчилсан байдлаар Японы бодит ДНБ 2005, 2006 онуудад 2.0 хувиар өсөх төлөвтэй байна. Хэдийгээр дотоод эрэлт сэргэж эхэлж байгаа боловч газрын тосны үнийн үргэлжилсэн өсөлт, дэлхий нийтийн урсгал дансны тэнцвэргүй байдлын орчинд иений ханш чангарч магадгүй байгаа нь өсөлтийг бууруулах эрсдэлийг агуулж байна.

Азийн хөгжиж буй улсууд

2004 оны дунд үеэс Хятад, Энэтхэгээс бусад орнуудын хувьд эдийн засгийн өсөлт удааширч эхэлсэн хэдий ч мэдээллийн технологийн салбарын сэргэлт, аж үйлдвэрийн салбар болон гадаад худалдааны өсөлтөөс шалтгаалан 2005 онд эдийн засгийн өсөлт

хурдасч тус бүсийн эдийн засгийн өсөлт 7.0 хувиас дээш гарах төлөвтэй байна. Өмнөх онтой харьцуулахад инфляци бараг өөрчлөгдөөгүй 4.0 орчим хувьтай байна. Хэдий тийм боловч газрын тосны үнийн өсөлт алсдаа дэлхийн бусад улс орнуудын нэгэн адилаар тус бүсийн эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг агуулж байна. Ялангуяа, Энэтхэг, Индонез, Малайз болон Тайланд зэрэг орны хувьд өнгөрсөн онуудын газрын тосны үнийн өсөлт дотоодын үнэд нөлөөлсөн хэвээр байгаа бөгөөд цаашид ч улсын төсөвт хүндээр тусах магадлалтай.

Тус бүсийн урсгал дансны ашиг өмнөх онд ДНБ-ий 4.1 хувийг эзэлж байснаа 2005 онд ялимгүй буурч 3.7 хувьд хүрэхээр байгаа боловч улс тус бүрийн байдал харилцан адилгүй байна. Тайлант онд оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний квотын хугацаа дууссанаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт хурдацтайгаар өссөн болон импортын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эрэлт суларч зарим салбарт импортын орлуулалт сайжирч байгаатай уялдан импортын өсөлт огцом унасан нь Хятад улсын хувьд урсгал дансны ашиг ДНБ-ий 6.0 хувиас доошгүй гарахад нөлөөлжээ. Бусад улсуудын хувьд урсгал дансны ашиг бага байгаа нь газрын тосны үнийн өсөлт, мэдээллийн технологийн экспортын өсөлтийн сааралт, ханшийн чангаралт (Өмнөд Солонгос, Тайван, Хятад) болон цунами хар салхинаас амссан их хохирол (Тайланд, Индонези) зэрэг хүчин зүйлстэй холбоотой юм.

Гадаад нөөцийн хувьд ч байдал төстэй байна. Бүсийн хэмжээнд гадаад нөөцийн сарын дундаж өсөлт нь 2003, 2004 оныхоос өөрчлөгдөөгүй боловч, энэ удаа Хятад улсын гадаад нөөц нийт нөөцийн гуравны хоёрыг бүрдүүлж байна. Харин 2003, 2004 онд Хятад улс бүс нутгийн гадаад нөөцийн гуравны нэгээс бага хэмжээг бүрдүүлж байжээ.

Тус бүсийн тулгамдаж буй асуудал нь тэнцвэртэй өсөлт болж байна. Энэ нь их хэмжээний хөрөнгө оруулалттай Хятад улсын хувьд ДНБ-ий 40.0 хувийг эзэлж буй хувийн хэрэглээний эрэлтийг нэмэгдүүлэх асуудал юм.

Хятад улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр буюу 9.0 хувьд хүрэх төлөвтэй байна. Мөнгөний бодлогоо чангаруулахын хажуугаар үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлтийг хязгаарлах болон бодлогын бусад арга хэмжээ авсны үр дүнд хөрөнгө оруулалтын өсөлтийг барих оролдлого амжилттай хэрэгжиж байгаа хэдий ч түүний өсөлт 20.0 хувиас их хэвээр байна. Цэвэр экспортын орлого огцом өссөн нь банкны салбар дахь илүүдэл нөөц их хэмжээгээр хуримтлагдахад хүргэсэн бөгөөд түүнийг багасгахын тулд нээлттэй зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгө оруулалт хурдтайгаар өсөх тохиолдолд мөнгөний хатуу бодлогоо улам чангаруулах шаардлага байна. 2005 оны 7 дугаар сард Хятад улс хөвөх ханшийн системд шилжиж, үүний үр дүнд юаний ханш өдрийн дүнгээр 0.3 нэгж хэмжээнд хэлбэлзэх боломжтой болж, 2.0 хувиар чангарсан байна. Энэ нь мөнгөний уян хатан бодлогод шилжих чухал алхам болсон бөгөөд бүрэн хэрэгжвэл цаашид мөнгөний бодлогын төлөвлөлт болон хэрэгжилтэд ихээхэн түлхэц болох юм. Төсвийн алдагдлыг 2005 онд бууруулах төлөвлөгөөний дагуу ажилласны зэрэгцээ цаашид ч бүсээ чангалж чадвал төсвөөс гадуурхи өр төлбөрийг багасгах, хүн амын хөгшрөлтөөс үүдэж буй нийгмийн халамжийн нэмэгдэж буй зардал, улсын байгууллагууд болон банкуудын бүтцийн өөрчлөлт зэрэг асуудлыг шийдвэрлэх боломжтой болно. Хөдөөгийн хөгжилд гоц анхааран хот, хөдөөгийн хоорондын улам ихсэж буй амьжиргааны зөрүүг аажмаар халах, нутаг дэвсгэрийн гүнд орших мужуудын хөгжилд мөнгө түлхүү хаях бодлогыг Хятадын эрх баригчдаас ойрын жилүүдэд явуулах төлөв илэрхий байна. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, ихээр нэмэгдэж буй мөнгөн хөрөнгийг дунд

хугацааны эдийн засгийн өсөлтөд зориулахад улсын байгууллагууд болон банкны шинэчлэл, дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжил зэрэг нь зайлшгүй шаардлагатай байна.

Хятад улс өөрийн эдийн засгийн өсөлтийг ойрын жилүүдэд 7.0-7.5 хувь хүртэл сааруулах бодлого баримталж байна. Тус хөрш орны эдийн засгийн байдлаас Монгол улсын экспортын гол бүтээгдэхүүн болох алт, зэс болон ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ шууд хамааралтай, мөн манай зах зээлээс БНХАУ руу арилжигддаг хөдөө аж ахуйн түүхий эдийн эрэлт хэрэгцээ ихээхэн шалтгаална.

Энэтхэг улсын хувьд эдийн засгийн өсөлт өмнөх оноос бага зэрэг буурч 7.0 хувь байх төлөвтэй байна. Аж үйлдвэрийн сэргэлтээс үүдсэн дотоодын хүчтэй эрэлт болон газрын тосны өндөр үнэ гадаад худалдааны алдагдал огцом өсөхөд нөлөөлсөн боловч эрчимтэй хөгжиж буй үйлчилгээний салбарын экспорт болон хувийн шилжүүлэг нь урсгал дансны алдагдлыг дэнслүүлэх хандлагатай байна.

Сүүлийн жилүүдэд өндөр өсөлттэй байсан Австрали, Шинэ Зеланд улсуудын эдийн засгийн өсөлт сулрах төлөвтэй гарчээ. Австралийн хувьд орон сууцны зах зээлийн үйл ажиллагаа тогтворжиж, ханш чангарсантай холбоотой бол Шинэ Зеланд улсын хувьд ч адил байгаа боловч экспортын өсөлтийн зогсонги байдал нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна.

Латин Америк

Өмнөх онд огцом өсөлттэй байсан Латин Америкийн орнуудын эдийн засгийн өсөлт бага зэрэг сулрах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч гадаад, дотоод эрэлтийн өсөлтийн улмаас эдийн засгийн өсөлт 1990-ээд оны дунджаас дээгүүр байх болно. Түүхий эд материалын эрчимтэй экспорт, бүсийн томоохон улсуудын худалдааны нөхцлийн тааламжтай байдал нь тус бүсийн өсөлтийн гол шалтгаан болж байна. Урсгал данс, гадаад нөөц болон төсвийн зохицуулалт сайжирсан, инфляцийг бууруулах бодлогыг эрчимжүүлсэн зэргээс энэ удаагийн сэргэлт тус бүсийн хувьд тогтвортой тэлэлт болно гэсэн итгэл төрүүлж байгаа юм. Зарим орнуудын урсгал данс ашигтай байгаа бөгөөд бүсийн хувьд урсгал дансны ашиг ДНБ-ий 0.5 хувьд хүрэх төлөвтэй байна. Харин дэлхийн аж үйлдвэрийн эрч суларсантай уялдаж аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт багасжээ. 2004 оны хоёрдугаар хагасаас өсч байсан инфляци эргээд харьцангуй тогтворжсон ч түүхий эд материалын үнийн тогтворгүй байдлаас шалтгаалан өсөх эрсдэлтэй байна. Ялангуяа, АНУ болон бусад аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн өсөлтийн сулрал болон хүүгийн өсөлт нь дэлхийн шатахууны бус түүхий эд материалын зах зээлд сөргөөр нөлөөлөх эрсдэл болж байна. Түүнээс гадна, тус бүсийн зарим орны их хэмжээний зээл, улс төрийн тогтворгүй байдал, удахгүй болох дараалсан сонгууль зэрэг нь өсөлтөд эрсдэл учруулж байна. Мөн газрын тосны үнийн өсөлт бүсийн газрын тос экспортлогч орнуудад тааламжтайгаар нөлөөлж байгаа ч газрын тос импортлогч орнуудад сөргөөр нөлөөлөх юм. Энэ бүхэн нь бодлогын тогтвортой хэрэгжилт болон өрийн зөв зохицуулалтыг шаардаж байгаа юм.

Европын хөгжиж буй эдийн засгууд

Дотоод эрэлтийн өсөлтөөс үүдсэн эдийн засгийн эрчимтэй өсөлт Балтийн орнуудад давамгайлж байгаа бол энэхүү бүс нутгийн бусад улсуудад 2005 онд эдийн засгийн

өсөлтийн хурд саарчээ. 2004 оны турш тус бүс нутгийн улсуудын мөнгөний ханш чангарахын зэрэгцээ, Баруун Европын орнуудын өсөлт суларсан нь бүсийн экспортын хэмжээнд сөргөөр нөлөөлөв. Түүнчлэн Европын Холбоонд элсэхтэй уялдан эрчимжиж байсан эдийн засгийн үйл ажиллагаа суларснаас дотоодын эрэлт буурсан байна. Европын Холбоонд элсэж татварын өөрчлөлт хийснээр өмнөх онд өсч байсан инфляци тайлант онд буурсан боловч зээл олголт эрчимжиж, газрын үнэ өсөн, гадаад худалдааны алдагдал нэмэгдэж байгаа нь үнийн түвшин өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Олон улсын зах зээл дэх хүүний бага түвшин болон ханшийн тогтвортой байдал зэрэг нь банкууд бага хүүтэйгээр гадаадын зээлээр санхүүжих боломжийг олгож байна. Ялангуяа, Балтийн орнууд болон Болгар, Унгар, Румын улсад ийнхүү санхүүжүүлсэн дотоодын зээл олголт огцом өсчээ. Гол төлөв зээлийн өсөлтөөс үүдсэн дотоодын эрэлтийн өсөлт Румын, Латви болон Балтийн бусад орны инфляцийн дарамтыг нэмэгдүүлж байна. Энэ бүхэн нь эдгээр улсад санхүүгийн зуучлал гүнзгийрч байгаагийн шинж тэмдэг мөн эсэх нь шинжээчдийн анхаарлыг татаж байгаа юм. Нийт зээлийн дийлэнх хувь нь жижиг бизнес эрхлэгчдийн болон орон сууцны зориулалттай гадаад валютын зээл байгаа нь зээлийн багц дахь гадаад валютын ханшийн эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Хөгжиж буй бусад орнуудын туршлагаас үзэхэд зээл олголт хяналтгүй өссөнөөр эдийн засгийн уналт, санхүүгийн хямралыг араасаа дагуулах сөрөг үр дагавартай болох нь харагдаж байна.

Польш улсаас бусад орнуудад урсгал дансны алдагдал өндөр хэвээр байна. Ихэнх орны хувьд төсвийн бодлогоо чангатгах, зардлын тогтолцоо болон татварын системийг шинэчлэх замаар төсвийн болон гадаад худалдааны алдагдлаа багасгах, инфляцийг бууруулах буюу бага түвшинд барих зэрэг нь тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн дээр дурьдсан орнуудад зээлийн хяналтын системийг боловсронгуй болгох, хэрэглэгчдийн эрсдэлийн талаархи мэдээллийг сайжруулах зэрэг алхам чухал байна.

Тусгаар Тогтносон Улсуудын Хамтын Нөхөрлөл (ТТУХН)

ТТУХН-ийн орнуудын эдийн засаг 2003-2004 онд эрчимтэй (8.4%) өсч байсан бол тайлант онд өсөлт нь мэдэгдэхүйц буурсан буюу 6 хувьд хүрэх төлөвтэй байна. Ялангуяа, Орос улсын хувьд төрийн бодлогын тогтворгүй байдал, ЮКОС-ыг тойрсон нүргээн, газрын тосны салбарын татварын огцом өсөлт (бараг 90 хувь буюу 1 баррельд 25.0 ам. доллараас өндөр) зэргээс шалтгаалан хөрөнгө оруулалт унаж, газрын тосны үйлдвэрлэл буурчээ. Түүнчлэн Украин улсын хувьд улс төрийн тогтворгүй байдал нь эдийн засгийн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлжээ. Харин хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжсэн гол хүчин зүйл болов. Хэрэглээний өсөлт өндөр гарсан нь дэлхийн түүхий эдийн зах зээлийн нааштай байдал, хөдөлмөрийн хөлсний хурдацтай өсөлт, мөнгөний нийлүүлэлтийн тэлэлт болон зээл олголт өргөжиж байгаатай холбоотой.

Хэрэглээ хурдацтай нэмэгдэж байгаа зарим салбар үйлдвэрлэлийн боломжит хэмжээндээ ойрхон ажиллаж байгаа, гадаад валютын дотоод руу чиглэсэн цэвэр урсгал өндөр хэвээр байгаа зэргээс шалтгаалан тус бүсийн инфляци 2.0 нэгжээр нэмэгдэж 12.6 хувьд хүрэх төлөвтэй байна. Газрын тос олборлогч орнууд ялангуяа, Казахстан, Орос улсын төсөв ашигтай байгаа нь цаашид засгийн газрын зардлыг нэмэх, инфляцийг өсгөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Улс төрийн болон бодлогын тогтворгүй байдлаас үүдсэн хөрөнгийн гадагш чиглэсэн урсгал байгаа хэдий ч металл, шатахуун болон эрчим хүч экспортлогч гол орнуудын урсгал дансны ашиг нэмэгдсэнтэй уялдан гадаад нөөц өссөөр байна. Газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалан тус бүсийн урсгал дансны ашиг нэмэгдэж тайлант онд 10.5 хувьд хүрэх төлөвтэй байна. Ийнхүү богино хугацааны төлөв нааштай байгаа хэдий ч хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх жин (21.0 хувь) Европын бүс нутгийн бусад шилжилтийн эдийн засгуудтай харьцуулахад 5.0 нэгжээр бага байгаа нь дунд хугацааны өсөлтөд эрсдэл учруулж байна. Ялангуяа, түүхий эдийн үйлдвэрлэлээс бусад салбаруудын хөрөнгө оруулалт чамлалттай байгаа. Тус бүсийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд бизнесийн орчинг тааламжтай болгохоос гадна хувийн өмч болон өрсөлдөөнийг дэмжих бүтцийн шинэчлэлтийг үргэлжлүүлэн явуулах, үүнд чиглэсэн төрийн оролцоо, төрийн үйл ажиллагааны нээлттэй байдал зайлшгүй чухал юм.

Африк

Тайлант онд Сахар болон Сахараас өмнөх Африкийн өсөлт 4.8 хувь болж буурах төлөвтэй байна. Тус бүс нутгийн инфляци сүүлийн 30 жилд тохиолдоогүй түвшин хүртэл буурсан нь тухайн улсуудын эдийн засгийн бодлого сайжирсантай холбоотой. Дэлхийн эрчимжиж буй эрэлтийн нөлөө, эдийн засгийн бодлогын шинэчлэл, бүтцийн шинэчлэл тогтвортой явагдсан, зэвсэгт мөргөлдөөн буурсан зэрэг нь тус бүсийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байна.

Газрын тосны үнэ өсч байгаа нь тус бүсийн газрын тос экспортлогч орнуудын эдийн засагт эерэгээр нөлөөлж байгаа боловч бусад түүхий эд материалын үнийн өсөлт хангалтгүй байгаагаас шалтгаалан хөвөн, оёмол сүлжмэл бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүн экспортлогч орнуудын хувьд үйлдвэрлэл буурах хандлагатай байна. Түүнчлэн ургац хураалт муу байснаас зүүн болон өмнөд Африкийн зарим орнуудад хүнсний үйлдвэрлэл унажээ.

Богино хугацааны төлөв эерэг байгаа хэдий ч Африкийн ихэнх орнуудын хувьд ядуурлыг бууруулж, эдийн засгийн тогтвортой өсөлтөд хүрэхийн тулд улам ч ихийг хийх шаардлага байна. Сүүлийн жилүүдэд нэмэгдэж буй хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангаж чадвал үйлдвэрлэл нэмэгдэхээс гадна иргэдийн орлогыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих сайн нөлөөтэй. Түүнчлэн хувийн секторыг дэмжих улс төрийн болон эдийн засгийн институцуудыг хөгжүүлэх, бодлогыг нээлттэй байлгах, хүний капитал болон бусад капиталд хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг хангах, худалдааг нээлттэй болгох талаар бүсийн орнууд илүү ихийг хийх шаардлагатай байна. Хувийн секторын үйл ажиллагааг дэмжих дэд бүтэц бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад чамлалттай байгаа юм. Үүнээс гадна дэлхий нийтийн тус дэм ч чухал байна.

Ойрхи Дорнод

Гадаад худалдааны таатай нөхцөл болон газрын тосны үйлдвэрлэл сүүлийн хорин жилд байгаагүй их хэмжээгээр өссөн нь газрын тос экспортлогч орнуудын гадаад урсгал данс болон төсвийн тэнцлийг эрс сайжруулж, өсөлтийг өндөр байлгахад нөлөөлсөн байна. Цаашид ч газрын тосны зах зээлийн хандлага тааламжтай байх

төлөвтэй тул тус бүс нутгийн эдийн засгийн өсөлт тайлант онд 5.4 хувьтай байх магадлалтай байна. Газрын тос экспортлогч орнуудын үндэсний үйлдвэрлэл нь тус бүс нутгийн нийт үйлдвэрлэлийн 95.0 хувийг эзэлдэг. Газрын тосны үнийн огцом өсөлт нь бүсийн газрын тосны экспортын орлогыг хурдацтайгаар нэмэгдүүлж байна.

Дотоод эрэлт их байгаа хэдий ч бүтээгдэхүүний зах зээл дэх уян хатан, нээлттэй байдал, дэлхийн инфляцийн бага түвшин зэргээс шалтгаалан Иранаас бусад улсын инфляци хэвээр байгаа буюу буурчээ. Ираны хувьд дотоод эрэлтийн өсөлт, хөдөө аж ахуйн салбарын сэргэлт болон мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлснээр инфляци 15.0 хувиас өндөр хэвээр байна.

Бүсийн урсгал дансны ашиг нэмэгдэж тайлант онд ДНБ-ий 21.0 хувьд хүрэх төлөвтэй байна. Газрын тосны орлого буурах хандлага нэг хэсэгтээ үгүй тул энэхүү их хэмжээний орлогыг ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмж, амьжиргааны түвшин, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн эдийн засгийн үйл ажиллагаа, шинэчлэлд үр ашигтайгаар захиран зарцуулах нь хамгийн чухал асуудал болж байна.

1.2. Дэлхийн зах зээлийн ханш, хүү

Дэлхийн инфляци газрын тосны үнийн өсөлтийн улмаас бага зэрэг өссөн ч сүүлийн жилүүдийн дундаж түвшинд байлаа. Ихэнх аж үйлдвэржсэн орнуудад суурь инфляци хязгаарлагдмал, инфляцийн хүлээлт тогтвортой байсан бол хөгжиж буй орнуудад инфляцийн дарамт өндөр хэвээр байв. Инфляци 2005 онд ихэнх бүс нутагт өсчээ.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн нөхцөл сайн байлаа. Урт хугацаатай хүү хэлбэлзэл ихтэй байгаа боловч бага түвшинд байв.

АНУ-ын төсвийн болон урсгал дансны алдагдал их хэмжээгээр өсч байна. Америк долларын ханш унах тохиолдолд Азийн орнуудын Төв банкууд АНУ-ын Төрийн сангийн үнэт цаасыг буцаан худалдаж эхлэх бөгөөд энэ үед ханшаас гадна үнэт цаасны захууд нэлээн хэлбэлзэлтэй болно гэж сүүлийн жилд олон эдийн засагч үзэх боллоо.

АНУ-ын урсгал данс алдагдалтай байгаа хэдий ч америк долларын худалдааны жингээр жигнэсэн ханш 2005 оны эхний 8 сарын байдлаар чангарсан байна. Аж үйлдвэржсэн орнуудын мөнгөн тэмдэгтийн америк доллартай харьцах ханшийн хөдөлгөөн нэлээд хэлбэлзэж байлаа. Тухайлбал, Канад долларын ханш чангарсан байхад иен, еврогийн ханш суларсан байна. Европын Холбооны үндсэн хуулийг Франц, Голланд улс эсэргүүцсэнээс бий болсон Евро бүсийн улс төрийн тодорхойгүй байдал, богино хугацаатай хүүний өөрчлөлт еврогийн ханш сулрахад хүргэжээ.

Хөгжиж буй улсуудын хувьд тэдгээрийн мөнгөн тэмдэгтийн америк доллартай харьцах ханш харилцан адилгүй байсан бол худалдааны хувийн жингээр жигнэсэн ханш Азийн 4 (Индонез, Малайз, Филиппин, Тайланд) улсыг эс тооцвол ерөнхийдөө чангарсан байна.

Хятад улс 2005 оны 7 дугаар сарын 21-ний өдөр юаний ханшийг америк долларын эсрэг хатуу барьсан тогтолцоогоо өөрчилж америк доллар, евро, иен, швейцарь франк гэсэн хэд хэдэн валютаас бүрдсэн сагсны бүтэцтэй хөвөх ханшийн тогтолцоонд шилжсэн нь юаний ханшийг 8.28-аас 8.11 болгож өөрчилсөн байна. Манай улсын

хувьд энэ өөрчлөлт нь 144.1 төгрөгтэй тэнцэж байсан юаний төгрөгтэй харьцах ханш 148 төгрөг хүртэл өсч энэ нь эргээд америк доллар төгрөгийн ханшинд нөлөөлжээ.

Харин Индонез улсаас бусад орны мөнгөн тэмдэгтийн ханшийн хөдөлгөөн ерөнхийдөө харьцангуй бага байв. Индонезийн рупи 8 дугаар сарын сүүлээр нэлээд чангарсан байна.

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Гол түүхий эдийн америк доллараар илэрхийлэгдсэн үнийн ерөнхий индекс 2005 оны эхний 8 сарын байдлаар 29.0 хувиар өсчээ. Газрын тосны хэрэглээ их хэмжээгээр өссөн, газрын тос болон үйлдвэрлэлийн зах зээлийн хүлээлт зэргээс цахилгаан дулааны үнэ 41.0 хувиар өсч, ерөнхий индексэд зонхилох нөлөө үзүүлсэн байна. “Катрин” хар салхи газрын тос болон түүний бүтээгдэхүүний үнэд нөлөөлснөөр тэдгээрийн спот, фьючерс арилжааны үнэ маш мэдрэмгий болов.

Харин шатахуунаас бусад түүхий эдийн америк доллараар илэрхийлэгдсэн үнийн индекс зөвхөн 5.0 хувиар өсөв. Ялангуяа металл болон хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт гол нөлөө үзүүлжээ. Тухайлбал, дэлхийн эдийн засгийн өсөлтийн улмаас бий болж буй эрэлтийн өсөлтөөс металлын үнэ 9.0 хувь, Хятад улсын хүчтэй эрэлтийн улмаас хүнсний бүтээгдэхүүний үнэ 4.0 хувиар тус тус өссөн байна.

Өмнөд Африкийн ургац муудсан, умард Америкийн үр тарианы гарц багассан зэрэг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлсөн байна.

Газрын тос

Хэдийгээр газрын тосны хэрэглээ тайлант онд хүлээлтийнхээ хэмжээнд байсан боловч үнэ нь өссөөр байв. ОПЕК (газрын тос экспортлогч орнуудын синдикат)-ийн гишүүн бус орнуудын газрын тосны нийлүүлэлт багассан нь газрын тосны үнэ өсөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн ч гол нь зах зээл дэх хүлээлтээс болж үнэ өсчээ. Энэ хүлээлт нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурдац, ОПЕК-ийн үйлдвэрлэгчдийн бага нөөц боломж, сүүлийн үед ОПЕК-ийн бус үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн бууралтаас үүссэн болгоомжлол зэргээс үүсчээ. Мөн Ирак, Иран, Венесуэл, Нигери зэрэг орны геополитикийн тодорхой бус байдал нефтийн нийлүүлэлтийн ирээдүй бүрхэг байна гэж үзэхэд хүргэсэн. Зарим судлаачдын үзэж байгаагаар дамын наймааны үйл ажиллагаа нь газрын тосны фьючерс арилжааны үнэд хэт нөлөөлж, олон хоногийн хугацаатай фьючерс арилжааны үнэ хүртэл зах зээлийн өнөөдрийн байдлаас маш их хамаарч байна.

АНУ-ын газрын тосны нэг өдрийн дотоодын үйлдвэрлэлийн 20.0 хувийг бүрдүүлдэг, газрын тосны үйлдвэрүүдийн нийт хүчин чадлын 50.0 орчим хувийг бүрдүүлдэг Мексикийн булангийн газрын тос болон хийн дэд бүтцийг “Катрин” хар салхи сүйтгэсний улмаас газрын тосны үнэ огцом өссөн байна. Газрын тос, бензин, байгалийн хийн үнэ 2005 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хар салхины улмаас өсч, АНУ-ын засаг захиргаа, Эрчим Хүчний Агентлаг стратегийн нөөцөөсөө газрын тосны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх (дэлхийн газрын тосны нийлүүлэлтийг 30 өдрийн турш өдрийн 2 сая баррелиар өсгөх) шийдвэр, Саудын Арабын газрын тосны үйлдвэрлэлийг өдөрт 500 мянган баррелиар өсгөх арга хэмжээний үр дүнд эдгээрийн үнэ эргээд бага зэрэг буурав. Ийнхүү “Катрин” хар салхины улмаас огцом өссөн газрын тосны үнийг

дэлхийн нийтээрээ авсан арга хэмжээний үр дүнд түр ч болтугай бууруулж чадсан ч газрын тос үйлдвэрлэгч үйлдвэрүүдийн сэргээн засварлалт удааширч саатсан зэрэг шалтгаанаас газрын тосны үнэ өндөр, тогтворгүй байв. Хэдийгээр ОПЕК-ийн улсууд нийлүүлэлтийн хомсдлоос сэрэмжилж байсан ч газрын тосны үнэ сүүлийн жилүүдэд тогтмол өссөн байна.

Газрын тосны үнийн өсөлт газрын тосны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, газрын тос экспортлогч орнуудын эдийн засагт эерэгээр нөлөөлж байна. Гэвч газрын тосны өндөр үнэ газрын тос импортлогч орнуудад урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлэх, дотоод үнийг хөөрөгдөх, инфляцийг нэмэгдүүлэх зэргээр сөрөг нөлөөг үзүүлсэн хэвээр байна. Манай улсын эдийн засагт газрын тосны өндөр үнэ нь дотоодын түлш, шатахууны үнэ, түүнийг дагаад бусад бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж, инфляцийг нэмэгдүүлж байгаа зэрэг сөрөг нөлөө үзүүлж байна. Иймээс дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж буй газрын тосны өндөр үнийн нөлөөллийг багасгах макро эдийн засгийн зохистой бодлого явуулах нь дэлхийн нийтийн өмнө тулгарч байна.

Бусад түүхий эдийн үнэ

Металл, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийн улмаас бусад түүхий эдийн америк доллараар илэрхийлэгдэх дундаж үнэ 2005 оны эхний 8 сарын байдлаар 5.0 хувиар өсөв. Ихэнх металлын зах зээлийн нөхцөл байдал олборлох компаниудын хөрөнгө оруулалтыг бууруулж, хөдөлмөрийн асуудалд нөлөөлсөн бол Хятад улсын шар буурцагны эрэлт хүнсний бүтээгдэхүүний үнийн индексэд гол нөлөө үзүүлжээ. Нийлүүлэлт нэмэгдсэнээс 2004 онд цахилгаанаас бусад барааны үнэ буурсантай адил тайлант оны эцэст эдгээр барааны үнэ буурах төлөвтэй байгаа бөгөөд үнийн индекс нь дунджаар 9.0 хувьтай байхаар байна.

Металлын салбарын тогтвортой байдал саарч байгаагаас металлын үнэ оны эхнээс 9.0 хувиар өсөв.

Барилга байгууламж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эрэлт АНУ болон Хятад улсад өндөр байсан нь металлын үнийг 2004 онд өсгөсөн бөгөөд энэ хандлага 2005 онд ч гэсэн үргэлжилсэн байна. Ган үйлдвэрлэгчид төмрийн хүдрийг өнгөрсөн оны үнээс 71.5 хувиар өндөр үнээр борлуулах шинэ гэрээ байгуулсан нь ган төмрийн өндөр эрэлт байгаатай холбоотой юм.

Зэсийн хөрөнгө оруулалт өөрийн түүхэн дэх доод түвшиндээ хүрсэн, сүүлийн үеийн уурхайчдын ажил хаялт зэрэг нь дэлхийн зэсийн нийлүүлэлтийг багасгаж, зэсийн үнийг 20.0 хувиар өсгөв. Ураны үнэ эрэлтээ дагаад 44.0 хувиар өссөн бол хөнгөн цагааны үнэ Хятад улсын экспортын хэмжээ нэмэгдсэнээс бага зэрэг л нэмэгджээ.

Хятадын шар буурцаг ургадаг гол бүс нутгуудын цаг уурын тааламжгүй байдлаас шалтгаалан эрэлт нь хоёр дахин нэмэгдсэн нь түүний үнийг 18.0 хувиар өсгөсөн байна.

Яргай загасны үнэ түүний өндөр эрэлт болон нийлүүлэлтийн хомсдолоос шалтгаалан 21.0 хувиар өсөв.

Харин Европын орнуудад цаг агаар дулаан байснаас гадил жимсний нийлүүлэлт эрэлтээ давж, Европын захуудад гадилын үнэ 43.0 хувиар буурчээ. 2005 оны эхний 8 сарын байдлаар хөдөө аж ахуйн түүхий эд материалын үнэ тэдгээрийн нийлүүлэлтийн илүүдлээс шалтгаалан 1.0 хувиар багасав. Ургац нэмэгдсэн нь зөөлөн модон эдлэлийн

үнийг 2005 оны эхний 8 сарын байдлаар 14.0 хувиар буурахад нөлөөлсөн бөгөөд энэ нь 2004 онд 15.0 хувиар өсч байсан байна.

Хятад дахь хөвөнгийн эрэлт их байснаас хөвөнгийн үнэ 5.0 хувиар нэмэгджээ. Газрын тосны өндөр үнэ синтетик каучукийн үнийг өсгөсөн ба байгалийн каучукийн орлуулалтын хязгаарлалт түр зуурын нийлүүлэлтийн саатлыг бий болгож, энэ нь каучукийн үнэ оны эхнээс 35.0 хувиар нэмэгдэхэд хүргэв.

Дэлхийн эдийн засгийн хүчтэй өсөлт түүхий эд, материалын эрэлтийг нэмэгдүүлэх хандлагатай байна. Иймээс хөдөө аж ахуйн түүхий эд, материал, ялангуяа модны үнийн өсөлтийг хязгаарлах нь зүйтэй байна.

АНУ-ын өмнөд мужийн далайн боомт, хотуудыг сүйтгэсэн “Катрин” хар салхи түлш шатахуунаас бусад барааны захуудыг түр зуур хаахад хүргэж, тээврийн саатлыг бий болгож байв. Энэ нь АНУ-ын шар буурцаг, улаан буудай, үр тарианы экспортыг буурууллаа. Мөн “Катрин” хар шуурга Миссисипи мужаас Жоржиа муж хүртэлх хөвөнгийн талбайг сүйтгэсэн байна.

Кофе хураалт болон цинк гэх зэрэг гол металлын олборлолтын нөхцөл тодорхой бус хэвээрээ байлаа. Модон материалын үнэ сүйдсэн бүс нутгуудын сэргээн засварлах үйл ажиллагааны улмаас өссөн байна.

2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2.1. Ерөнхий тойм

Сүүлийн жилүүдэд макро эдийн засгийн орчин харьцангуй тогтвортой байж 2005 онд эдийн засгийн бодит өсөлт урьдчилсан байдлаар жилийн 6.2 хувьд хүрлээ. Шатахуун, цахилгаан, дулааны эрчим хүч, хүнсний чиглэлийн өргөн хэрэглээний зарим барааны үнэ өссөн ч жилийн инфляци нэг оронтой тоонд багтан 9.5 хувь болов. Монголбанк ОХУ-д их өрийг төлөхөөс өмнөх үеийн хэмжээнд улсын гадаад валютын нөөцийг хүргэв. Үүнээс гадна улсын төсөв анх удаа ашигтай гарлаа. Энэ бүх өөрчлөлтүүд эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна.

Тайлант онд дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6.2 хувиар өссөн нь өмнөх оныхоос бага боловч сүүлийн 5 жилийн дундаж өсөлтөөс 2.0 орчим нэгжээр илүү байна. Энэхүү өсөлтөд уул уурхай, олборлох үйлдвэрлэл болон хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ, тээвэр агуулахын аж ахуйн салбарын өсөлт голлон нөлөөлжээ. Түүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд банк санхүүгийн үйлчилгээ, барилгын салбар тогтмол өсч байгаа нь зохих хувь нэмрээ оруулж байна. Харин боловсруулах үйлдвэрлэл 24.1 хувиар буурч, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүллээ. Үүнд, хувцас үйлдвэрлэл 66.1 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 40.4 хувиар тус тус багассан байна.

Аж үйлдвэрийн салбарт уул уурхай, олборлох үйлдвэрийн эзлэх хувийн жин хамгийн өндөр тул салбарын нийт дүнд үзүүлэх нөлөө нь их байна. Мөн үүнтэй адилаар металлын хүдэр олборлолт нь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн ихэнх хувийг эзэлдэг тул түүний өөрчлөлт уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн хэмжээнд жинтэй нөлөө үзүүлдэг. Уул уурхай, олборлох үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2004 онтой харьцуулахад 11.3 хувь, үүнээс металлын хүдэр олборлолт 11.1 хувиар нэмэгджээ.

Алтны олборлолт нэмэгдсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 25.4 хувиар өссөн байна. Уул уурхайн салбарт дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт эрчимжсэн нь шинээр хүчин чадал нэмэгдэж тус салбарын үйлдвэрлэл өсөхөд нөлөөлжээ. 2005 онд “Олон овоот”-ын алтны үйлдвэрийн өргөтгөл, Тавтын алтны үйлдвэр ашиглалтанд орсон бөгөөд 2004 онд үйл ажиллагаагаа эхэлсэн Бороогийн алтны үйлдвэрийн олборлолт ч нэмэгдсэн байна. Мөн дотоодын нийт бүтээгдэхүүний 20 гаруй хувийг (сүүлийн 10 жилийн дунджаар 30 хувь) бүрдүүлдэг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарын үйлдвэрлэл 7.7 хувиар нэмэгджээ. 2005 оны жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан дүнгээр малын тоо 30.4 сая толгойд хүрсэн нь өнгөрсөн оны дүнгээс 8.5 хувиар их байна.

Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний олон талт хэлэлцээр 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр дуусгавар болсон нь хувцас үйлдвэрлэл буурахад хүргэв. Харин Монгол улс Европын Холбооны хөнгөлөлтийн системд (GSP⁺) хамрагдаж 7200 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг 25 орны зах зээлд татвар болон тоо хэмжээний хязгаарлалтгүй нийлүүлэх боломжтой болсон. Үүнээс гадна сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор татвар, нийгмийн даатгалын шимтгэлд зохих өөрчлөлт оруулж, Засгийн газраас тус салбарын үйлдвэрүүдэд тодорхой дэмжлэг үзүүлснээр хувцас үйлдвэрлэлийн уналтыг зогсоох нөхцөлийг бүрдүүлж өглөө.

2004 онд жилийн 11.0 хувьд хүрсэн инфляци бага зэрэг буурч 2005 онд жилийн 9.5 хувь боллоо. Дэлхийн зах зээл дээр нефтийн үнэ ерөнхийдөө өндөр хэвээр байсан, шатахуун нийлүүлэгч гол түнш Орос улсын экспортын татвар нэмэгдсэн зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан түлш шатахууны дотоодын үнэ өсөв. Үүнийг дагаад зарим хэрэглээний бараа бүтээгдэхүүн, ялангуяа мах махан бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн нь инфляци өсөхөд хүргэлээ. Тайлант онд А-76 бензиний дундаж үнэ өмнөх оны дундаж үнээс 27.9 хувь, А-93 бензинийх 30.2 хувиар тус тус нэмэгдлээ. 2005 оны 6 дугаар сард А-76 бензиний үнэ 650 төгрөгөөс 730 төгрөг хүртэл өсч үлдсэн саруудад харьцангуй тогтвортой байлаа. Харин 12 дугаар сард 0.8 хувиар нэмэгдэж 736 төгрөг болсон байна. А-93 бензиний үнэ 5 дугаар сард 730 төгрөгөөс 790 төгрөг болсны дараа долоон сарын хугацаанд өөрчлөгдөөгүй байснаа 12 дугаар сард 1.3 хувиар өсч 800 төгрөг болжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд хамгийн их хувийн жин эзэлдэг хүнсний барааны бүлгийн жилийн өөрчлөлт 15.6 хувь байсан нь хэрэглээний үнийн индекс жилдээ 9.5 хувиар өсөхөд нөлөөлсөн байна. Харин хэрэглээний үнийн индексээс мах, сүү, хүнсний ногооны төрлийн 28 барааг хасаж тооцсон суурь инфляцийн жилийн өсөлт 3.5 хувьтай байна. Тайлант онд мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ хамгийн их буюу 32.2 хувиар өсчээ. Инфляцийг тогтвортой бага хэмжээнд байлгахын тулд хэрэглээний үнийн индекст нөлөөтэй мах, шатахууны нийлүүлэлтийн хүчин зүйлсийг зохицуулах бололцоо төрд байгаа хэмээн Монголбанк үздэг. Тухайлбал мах, махан бүтээгдэхүүн бэлтгэх, нөөцлөх ажлыг цаг алдалгүй зохион байгуулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх, Монголд нефть нийлүүлдэг эх сурвалжийн монополь байдлыг халах, нефтийн үнэ огцом дээш цогих үед онцгой албан татварт нь уян хатан хандах зэрэг арга хэмжээг төрийн байгууллагын зүгээс хэрэгжүүлэх нь зүйтэй. Засгийн газраас тус асуудалд анхаарлаа хандуулан зохих арга хэмжээ авч эхэлсэн нь сайшаалтай. Тухайлбал, Улаанбаатар хотын хэмжээнд махны үнийг тогтвортой байлгахын тулд махны нөөц бүрдүүлж борлуулсан аж ахуйн нэгжийг урамшуулах болсон байна.

Тайлант онд улсын төсөв анх удаа 83.0 тэрбум төгрөгийн ашигтай гарч, төсвийн урсгал орлого урсгал зардлаас 240.2 тэрбум төгрөгөөр давлаа. Төсвийн нийт болон урсгал тэнцэл ашигтай гарсанд Эрдэнэт УҮГ өмнөх онуудын ногдол ашгаа төсөвт шилжүүлсэн, дэлхийн зах зээл дээрх алт зэсийн үнэ өндөр байсан, төсвийн зарцуулалтыг хянаж, зөв удирдсан зэрэг явдал нөлөөлжээ. Харин алт, зэсийн дэлхийн үнийн тааламжтай байдлыг ашиглан Засгийн газраас Монголбанкинд төлөх өглөгийг барагдуулах, үлдэх экспортын орлогыг тогтворжилтын санд хадгалуулах нь алт, зэсийн үнэ унах тэр үед Монгол улсад ач тустай. Түр хугацааны экспортын нэмэлт орлогыг цалин тэтгэврийн огцом нэмэлтэд бүгдийг нь тарамдуулбал сүүлд үнэ ханш буух үед улс төрийн сөрөг үр дагавартай байж болно.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн цагт 251 төгрөг 48 мөнгө буюу сард 42500 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2005 оны эцсийн байдлаар 32.9 мянга болж, 2004 оныхоос 2.6 мянган хүн буюу 7.4 хувиар буурав. Мөн улсын хэмжээнд 53.1 мянган ажлын байр шинээр бий болгожээ.

2005 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт экспорт 1053.7 сая, нийт импорт 1148.7 сая ам. доллар болж, гадаад худалдааны алдагдал 95.0 сая ам. доллартай тэнцэв. Гадаад худалдааны алдагдал 2004 оныхоос 56.4 сая ам. доллар буюу 37.3 хувиар буурч дотоодын нийт бүтээгдэхүүний 5.1 хувийг эзэлж байна. Манай орны экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний экспорт (42.3 хувь) жилийн хугацаанд 96.2 сая ам. доллар буюу 27.2 хувь, үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн экспорт (31.2 хувь) 88.3 сая ам. доллар буюу 26.6 хувиар тус тус нэмэгдэж нийт экспорт өсөхөд хүргэсэн байна. Өөрөөр хэлбэл, манай орны экспортын гол бараа бүтээгдэхүүн болох алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнэ өссөн нь нийт экспортын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлөв. Харин нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт нийт импортын хэмжээнд нөлөөлсөн бөгөөд нийт импорт өмнөх онтой харьцуулахад 127.5 сая ам. доллар буюу 12.5 хувь, үүнд нефтийн бүтээгдэхүүний импорт 75.6 сая ам. доллар буюу 36.6 хувиар тус тус өсчээ. 2004 онд нефтийн бүтээгдэхүүний импорт нийт импортын хэмжээнд 20.2 хувь эзэлж байсан бол 2005 онд 24.5 хувь болж 4.3 нэгжээр нэмэгджээ. Нефтийн бүтээгдэхүүний 88.3 хувийг ОХУ-аас импортолсон байна. Казахстан, Хятадаас импортоор оруулсан нефтийн бүтээгдэхүүн 118.3 хувь болон 63.6 хувиар тус тус өссөн нь нефть нийлүүлэх зах зээлийг өргөтгөсөн байна.

Гадаад цэвэр албан нөөц 298.0 сая ам. доллар болсон нь 2004 оны эцсийн үзүүлэлтээс 134.4 сая ам. доллар буюу 82.1 хувь, их өр төлсөн 2003 оныхоос 169.0 сая ам. доллар буюу 131.0 хувиар тус тус нэмэгджээ. Монголбанк их өрийг Монгол улс ОХУ-д 2003 оны 12 дугаар сард төлж байсан үеийн хэмжээнд Монгол улсын гадаад валютын нөөцийг 2 жилийн хугацаанд эргэн хуримтлуулсан нь улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг бататгах нэг том алхам боллоо.

Төгрөгийн америк доллартай харьцах нэрлэсэн ханш өнгөрсөн оны эцсээс 1.0 хувиар суларсан бөгөөд оны туршид дунджаар 1 төгрөг буюу 0.1 хувиар суларч байсан нь өмнөх оныхтой харьцуулахад тогтвортой байв.

Аж үйлдвэр

Тайлант онд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2000 оны зэрэгцүүлсэн үнээр 813.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 35.6 тэрбум төгрөг буюу 4.2 хувиар буурав. Уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 11.3 хувь, цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, усан хангамж 4.3 хувиар тус тус нэмэгдэж, харин боловсруулах аж үйлдвэр 23.9 хувиар багассан байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын гол үйлдвэрлэлийн өөрчлөлтийг авч үзвэл хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл 1.3 хувь, төмрийн үйлдвэрлэл 31.3 хувиар тус тус өссөн бол нэхмэлийн үйлдвэрлэл 40.4 хувь, хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт 66.1 хувиар тус бүр буурчээ. Нэхмэл болон хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалтын дэд салбарын үйлдвэрлэлийн бууралт нь гадаадын хөрөнгө оруулалттай зарим үйлдвэр үйл ажиллагаагаа зогсоосонтой холбоотой.

Статистикийн мэдээлэлд хамрагддаг 118 гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, 98 гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан байна. Тухайлбал, цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч, нүүрс, молибдений баяжмал (47 хувийн агуулгатай), алт, катодын зэс (99 хувь), металл бэлдэц, металл цувимал, самнасан ноолуур, цемент, хиаман бүтээгдэхүүн, гурил, нарийн боов, амтат ус, ундаа, спирт зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн байна. Харин газрын тос, төмрийн хүдэр, зэсийн баяжмал (35 хувийн агуулгатай), хайлуур жоншны баяжмал, сүлжмэл эдлэл, хивс, тэмээний ноосон хөнжил, зүсмэл материал, шохой, сонин, мах, талх, гоймон, архи, дарс зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл багасчээ.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт оны үнээр 1463.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс 773.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд нийлүүлжээ. Уул уурхай, олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын 69.9 хувь, боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын 33.0 хувь нь гадаадын зах зээлд ногдож байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалтын дүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт 66.4 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 19.5 хувь, цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, усан хангамж 14.1 хувийг тус тус эзэлж байна. Мөн аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалтын 54.1 хувь нь Улаанбаатар хот, 32.8 хувь нь Орхон аймагт тус тус ногдож байна.

Хөдөө аж ахуй

Мал тооллогын 2005 оны урьдчилсан дүнгээр нийт 30.4 сая мал, үүний дотор 254.2 мянган тэмээ, 2.0 сая адуу, 2.0 сая үхэр, 12.9 сая хонь, 13.3 сая ямаа тоологдсон нь өмнөх оныхоос 2.4 сая толгой буюу 8.5 хувиар өссөн байна. Малын тоо, толгойн өсөлтийг төрлөөр нь авч үзвэл адуу 23.8 мянга, үхэр 122.0 мянга, хонь 1.2 сая, ямаа 1.0 сая толгойгоор тус тус өсч, харин тэмээ 2.4 мянган толгойгоор буурчээ. Малын тоо толгойн өсөлт үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан байна.

Урьдчилсан дүнгээр нийт 19 аймаг малаа 17.8-294.7 мянган толгой буюу 2.7-20.4 хувиар өсгөсөн бөгөөд Хөвсгөл (2504.3 мянга), Өвөрхангай (2301.2 мянга), Архангай (2194.9 мянга), Завхан (2102.1 мянга), Увс (2021.3 мянга) аймгууд малын тоогоороо тэргүүлжээ. Харин Сүхбаатар, Дорноговь, Баян-Өлгий аймгуудад малын тоо өмнөх оныхоос 26.2-56.9 мянган толгой буюу 1.9-4.7 хувиар буурсан байна.

2005 онд 9.9 сая эх мал буюу эх малын 85.0 хувь төллөжээ. Өнгөрсөн оныхоос төллөлтийн хувь 2.5 нэгжээр буурсан байна. Нийт 9.3 сая төл буюу гарсан төлийн 94.1 хувь бойжсон нь өмнөх оныхоос 36.8 мянган толгойгоор сайжирсан үзүүлэлт юм.

Улсын хэмжээгээр 677.2 мянган том мал зүй бусаар хорогдсон нь 2004 оныхоос 385.5 мянган толгойгоор их байна. 2005 оны эхэнд зарим нутгаар цаг агаарын байдал хүндрэлтэй байснаас малын хорогдол ихэсчээ. Тус шалтгаанаар хорогдсон малын тоо нийт хорогдлын 67.4 хувь, харин өвчнөөр хорогдсон малын тоо 11.2 хувийг эзэлж байна.

Тайлант онд 75.2 мянган тонн үр тариа, 82.7 мянган тонн төмс, 64.0 мянган тонн хүнсний ногоо хураасан нь 2004 оныхоос үр тариа 63.3 мянган тонн буюу 45.7 хувиар бага байхад хүнсний ногоо 14.9 мянган тонн буюу 30.2 хувь, төмс 2.6 мянган тонн буюу 3.2 хувиар илүү байна.

Хураасан үр тарианы 41.1 хувь нь Сэлэнгэ аймагт, 17.8 хувь нь Булган аймагт, 10.8 хувь нь Хэнтий аймагт, төмсний 26.8 хувь нь Төв аймагт, 20.1 хувь нь Сэлэнгэ аймагт, 8.5 хувь нь Ховд аймагт, 7.1 хувь нь Булган аймагт тус тус ногдож байна. Хүнсний ногооны 24.3 хувийг Сэлэнгэ аймаг, 18.6 хувийг Дархан-Уул аймаг, 16.3 хувийг Төв аймаг, 14.7 хувийг Ховд аймаг хураан авсан байна.

Нэг га-гаас дунджаар 4.7 центнер үр тариа, 84.8 центнер төмс хураасан нь 2004 оныхоос үр тариа 3.3 центнер, төмс 3.5 центнерээр тус тус бага байна.

Тайлант онд 830.7 мянган тонн өвс хадлан, 26.5 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь өмнөх оныхоос өвс хадлан 19.8 мянган тонн буюу 2.3 хувь, гар тэжээл 3.9 мянган тонн буюу 12.9 хувиар буурчээ.

2005 онд нийт 189.5 мянган га талбайд тариалалт хийсэн нь 2004 оныхоос 10.9 мянган га буюу 5.5 хувиар бага бөгөөд энэ нь үр тариалалт эхлэх үед цаг агаарын байдал хүйтэн байсан, үр тарианы үрийг улсаас зээлээр олгоогүй, тариалалтын зардал нэмэгдсэнтэй холбоотой.

Үр тарианы хураасан ургацын хэмжээ буурсан нь үр тарианы дийлэнх хувийг эзэлдэг буудайн ургац бүрэлдэх үед нарны хэт их халалт, хуурайшилт явагдаж ургацын чанар хэмжээнд нөлөөлснөөс шалтгаалжээ. Үүнээс гадна тус салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн дутагдал болон боловсон хүчний хүрэлцээ, чанарын түвшин ургацын бууралтад нөлөөлсөн байна.

Барилга

Тайлант онд урьдчилсан байдлаар оны үнээр нийт 175.9 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэж, 50.1 тэрбум төгрөгийн үндсэн фонд бүхий барилга объектыг ашиглалтад оруулжээ. Гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2004 онтой харьцуулснаар 8.9 хувиар өссөн байна.

2005 онд нийт 144 барилга ашиглалтад оруулснаас орон сууцны зориулалттай 227 мянган ам метр талбай бүхий 2.7 мянган айлын 81 барилга, худалдаа үйлчилгээний зориулалттай 46.4 мянган ам метр талбай бүхий 23 барилга, зочид буудал, зоогийн

газрын зориулалттай 1.6 мянган ам метр талбай бүхий 6 барилга, үйлдвэрлэлийн зориулалттай 3.0 мянган ам метр талбай бүхий 3 барилга тус тус ашиглалтад өгчээ.

Авто замын салбарт 22.0 тэрбум төгрөгийн өртөгтэй 389.4 километр хатуу хучилттай зам улсын төсвийн санхүүжилтээр, 3.2 тэрбум төгрөгийн өртөгтэй 746.9 километр хайрган хучилттай зам гадаадын хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулсан байна.

Тээвэр, холбоо

Бүх төрлийн тээврийн хэрэгслээр 25.2 сая тонн ачаа, давхардсан тоогоор 192.7 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхоос ачаа тээвэрлэлт 3.6 сая тонн буюу 16.7 хувиар өсч, харин зорчигч тээвэрлэлт 1.5 сая хүн буюу 0.8 хувиар буурсан байна.

Тээврийн салбараас олсон нийт орлого 327.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 34.2 хувиар өсчээ. Үүнд төмөр замын тээврийн орлого 43.4 хувь, агаарын тээврийн орлого 10.5 хувь, авто тээврийн орлого 0.3 хувиар тус тус нэмэгджээ.

Төмөр замын ачаа тээвэрлэлт 11.1 хувиар өсч, зорчигч тээвэрлэлт 2.3 хувиар буурсан байна. Харин 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс төмөр замаар зорчих тасалбарын үнэ өссөн, ачаа тээвэрлэлт 1.5 сая тонноор нэмэгдсэн нь орлогын дүн өсөхөд нөлөөлөв.

Авто тээврээр ачаа тээвэрлэлт 27.2 хувиар нэмэгдсэн бол зорчигч тээвэрлэлт 0.7 хувиар багасчээ. Авто техникийн 2005 оны үзлэг, тооллогоор 131.2 мянган авто машин тоологдсон нь өмнөх оныхоос 10.8 мянга буюу 8.9 хувиар нэмэгджээ. Нийт авто машины 77.4 хувийг хувийн машин эзэлж байгаа нь 2004 оныхоос 2.4 нэгжээр илүү байна.

Тайлант онд орон нутгийн нислэгийн тоо буурснаас агаарын тээврийн ачаа тээвэрлэлт 11.5 хувь болон зорчигч тээвэрлэлт 6.6 хувиар тус тус багасчээ.

Холбоо ашиглалтын нийт орлого 2005 онд 128.4 тэрбум төгрөгт хүрсний 97.1 тэрбум төгрөг буюу 75.6 хувь нь хүн амаас орсон орлого байв. Холбооны салбарын нийт орлогын 88.6 хувь, хүн амаас орсон нийт орлогын 90.9 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Суурин телефон цэгийн тоо 159.3 мянга, үүрэн телефон хэрэглэгчийн тоо 570.9 мянга, утасгүй телефоны тоо 23.0 мянгад хүрч өмнөх оныхоос суурин телефон цэгийн тоо 4.4 хувь, үүрэн телефон хэрэглэгчийн тоо 28.3 хувь, утасгүй телефоны тоо 9.1 хувиар тус тус нэмэгджээ.

“Цахим Монгол” болон “Бүх нийтийн компьютержүүлэлт” зэрэг хөтөлбөр хэрэгжиж, баруун чиглэлийн дамжуулах шугамыг шилэн кабелиар сольж, утасгүй интернетийн технологи нэвтрүүлсэн нь холбооны салбарын хөгжлийг хурдасгалаа.

2.2. Засгийн газрын санхүү

Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах, төсөв санхүүгийн дунд хугацааны шинэчлэлийг гүнзгийрүүлэх замаар төсөв санхүүгийн тогтолцоонд сүүлийн жилүүдэд бий болсон нааштай өөрчлөлтүүдийг бататган нэгдсэн төсвийн алдагдлыг бууруулах,

Засгийн газрын өрийн түвшинг багасгах, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулахад Монгол улсын төсвийн үндсэн бодлого чиглэгджээ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд төсвийг төлөвлөх, түүний хэрэгжилт үр дүнгийн төлөө төсвийн ерөнхийлөн захирагчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг санхүүгийн болон татварын бодлогоор дэмжих ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд Монгол улсын төсвийн тогтвортой байдал хангагдаж, төсвийн алдагдал сүүлийн 3 жилд эрчимтэй буурав.

Монгол улсын нэгдсэн төсвийн орлого 2005 оны урьдчилсан гүйцэтгэлээр 833.3 тэрбум төгрөг (ДНБ-ий 36.8 хувь), зарлага 750.3 тэрбум төгрөг (ДНБ-ий 33.1 хувь) болж нийт тэнцэл 83.0 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 3.7 хувь), урсгал тэнцэл 240.2 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 10.6 хувь) ашигтай гарсан байна.

Монгол улсын нэгдсэн төсөв анх удаа ашигтай гарсан нь Эрдэнэт УУГ-аас 2005 оны 2 дугаар улиралд хоёр орны хамтарсан төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу өмнөх онуудын ногдол ашгийг хуваарилсан, тайлант онд зэс, алт зэрэг манай гол экспортын бараа бүтээгдэхүүний үнэ ханш дэлхийн зах зээл дээр өндөр байсан зэргээс шалтгаалан орлогын албан татварын төлөвлөгөө 42.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн, мөн урсгал зардлын гүйцэтгэл 95.8 хувь буюу 33.9 тэрбум төгрөгийн хэмнэлттэй гарсантай холбоотой юм. Мөн дотооддоо төсвийн бүрдүүлэлт сайжирсан, санхүүгийн шинэ программ (Free balance) нэвтрүүлж хэрэгжүүлснээр төсвийн хяналт сайжирч энэ нь орлого нэмэгдэхэд бас нөлөөлжээ.

Хүснэгт Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Төсвийн орлого

Төсвийн нийт орлого 2005 онд 833.3 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн хэмжээнээс 12.4 хувь буюу 92.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс 19.5 хувь буюу 135.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

Төсвийн нийт орлогын 99.5 (829.2 тэрбум төгрөг) хувийг урсгал орлого, 0.4 (3.0 тэрбум төгрөг) хувийг тусламжийн орлого, 0.1 (1.1 тэрбум төгрөг) хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Эдгээр үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулан үзвэл, урсгал орлогын нийт орлогод эзлэх хувь 0.5 нэгжээр өсч, тусламжийн орлого 0.5 нэгжээр буурч, хөрөнгийн орлого өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй ойролцоо түвшинд байна.

Төсвийн нийт орлогын голлох хэсэг буюу 99.5 хувийг эзэлж буй урсгал орлогын дотор татварын орлого 12.3 хувь буюу 75.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Үүнээс: Орлогын албан татвар 29.4 хувь буюу 40.3 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлого 8.7 хувь буюу 7.5 тэрбум төгрөг, гадаад худалдааны орлого 24.5 хувь буюу 11.2 тэрбум төгрөгөөр тус тус давсан боловч өмчийн татвар 3.1 хувь буюу 0.2 тэрбум төгрөг, дотоодын бараа, үйлчилгээний татвар 2.6 хувь буюу 7.2 тэрбум төгрөгөөр тус тус тасарчээ.

Дотоодын бараа, үйлчилгээний албан татварын төлөвлөгөө урьдчилсан гүйцэтгэлээр дутуу биелсэн нь нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын буцаан олголтыг

төлөвлөгөөнөөс 12.2 тэрбум төгрөгөөр илүү санхүүжүүлсэнтэй холбоотой юм. НӨАТ өссөн дүнгээр 7.6 тэрбум төгрөгөөр давж биелснээс дотоодын бараа үйлчилгээний НӨАТ 11.0 тэрбум төгрөг, импортын барааны НӨАТ 8.8 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Тайлант онд онцгой албан татвар өссөн дүнгээр 85.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 13.0 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ. Энэ нь дотоодын болон импортын архи, шар айрагны онцгой албан татвар ногдох биет хэмжээ буурсан, мөн оны эхэнд төсөв батлахдаа татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхээр тусгасан зэргээс шалтгаалсан байна.

Тусгай зориулалтын орлого өссөн дүнгээр 85.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 1.8 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Энэ нь дэлхийн зах зээл дээр нефтийн үнэ өссөнтэй холбоотойгоор импортоор орж ирэх автобензин, дизель, түлшний биет хэмжээ буурсантай холбоотой юм.

Татварын бус орлогын гүйцэтгэл 2005 онд өссөн дүнгээр 12.2 хувь буюу 15.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Үүний 19.1 тэрбум төгрөг нь улсын үйлдвэрийн газраас төлсөн өмнөх оны ногдол ашгийн төлбөр бөгөөд Эрдэнэт УҮГ 2003 оны ногдол ашигт 14.4 тэрбум төгрөгийг төлсөнтэй холбоотой юм. Мөн хүү торгуулийн орлого өссөн дүнгээр 29.8 хувь буюу 3.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүний орлогын төлөвлөгөө 2.2 тэрбум төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого 95.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 3.0 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн зарлага

Төсвийн зарлага тайлант онд 750.3 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн хэмжээнээс 7.0 хувь буюу 56.5 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 5.1 хувь буюу 36.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Төсвийн зарлагын өсөлт (5.1 хувь)-ийг орлогын өсөлт (19.5 хувь)-тэй зэрэгцүүлж үзвэл орлогын өсөлт зарлагынхаас 99.5 тэрбум төгрөг буюу 14.4 нэгжээр илүү байна.

Тайлант онд төсвийн зарлагын төлөвлөгдсөн хэмжээ нь бараа, үйлчилгээний зардал, татаас ба урсгал шилжүүлгийн зардалаас бусад бүх ангиллаар хэмнэгдсэний дотор урсгал зардал 0.2 хувь буюу 1.3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 13.2 хувь буюу 13.0 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээл 35.8 хувь буюу 42.3 тэрбум төгрөгөөр тус тус хэмнэгджээ.

Төсвийн зарлагын голлох хэсгийг эзэлдэг урсгал зарлага 1.3 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн нь түүнийг бүрдүүлэгч зардал болох зээлийн үйлчилгээний төлбөр 7.9 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Харин бараа, үйлчилгээний зардал 5.1 тэрбум төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 1.5 тэрбум төгрөгөөр гүйцэтгэл нь илүү гарсан байна.

Төсвийн зарлагын 78.5 хувийг урсгал зардал, 11.4 хувийг хөрөнгийн зардал, 10.1 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байгаа бөгөөд төсвийн зарлагын голлох хэсгийг (78.5 хувь) эзэлж буй урсгал зардалд бараа, үйлчилгээний зарлага 63.7 хувийг, татаас ба урсгал шилжүүлэг 32.8 хувийг, зээлийн үйлчилгээний зардал 3.5 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зарлагад эзлэх урсгал зардалын

хувь 4.8 нэгжээр өсч, хөрөнгийн зардал 2.9 нэгж, эргэж төлөгдөх цэвэр зээл 1.9 нэгжээр буурчээ.

Урсгал зардлын дүнд эзлэх зээлийн үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеийнхээс 0.7 нэгж, бараа, үйлчилгээний зардлынх 1.9 нэгжээр тус тус буурч, харин татаас ба урсгал шилжүүлгийн зардал 2.6 нэгжээр өссөн байна.

Орон нутгийн төсөв

Урьдчилсан гүйцэтгэлээр 2005 онд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 12.9 хувь буюу 8.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн ба зарлага нь төлөвлөсөн хэмжээнээс 9.2 хувь буюу 6.7 тэрбум төгрөгөөр илүү санхүүжигдсэн байна.

Тайлант онд бүх аймгууд орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн бөгөөд Дундговь, Төв, Увс, Сүхбаатар зэрэг аймгууд төсвийн орлогын төлөвлөгөөг хамгийн их буюу 20.3-39.4 хувиар давуулан биелүүлжээ.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 6.4 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн хэмжээнээс 6.9 хувь буюу 0.4 тэрбум төгрөгөөр илүү байна. Энэ нь орон нутагт түлш халаалт, цэвэр бохир усны үнийн өсөлттэй холбоотойгоор үүссэн орон нутгийн төсвийн байгууллагуудын өрийг барагдуулах зорилгоор 409.2 сая төгрөгийн санхүүжилт нэмж олгосонтой холбоотой юм.

Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд 100.0 хувь буюу 23.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.3. Төлбөрийн тэнцэл

Гадаад орчин

Дэлхийн нефтийн зах зээл

Дэлхий дахинд тохиолдож буй байгалийн гамшиг, Ирак, Иран болон Венесуэль зэрэг томоохон нефть нийлүүлэгчдийг тойрсон улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал дэлхийн нефтийн үнийг огцом өсгөж дэлхийн эдийн засаг ялангуяа, хөгжиж буй орнуудын эдийн засгийн тогтвортой өсөлтөд ихээхэн бэрхшээл учруулж байлаа. “Катрин” далайн хар салхи АНУ-ын нефть боловсруулах хүчин чадал төвлөрсөн газар нутгаар дайран өнгөрч асар их хэмжээний хохирол учруулан нефтийн үнийг огцом өсгөсөн байна. Тухайлбал, нэг баррель нефтийн үнэ сүүлийн 25 жилийн хамгийн дээд хэмжээнд буюу 71.0 ам. долларт хүрээд буурсан байна.

Зураг Дэлхийн нефтийн хэрэгцээ (Сүүлийн 5-н жилийн байдлаар)

Дэлхийн нефтийн өдрийн хэрэглээний 40.0 гаруй хувийг нийлүүлдэг ОПЕК-ийн орнууд 2004 оны байдлаар өдөрт 23.5 сая баррель нефть олборлодог байсан бол 2005 онд нефтийн зах зээлийн байдлыг харгалзан үзэж өдөрт 28.0 сая баррелийг олборлодог болов.

ОПЕК-ийн гишүүн бус нефть экспортлогч орнууд мөн өөрсдийн хүчин чадлын дээд хэмжээнд хүрээд байгаа бөгөөд зарим нийлүүлэгч орны жишээлбэл, Норвегийн

олборлох хэмжээ бүр багассан байна. Нефтийн зах зээл дээр багагүй хувийн жин эзэлдэг Нигер, Венесуэль, Ирак зэрэг улсуудын улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал нь дэлхийн нефтийн зах зээлийн үнэд мөн нөлөөлж байна.

Дэлхийн нефтийн зах зээл дээр илүүдэл нефть гэсэн ойлголт байхгүй болсон учир нефть, нефтийн бүтээгдэхүүний үнэ ойрын хугацаанд өсөх хандлагатай байна.

Түүхий эдийн зах зээл

АНУ-ын эдийн засгийн өсөлт, Японы эдийн засгийн сэргэлт, БНХАУ, Энэтхэг, Бразиль болон Азийн орнуудын эдийн засгийн хурдацтай хөгжил нь дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн хэрэгцээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үнийг нь өсгөсөөр байна.

Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ өсч байгаа нь зөвхөн эрэлт хэрэгцээнээс хамаарахаас гадна инфляци, ханшийн тогтворгүй байдал улмаар дэлхийн хэмжээнд алтны олборлолт буурч байгаатай холбоотой юм. Алт олборлолтоор дэлхийд тэргүүн байр эзэлдэг Өмнөд Африк улсын хэд хэдэн уурхай хаагдаж тус улсын олборлолтын хэмжээ 15.0 хувиар буурчээ.

2005 оны эхний хагаст зэс үйлдвэрлэгчид 8.05 сая тонн цэвэршүүлсэн зэс дэлхийн зах зээлд нийлүүлсэн боловч нийт хэрэгцээ 8.27 сая тонн байсан тул зах зээл дээр 219.0 мянган тонн зэс дутагдсан байна. Харин 2004 оны эхний хагаст дэлхийн зах зээл дээр цэвэршүүлсэн зэсийн хэрэгцээ нийлүүлэлтээсээ 790.0 мянган тонноор давж байжээ.

Зураг Зэсийн экспорт

Томоохон улсуудын эдийн засгийн өсөлтийг дагаад зэсийн хэрэгцээ нэмэгдсэн хэвээр байна. Сүүлийн жилүүдэд зэс олборлох хэмжээ нэмэгдсэн хэрнээ зах зээлийн нийт хэрэгцээг хангахуйц хэмжээнд өсч чадахгүй байгаа тул зэсийн үнэ өндөр хэвээр байна.

Ноолуурын хувьд 2000 онд бэлтгэн нийлүүлэгчид нийт 15.8 мянган тонн ноолуур бэлтгэсний 11.1 мянган тонн буюу 70.0 хувийг БНХАУ дангаараа нийлүүлжээ.

2005 оноос эхлэн олон улсын гадаад худалдааг чөлөөлөх ажлын хүрээнд дэлхийн томоохон зах зээлүүд БНХАУ-аас гаралтай оёмол, сүлжмэлийн бүтээгдэхүүнд ногдуулж байсан квотын системийг халав. Энэхүү үйл явдлыг БНХАУ баяртайгаар хүлээн авч өөрсдийн экспортыг нэмэгдүүлэх, дэлхийд ноолууран бүтээгдэхүүн нийлүүлэлтээр тэргүүлэх зорилго тавин эрчимтэй ажиллаж байна.

Нэг талаас олон улсын хэмжээнд ийнхүү квотын системийг халсан явдал нь Монголын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд таагүй байсан ч нөгөө талаас Европын холбооны зүгээс манай улсыг хөнгөлөлттэй тарифаар үйлчлэх улс орнуудын тоонд оруулсан нь манай улсын ноолуурын салбарт таатай орчныг бүрдүүлж өгч байна.

Гадаад худалдааны индекс

Манай улсын экспорт болон импортын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа нь эдийн засаг тэлж, дотоодын бизнесийн орчин таатай байгааг илтгэж байна.

Тайлант оны эцэст манай улсын экспортын индекс суурь 2000 онтой харьцуулахад 149.0 хувь, импортын индекс 139.0 хувьд тус тус хүрэв. Энэ нь өнгөрсөн оныхоос экспортын индекс 20.0 нэгж, импортын индекс 14.0 нэгжээр тус тус өссөн үзүүлэлт байна.

Экспортын индексийн өсөлтөд экспортын гол бараа бүтээгдэхүүн болох алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, импортын индексийн өсөлтөд нефтийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт гол нөлөөг үзүүлжээ. Манай улсын импортын 24.5 хувийг эзэлж байгаа нефтийн бараа бүтээгдэхүүний импорт 2005 онд 36.6 хувиар нэмэгдсэн байна.

Зураг Экспортын индекс /хувиар

Зураг Импортын индекс /хувиар

2005 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын импорт 1.1 тэрбум ам. доллар, экспорт анх удаа 1.0 тэрбум ам. долларыг давж, импортыг экспортоор нөхөх коэффициент 91.73 хувьд хүрэв. Энэ нь өнгөрсөн 6 жилийн турш дахь хамгийн өндөр түвшин юм.

Зураг Экспорт, импортын хэмжээ

Зураг Импортыг Экспортоор нөхөхкоэффициент

Тайлант онд гадаад худалдааны индекс суурь 2000 онтой харьцуулахад 7.0 хувиар өссөн бол өмнөх оныхоос 7.0 нэгжээр буурсан байна.

Зураг Гадаад худалдааны ерөнхий индекс

Урсгал данс

Тайлант онд төлбөрийн тэнцлийн урсгал данс 104.3 сая ам. долларын ашигтай гарч өнгөрсөн оныхоос 40.9 сая ам. доллараар нэмэгджээ. Энэ нь ДНБ-ий 5.6 хувийг эзэлж байна. Гадаад худалдааны алдагдал 9.2 сая ам. доллар болж багассан нь өнгөрсөн оныхоос 3.1 дахин буурсан байна. Урсгал данс ашигтай гарахад 3, 4-р улирлын бараа болон үйлчилгээний тэнцэл эрс сайжирсан, урсгал шилжүүлэг түүний дотор гадаад оронд ажиллаж буй монгол иргэдийн хувийн гуйвуулга болон Засгийн газрын техник туслалцааны орлого орсон зэрэг голлон нөлөөлсөн байна.

Зураг Урсгал данс

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гадаадад ажиллаж буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын орлого 21.2 сая ам. доллараар буурч, 174.2 сая ам. долларт хүрсэн нь банкуудаар болон бусад албан сувгаар хийгддэг шилжүүлгийн тоо эрс багассантай холбоотой юм. Гэсэн ч 2005 оны хувийн гуйвуулгын орлого ДНБ-ий 9.4 хувьтай тэнцэж байна. Монгол улсын Засгийн газар нийт 88.0 сая ам. долларын буцалтгүй тусламжийг олон улсын байгууллага болон гадаад орны засгийн газраас хүлээн авчээ. Тайлант оны үйлчилгээний тэнцэл 61.5 сая ам. долларын алдагдалтай гарав.

Гадаад худалдаа

Гаалийн ерөнхий газрын урьдчилсан мэдээгээр 2005 оны гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 2004 оноос 311.6 сая ам. доллар буюу 16.5 хувиар өсч 2202.4 ам. долларт хүрлээ. Худалдааны алдагдал 95.0 сая ам. доллар гарсан нь өмнөх оны худалдааны алдагдлаас 56.4 сая ам. доллараар багассан байна. Төлбөрийн тэнцэлд импортын үнийн дүнг С.И.Ф нөхцөлөөс Ф.О.Б нөхцөлд шилжүүлэн тээвэр болон даатгалын төлбөрийг үйлчилгээний бүлэгт бүртгэж тооцсоноор нийт импорт 1065.0 сая ам. доллар болж барааны тэнцэл 9.2 сая ам. долларын алдагдалтай гарав.

Монгол улсын экспортын нийт орлогын 67.2 хувийг бүрдүүлдэг алт, зэс, ноолуурын зах зээлийн үнэ өндөр байсан нь манай улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийн алдагдлыг багасгахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын алтны экспорт тогтмол нэмэгдэж алт нь манай улсын экспортын гол бараа бүтээгдэхүүний нэг боллоо. 2005 оны байдлаар Монгол улс 23.8 тонн алт экспортолж, экспортын орлогын 31.5 хувийг бүрдүүллээ. 2005 онд экспортолсон алтны хэмжээ өмнөх оны байдалтай харьцуулбал 4.5 тонн буюу 23.0 хувиар нэмэгджээ.

Зураг Нийт экспортод алтны эзлэх хувь
Зураг Нийт экспорт болон алтны хэмжээ

Нөгөө талаас хөрөнгө оруулагчид, Төв банкууд, нефть экспортлогч орнууд нефтийн үнийн өсөлтийн улмаас бий болж буй инфляци, валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн гарч болзошгүй алдагдлаас хөрөнгөө хамгаалах зорилгоор алт худалдан авч байсан нь 2005 онд нэг унц алтны дэлхийн зах зээлийн үнийг өсгөхөд нөлөөлсөн байна.

Тайлант оны 12 дугаар сарын 12-ны өдөр нэг унц алтны үнэ 541 ам. долларт хүрсэн нь сүүлийн 24 жилийн хамгийн өндөр үнэ юм. Харин 12 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар нэг унц алтны үнэ буурч 513.28 ам. долларт хүрсэн нь 2004 оныхоос 18.0 хувиар өсчээ. 2005 оны нэг унц алтны жилийн дундаж үнийг 2004 оны үнэтэй харьцуулахад 5.5 хувиар өссөн байна.

Зураг. Лондонгийн биржийн 1 унц алтны үнэ
Зураг. Лондонгийн биржийн 1 унц алтны үнэ

АНУ-Ираны харилцаанаас үүдэн геополитикийн байдал түгшүүртэй болж инфляци өсөх хүлээлттэй орчинд эцсийн шатны валют болох алтыг хөрөнгө оруулагчид ихээр худалдан авч түүний эрэлт хэрэгцээ нэмэгддэг уламжлал тогтсон байдаг. Жишээлбэл, 1980 онд АНУ-д инфляцийн түвшин огцом 12.0 хувиар нэмэгдэхэд зах зээл дээр алтны үнэ өсч Нью-Йоркийн бирж дээр нэг унц алтны үнэ 873 ам. долларт хүрч байсан байна.

Экспортод гаргасан эрдэс бүтээгдэхүүний экспортын 95.2 хувийг зэсийн баяжмал, молибдены баяжмал, хайлуур жонш, түүхий нефть болон чулуун нүүрсний экспорт эзэлж байна. 2005 онд нийт 584.5 мянган тонн зэсийн баяжмал экспортолж 324.6 сая ам. долларын экспортын орлого олжээ. Хувийн жингээрээ алтны дараа ордог гол экспортын бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалын экспорт 2005 оны байдлаар манай улсын нийт экспортын 30.7 хувийг бүрдүүлэв.

Зэсийн баяжмалын экспортыг биет хэмжээгээр нь өмнөх онтой харьцуулахад 22.1 мянган тонноор нэмэгджээ. Тайлант онд нийт зэсийн баяжмалын экспортын 95.2 хувийг Хятадад гаргав. Монгол улсын олборлож байгаа зэсийн хэмжээ дэлхийн нийлүүлэлтийн 4.0 орчим хувийг тогтмол бүрдүүлдэг.

Хувийн жингээрээ ноолуур манай улсын экспортын 3 дахь гол бүтээгдэхүүн юм. Тайлант онд Монгол улс нийтдээ 2.4 мянган тонн ноолуур, 482.5 мянган ширхэг ноолууран бүтээгдэхүүн экспортолж, нийт 93.8 сая ам. долларын орлого олсон нь 2005 оны экспортын 8.8 хувийг эзэлж байна.

Манай улс өөрийн хэрэгцээний нефтийн бүтээгдэхүүнийг 100.0 хувь импортоор авдаг тул дэлхийн нефтийн зах зээлийн байдал манай улсын гадаад худалдаанд шууд нөлөөлдөг. 2005 онд нефтийн бүтээгдэхүүний импортын биет хэмжээ 5.7 хувиар буурсан ч, импортын дундаж үнэ 374.6 ам. доллараас 537.9 ам. доллар болж нэмэгдсэнээр импорт үнийн дүнгээр 75.6 сая ам. доллараар өсөв.

Хүснэгт Нефтийн бүтээгдэхүүний импорт

Манай улсын нефтийн бүтээгдэхүүний жилийн хэрэглээг харуулсан хүснэгтээс харахад 2005 оны эцсийн байдлаар манай улсын эдийн засаг 542.4 мянган тонн нефтийн бүтээгдэхүүн хэрэглэсэн бөгөөд энэ нь 2000 оныхоос 21.8 хувиар их, 2004 оныхоос 5.6 хувиар бага байна. 2005 онд нийт хэрэглэсэн нефтийн хэмжээ буурсан нь үнийн өөрчлөлттэй шууд холбоотой бөгөөд үнийн өсөлт, ханшийн сулралт нь импортын хэмжээнд нөлөөлснийг харуулж байна.

Зураг Нефтийн бүтээгдэхүүний импорт /тонноор/

Зураг. Нефтийн бүтээгдэхүүний импорт /мян. ам. доллараар/

ДНБ-ийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор авч буй арга хэмжээ, гадаадад байгаа монгол иргэдийн гуйвуулгын өсөлт, автомашин, техникийн импортын өсөлт зэргээс манай улсын нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ цаашид улам нэмэгдэх хандлагатай байна.

Зураг Худалдааны тэнцэл

*Төлбөрийн тэнцлийн шинэчилсэн аргачлалын дагуу импортын үнийн дүнг С.И.Ф нөхцөлөөс Ф.О.Б нөхцөлд шилжүүлэхдээ коэффициентийг 11.0 хувиар тооцов.

*Экспортын үнийн дүн дээр татваргүй барааны орлого нэмэгдсэн болно.

Үйлчилгээ болон шилжүүлэг

Тайлант онд үйлчилгээний нийт орлого 414.4 сая ам. доллар, зарлага 475.9 сая ам. долларт хүрснээр үйлчилгээний тэнцэл 61.5 сая ам. долларын алдагдалтай гарлаа. Монгол улсын нийт үйлчилгээний зарлага 2005 онд 27.6 сая ам. доллараар буурч, харин үйлчилгээний орлого 76.2 сая ам. доллараар нэмэгдсэн байна.

Үйлчилгээний тэнцэл сайжрахад тээврийн үйлчилгээний орлого голлон нөлөөлжээ. 2004 онд 91.8 сая ам. долларын алдагдалтай байсан тээврийн үйлчилгээний тэнцэл 74.8 сая ам. доллараар сайжирч 17.0 сая ам. долларын алдагдалтай гарав. Үүнд ачаа тээш болон тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний орлого эрс нэмэгдсэн нь

машин, онгоц болон төмөр замын транзит тээврийн орлого, дамжин өнгөрөх чартер болон гэрээт нислэгийн хураамж өссөнтэй шууд холбоотой байна.

Мөн аялал жуулчлалын салбарын зардал 22.1 сая ам. доллараар багасч, уг салбарын үйлчилгээний тэнцэл 13.8 сая ам. доллараар сайжирсан байна. Өнгөрсөн онд нийт 344.6 мянган гадаадын иргэд Монгол улсад зорчсоноос 338.7 мянган жуулчид ирж аялал жуулчлалын салбарын нийт орлого 176.8 сая ам. долларт хүрчээ. Аялал жуулчлалын орлого алтны экспортын орлогын 53.3 хувь, зэсийн баяжмалын экспортын орлогын 54.5 хувийг тус тус эзэлж байна.

Зураг Үйлчилгээний тэнцэл

Урсгал шилжүүлэг 225.2 сая ам. долларын ашигтай гарсан нь Монгол улсын Засгийн газар нийт 88.0 сая ам. доллартай тэнцэх буцалтгүй тусламжийг хүлээн авсан, мөн гадаадад ажиллаж буй Монгол иргэдийн гуйвуулгын орлого өндөр байгаатай шууд холбоотой байна.

Монгол иргэдийн хувийн гуйвуулга өнгөрсөн оноос 10.8 хувиар багассан нь Англи, Герман зэрэг орноос албан шугамаар хүлээн авдаг гуйвуулгын дүн эрс буурсан, БНСУ-д хууль бусаар үйл ажиллагаа явуулж байсан манай 5 банкны хувийн гуйвуулгын үйлчилгээ оны эцсээр хаагдсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад Монгол улсын Засгийн газрын хүлээн авсан буцалтгүй тусламжийн хэмжээ өөрчлөгдөөгүй нь урсгал шилжүүлгийг ашигтай гарахад нөлөөллөө.

Хөрөнгө болон санхүүгийн данс

Хөрөнгө болон санхүүгийн данс 43.4 сая ам. долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 66.5 сая ам.доллараар өсчээ.

2005 оны байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалт ДНБ-ий 9.8 хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулснаар гадаадын шууд хөрөнгө оруулалт 96.2 хувиар өсч 182.3 сая ам.доллар болсон нь санхүүгийн данс ашигтай гарахад нөлөөллөө. Харин бусад хөрөнгө оруулалтын тэнцэл 138.9 сая ам. долларын алдагдалтай гарсан нь манай улсын уул уурхай, алт олборлолтын салбарт үйл ажиллагаа явуулж буй зарим аж ахуйн нэгжүүдийн алтны экспортын орлого орж ирээгүйтэй холбоотой.

Зураг Санхүүгийн данс

Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн мэдээгээр 2005 онд гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай болон хамтарсан хөрөнгө оруулалттай нийт 988 аж ахуйн нэгж 311.7 сая ам. долларын гадаадын хөрөнгө оруулалт хийхээр бүртгэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ, БНСУ, ОХУ, Их Британи, АНУ, Япон, Итали, Украин зэрэг улс нийт хөрөнгө оруулалтын 93.2 хувийг эзэлж байна.

*Зураг Шууд хөрөнгө оруулалт /улсаар/
Зураг Шууд хөрөнгө оруулалт /динамик/*

Хөрөнгө оруулалтыг тухайн салбарт эзлэх хувийн жингээр нь авч үзвэл геологи, уул уурхайн салбар нийт хөрөнгө оруулалтын 61.0 хувь, худалдаа, нийтийн хоолны салбар 17.0 хувь, банк, санхүүгийн салбар 3.0 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал уул уурхайн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт 30.1 хувиар өссөн бол банк санхүүгийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 56.5 хувиар буурчээ. Банкуудын хувьчлал хийгдсэн жилүүдэд банк санхүүгийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй өндөр байв.

Зураг Шууд хөрөнгө оруулалт салбараар

Тайлант онд Засгийн газрын шугамаар олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас нийт 96.2 сая ам. долларын урт болон дунд хугацаатай зээл авснаас Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон Японы Засгийн газраас авсан зээл 71.6 хувийг эзэлж байна. Монгол улс тайлант хугацаанд ДНБ-ий 8.1 хувь буюу 151.2 сая ам.долларыг үндсэн өрийн нийт төлбөрт төлсөн бол 16.2 сая ам. долларыг үндсэн өрийн хүүний төлбөрт төлжээ.

2.4. Үнэ, цалин хөлс

2005 онд өргөн хэрэглээний барааны үнийн түвшин харьцангуй өндөр хэлбэлзэлтэй байв. Бензин, шатахууны үнийн өсөлт, түүний бараа бүтээгдэхүүний суурь үнэ болдог онцлог байдал нь инфляцийн өсөлтийн шалтгаан болсон. Мөн зарим бараа бүтээгдэхүүний хомсдол буюу улирлын шинж чанартай бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт нь инфляци өндөр гарах нөхцөл болж байна. Энэ нь 2005 оны суурь инфляци хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляциас харьцангуй бага гарснаас харагдаж байна.

Хүснэгт. Инфляци ба суурь инфляци¹

Оны эхнээс инфляци өндөр хурдтай өсч эхэлсэн бөгөөд оны эхний хагаст сард дунджаар 2.2 хувиар өсч, 6 дугаар сард 13.6 хувьд хүрсэн нь 2001 оны 7 сараас хойш илрээгүй үзүүлэлт юм. Харин 7 дугаар сараас өсөлт буурч, 8, 9, 10 дугаар саруудад дефляци ажиглагдан оны эцсийн байдлаар жилийн инфляци 9.5 хувьтай гарлаа. Хэрэглээний үнийн индексийн динамикаас харахад жил бүрийн эхний хагаст ерөнхий индекс өсч, харин зуны сард буурч, оны сүүлд эргээд өсөх хандлага сүүлийн жилүүдэд тогтмол хадгалагдаж иржээ. Тухайлбал, өмнөх онуудад зуны сард ажиглагддаг дефляци ихэвчлэн 6 дугаар сараас, зарим жилд 7 дугаар сараас эхлэн 8 дугаар сар, эсвэл 9 дүгээр сар хүртэл үргэлжилж байв. Энэ нь хэрэглээний сагсанд өндөр хувийн жин эзэлдэг мах болон сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногооны нийлүүлэлт зуны сард нэмэгддэгээс үнийн түвшин бууран улмаар хүнсний бүтээгдэхүүний бүлгийн индекс ижил чиглэлд өөрчлөгддөгтэй холбоотой юм.

Хүснэгт. Хэрэглээний үнийн индекс

Бензин шатахууны үнийн өсөлтийн шууд нөлөөгөөр тээвэр, холбооны үйлчилгээний дэд бүлгийн индекс 2005 онд 5.9 хувиар өссөн нь ерөнхий индексийг 0.8 орчим

¹ * Суурь инфляцийг мах, ногоо, сүү зэрэг нийлүүлэлтийн хомсдолоос шалтгаалан үнэ нь өөрчлөгддөг барааны бүлгийг хасаж тооцсон. Өөрөөр хэлбэл, нийт хэрэглээний сагсны 239 бараанаас 28 барааг тооцоонд оруулаагүй.

нэгжээр нэмэгдүүлсэн байна. Харин улирлын шинж чанартай хүнсний барааны үнийн түвшин өмнөх оноос 15.6 хувиар өссөн нь ерөнхий индексийг 9.6 хувиар нэмэгдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл жилийн инфляци 9.5 хувьтай гарсны дийлэнх нь хүнсний барааны үнийн өөрчлөлттэй уялдаатай.

Хүнсний бараа, үүнд мах, махан бүтээгдэхүүн инфляцийн өсөлтийн үндсэн шалтгаан болж буй энэ нөхцөлд махны үнийг тогтворжуулах, зохистой түвшинд барих явдал нь чухал юм. Зуны сүүл, намрын эхэн саруудад хонь, үхрийн махны үнэ нийлүүлэлтээс хамаарч буурдаг. Энэ үед мах нөөцөлж, өвөл, хаврын хомсдол үүсдэг улиралд нийлүүлэх нь махны үнийн огцом өсөлт, үнийн хиймэл хөөрөгдлөөс сэргийлэх арга хэмжээ болно.

Үндэсний Статистикийн Газар (ҮСГ) нь ХҮИ²-ийн аргачлалаар инфляци тооцохдоо 2000 оныг суурь оноор авдаг. 2000 онд иргэдийн өргөн хэрэглэж байсан бараа бүтээгдэхүүн одоо үеийнхээс харьцангуй өөрчлөгдсөн. Иймд өрхийн орлого, зарлагын нарийвчилсан судалгаа хийж, хэрэглээний сагсны бүтцийг шинэчлэх шаардлагатай байна. Жишээ нь: 2005 оны жилийн инфляци нь зөвхөн хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөлтөөс хамаарчээ. Гэвч бодит хэрэг дээр бензин шатахуун, халуун ус, цахилгааны үнэ өссөн нь ард иргэдэд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлттэй дүйцэхүйц хэмжээний дарамт учруулсан.

ҮСГ нь улирал бүр ажиллагсдын сарын дундаж цалинг тооцож гаргадаг. Тооцооны дагуу оны эцсийн байдлаар ажиллагсдын дундаж цалин 101.2 мянган төгрөг байна. Дундаж цалингийн жилийн өсөлт нь 8.7 хувь буюу жилийн инфляциас 0.8 нэгжээр бага өөрөөр хэлбэл бодит орлогын үнэ цэнэ буурчээ.

Хүснэгт Дундаж цалин, салбараар

Ажиллагсдын дундаж цалингийн өмнөх онтой харьцуулсан өсөлтийг эдийн засгийн салбараар авч үзэхэд зочид буудал зоогийн газар, барилга, эрчим хүч, санхүү зохицуулалт, уул уурхай, тээвэр холбоо агуулахын аж ахуй зэрэг салбарт ажиллагсдын дундаж цалин улсын дунджаас 9.7-62.7 мянган төгрөгөөр их байхад хөдөө аж ахуй, ойн аж ахуй, үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа, эрүүл мэнд нийгмийн хангамж, нийгэм, хамт олон, хувь хүний үйлчилгээ зэрэг салбарт ажиллагсдын цалин улсын дундаж цалингаас 8.4-48.4 мянган төгрөгөөр доогуур байна.

Макро эдийн засгийн онолд хөдөлмөрийн бүтээмж өсөөгүй үеийн цалингийн өсөлтийг сайшаадаггүй. Харин цалинг бууруулах эсвэл тогтвортой түвшинд барихыг санал болгодог. 2006 онд төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмэгдүүлэхээ Засгийн газар мэдэгдсэн. Нийт ажил эрхлэгчдийн 11.5 хувь нь төрийн албан хаагчид байдаг. Энэхүү эзлэх хувийн жин нь бага биш тоо бөгөөд эдийн засагт яаж нөлөөлөх талаар нарийн судалгаа шинжилгээ хийх хэрэгтэй юм. Өрхийн орлого, зарлагын судалгаанаас харахад нийт өрхийн дийлэнх хувь нь орлогоо тухайн сардаа бүрэн зарцуулдаг. Өөрөөр хэлбэл ахиу цалин нь иргэдийн хэрэглээг өсгөж эрэлтээс үүдсэн инфляци илрэх магадлалтай. Инфляцийн өсөлт эргээд бодит цалингийн үнэ цэнийг бууруулдаг. Цалингийн өсөлтөөс энэ мэт үр дагавар илэрч болзошгүй юм. Гэсэн хэдий ч төрийн албан хаагчдын цалин ажиллагсдын цалингийн дунджаас бага байна.

² ХҮИ - хэрэглээний үнийн индекс

2.5. Ажиллах хүчний зах зээл

Монгол улсын нийт хүн ам 2005 оны эцсийн байдлаар 2562.4 мянгад хүрснээс хөдөлмөрийн насны хүн ам 1673.6 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүч 1001.2 мянга, ажиллагсад 968.3 мянга болов.

Засаг захиргааны бүртгэлд үндэслэсэн ажил эрхлэлтийн 2005 оны эцсийн тайлангаас үзвэл төрөл бүрийн шалтгаанаар нийтдээ 278.9 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байв. Үүнээс хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, өвчтэй, гэр бүлийн хүний ажлын онцлог, гэрийн ажилтай гэх мэт хүндэтгэх шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй хүнийг хасвал 197 гаруй мянган хүн хүндэтгэх бус шалтгаанаар тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй байна.

2005 оны жилийн эцсийн байдлаар эдгээр хүнээс 32.9 мянга нь аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил идэвхтэй эрж, хайж байгаа ажилгүйчүүд гэж бүртгүүлсэн нь өнгөрсөн оныхоос 7.4 хувь буюу 2.6 мянган хүнээр буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 22.8 хувийг 16-24 насны, 33.3 хувийг 25-34 насны, 28.9 хувийг 35-44 насны, 15.1 хувийг 45-59 насны хүн эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 11.0 хувь нь дээд, 8.3 хувь нь тусгай дунд, 10.0 хувь нь мэргэжлийн анхан шатны, 65.3 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд, 4.8 хувь нь бага боловсролтой, 0.7 хувь нь боловсролгүй хүн байна.

2005 онд улсын хэмжээгээр 56.4 мянган хүн шинээр ажил хайж бүртгүүлсэн бол 42.1 мянган бүртгэлтэй ажилгүй хүн ажилд оржээ.

3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

Тайлант онд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээ, хүртээмж өргөжин, харилцагчдын банкинд итгэх итгэл үргэлжлэн дээшлэхийн хирээр банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө, зээлжүүлэлт хурдацтай нэмэгдсэн байна. Энэ нь санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлж, эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр оруулах алхам болж өглөө.

Банкуудын тоон үзүүлэлтүүд тэлж нийт актив өмнөх оныхоос 42.9 хувиар, нийт зээлийн хэмжээ 41.8 хувиар, өөрийн хөрөнгө 23.9 хувиар өсч харин банкны салбарын үйл ажиллагааны гол чанарын үзүүлэлт болох чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь 0.6 нэгжээр буурсан байна. Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийн түвшин оны дунд үе хүртэл өсөх хандлагатай байсан тул Төв банк ТБҮЦ-ны гаргах хэмжээгээ нэмэгдүүлэн, мөнгөний агрегатуудын хурдыг сааруулан ажиллав. Инфляци оны эцэст буурч жилийн 9.5 хувь болов.

Нийт мөнгөний өсөлтөд бараг мөнгөний өсөлт дийлэнх хувийг эзэлсээр байгаа бөгөөд 2004 онд бараг мөнгөний өсөлтөд гадаад валютын хадгаламжийн өсөлт зонхилох хандлага ажиглагдаж байсан бол 2005 оны хувьд эсрэгээрээ буюу төгрөгийн хадгаламжийн өсөлт илүү байлаа. Энэ нь иргэдийн үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл сайжирч буйг илэрхийлэхийн зэрэгцээ оны туршид төгрөгийн хадгаламжийн

хүү нь гадаад валютын хадгаламжийн хүү болон төгрөгийн америк доллартай харьцах номиналь ханшийн сулралтын нийлбэрээс өндөр байсантай холбоотой юм.

Мөнгөний нийлүүлэлт

Тайлант онд эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт оны эхнээс 38.1 хувь буюу 323.1 тэрбум төгрөгөөр өсч, Монголын эдийн засгийн түүхэнд анх удаагаа 1.17 их наяд (триллион) төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх буюу 85.2 хувийг бараг мөнгөний өсөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оныхоос 8.9 нэгжээр буурсан байна. Харин M1 мөнгө (банкнаас гадуурхи мөнгө болон төгрөгийн харилцах)-ний өсөлт 14.8 хувийг эзэлж, өмнөх оныхоос 8.9 нэгжээр өсчээ.

Зураг Нийт мөнгө M2, M1 болон бараг мөнгө, 12 сарын өсөлт, хувиар

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг өмнөх оны өсөлттэй харьцуулахад 179.4 тэрбум төгрөг буюу 17.7 нэгжээр хурдасчээ. Харин энэ үзүүлэлт 2004 онд 89.5 тэрбум төгрөг буюу 29.2 нэгжээр саарч байжээ.

Зураг Мөнгөний үзүүлэлтүүд: 12 сарын өсөлт, хувиар

Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдэд гарсан өөрчлөлтийн хандлагаас харахад өмнөх жилд буурч байсан мөнгөний агрегатуудын жилийн өсөлтийн хурдац тайлант онд өссөн байна. Тухайлбал, M1-ийн жилийн өсөлт 17.6 нэгж, төгрөгийн хадгаламж 26.3 нэгж, гадаад валютын хадгаламж 7.3 нэгжээр тус тус нэмэгдэж M2-ийн жилийн өсөлтийг 17.7 нэгжээр өсөхөд нөлөөлөв. Үүнээс үзэхэд тайлант оны мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд бараг мөнгө түүн дотроо иргэдийн төгрөгийн хадгаламж зонхилох хувь эзлэх болсон нь харагдаж байна. Энэ нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт өсч санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн хэрээр иргэд, байгууллагуудын мөнгөн хөрөнгийн хуримтлал нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Зураг M2 мөнгөний бүтцийн задаргаа, M2 мөнгөнд эзлэх хувиар

Бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд сүүлийн жилүүдэд эрчимтэй буурах хандлагатай байсан банкнаас гадуурхи мөнгө тайлант оны эхээр бага зэрэг өсч энэ түвшин оны турш хадгалагдсан бол харин банкуудын харилцах тогтвортой байв. Төгрөгийн ханшийн хэлбэлзэлтэй холбоотойгоор төгрөгийн хадгаламж оны эхээр болон III улиралд нийт мөнгөнд эзлэх хувийн жингээрээ тэргүүлж байсан бол II болон IV улиралд гадаад валютын хадгаламжийн эзлэх хувь илүү болжээ.

Хүснэгт Мөнгө санхүүгийн салбарын гол үзүүлэлтүүд, хувиар

Тайлант онд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг үндсэндээ мөнгөний эрэлтийг хангах нийлүүлэлт байсан гэж үзэх нь нэг талаас эдийн засаг дахь зээлийн хэмжээ хурдацтай өсч байгаа буюу банкны салбараас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оноос 253.1 тэрбум төгрөг буюу 41.7 хувиар өссөн нь нийт мөнгөний өсөлтийн 78.3 хувийг эзэлж байгаа, нөгөө талаас инфляцийн түвшин оны дундаас тогтвортой бууран нэг оронтой тоонд орсонтой холбоотой.

Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийг гадаад болон дотоод цэвэр активын өөрчлөлтөөр авч үзвэл, өмнөх онд дотоод цэвэр активын өсөлтөөр хангагдаж байсан

мөнгөний нийлүүлэлтийн хандлага эрс өөрчлөгдөж, өсөлтийн зонхилох хувь буюу 80.2 хувийг гадаад цэвэр актив, 19.8 хувийг дотоод цэвэр актив эзлэх болсон байна. Энэ нь 2004 оны эцэст гадаад болон дотоод цэвэр активт огцом өөрчлөлт гарсан, 2005 онд тэдгээрийн хандлага өөрчлөгдсөнөөр тайлбарлагдаж байна. Дотоод цэвэр активын жилийн өсөлт 8.0 нэгжээр буурч 11.9 хувьд хүрсэн бол гадаад цэвэр активынх 62.0 нэгжээр нэмэгдэж 83.3 хувьд хүрчээ. Тайлант онд гадаад болон дотоод активын жилийн өөрчлөлтүүд өмнөх онтой харьцуулахад харьцангуй тогтвортой байсан нь мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийг жилийн туршид харьцангуй тогтвортой байхад нөлөөллөө.

Зураг Мөнгө, гадаад болон дотоод цэвэр активууд, 12 сарын өсөлт

Банкны салбараас дотооддоо олгосон цэвэр зээл оны эхнээс 26.1 хувь буюу 168.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс дотоод цэвэр актив 11.9 хувь буюу 63.9 тэрбум төгрөгөөр өслөө. 2005 оны эхнээс банкуудын засгийн газраас авах авлага тогтвортой буурч, засгийн газрын харилцах, хадгаламжийн хэмжээ өсч байсан бөгөөд улмаар 7 дугаар сараас эхлэн засгийн газрын дотоод цэвэр зээл сөрөг буюу засгийн газрын хадгаламжийн хэмжээ нь зээлээсээ их байв. Энэ нь төсвийн татварын орлогын өсөлтөөс шалтгаалсан болно. Тайлант онд улсын секторт олгосон зээл 21.5 тэрбум төгрөг буюу 71.6 хувиар, хувийн секторт олгосон зээл 221.8 тэрбум төгрөг буюу 41.6 хувиар өсчээ. Харин хугацаа хэтэрсэн зээл 0.7 тэрбум төгрөг буюу 3.2 хувиар буурсан байхад хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл 10.4 тэрбум төгрөг буюу 26.5 хувиар өсчээ.

Гадаад цэвэр актив өмнөх оноос 83.3 хувь буюу 259.2 тэрбум төгрөгөөр өссөнөөс гадаад цэвэр албан нөөц 82.2 хувь буюу 134.4 сая ам. доллараар нэмэгджээ. Гадаад цэвэр албан нөөцийн энэхүү өөрчлөлтөнд гадаадын банк дахь хугацаат хадгаламжийн хэмжээ 89.1 хувь буюу 116.9 сая ам. доллараар, гадаадын засгийн газрын үнэт цаас 42.7 хувь буюу 21.6 сая ам. доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Бага мөнгө M1

Тайлант оны эцэст бага мөнгө (M1) 21.6 хувь буюу 47.8 тэрбум төгрөгөөр өсч 269.1 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 23.0 хувийг эзэлж байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүдийн хэрэглээний цар хүрээ тэлэхийн хэрээр бага мөнгөний өсөлтөд төгрөгийн харилцахын өсөлт зонхилох хувийг эзэлж байна. M1-ийн өсөлтийн 81.5 хувь нь банкуудын төгрөгийн харилцахын өсөлт, 18.5 хувь нь банкнаас гадуурхи мөнгөний өсөлт байна. Төгрөгийн харилцахын өсөлт өмнөх онтой харьцуулахад эргэж өссөн нь бага мөнгөний өсөлтийг 17.6 нэгжээр нэмэгдүүлсэн хэдий ч бараг мөнгөний хурдацтай өсөлтөөс шалтгаалан нийт мөнгөнд эзлэх хувь нь 3.1 нэгжээр буурчээ.

Тайлант онд банкнаас гадуурхи мөнгө 8.9 тэрбум төгрөг буюу 6.2 хувь, банкуудын касс 14.3 тэрбум төгрөг буюу 57.2 хувь, төгрөгийн харилцах 38.9 тэрбум төгрөг буюу 50.0 хувиар тус тус өсчээ. Бага мөнгөний жилийн өсөлт эдийн засаг дахь бэлэн мөнгөний эрэлтийг даган оны эхэнд тогтмол нэмэгддэг. Харин төгрөгийн харилцахын жилийн өсөлт нэгдүгээр сард буураад түүнээс хойш оны турш өсч байсан бол банкнаас гадуурхи мөнгө зуны саруудад илүүтэй нэмэгдэж, бусад саруудад буурах хандлага ажиглагдлаа.

Зураг Бага мөнгө, түүний бүтэц, 12 сарын өсөлт, хувиар

Газар тариалан, ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэл болон уул уурхайн салбаруудын үйлдвэрлэл 1 дүгээр улиралд зогсож, 2 дугаар улиралд үйл ажиллагаа нь эхэлдэгтэй холбоотойгоор банкнаас гадуурхи мөнгөний эрэлт 1 дүгээр улиралд буурч, 2 дугаар улиралд нэмэгдэх хандлагатай байдаг. Харин жилийн сүүлийн хагаст бэлэн мөнгөний урсгал дээр дурьдсан салбаруудаас банкны салбар руу буцаж ордгоос банкнаас гадуурхи мөнгө буурдаг байдал сүүлийн жилүүдэд тогтмол ажиглагдаж байна. 2005 онд энэ байдал хадгалагдаж, банкнаас гадуурхи мөнгөний улирлын өөрчлөлт харьцангуй тогтвортой байлаа. Энэхүү улирлын нөлөөлөл М1 болон М2-г хүчтэй нөлөөлдөг боловч сүүлийн жилүүдэд М1 болон бараг мөнгөний нийт мөнгөнд эзлэх хувийн жингийн өөрчлөлтийг даган М2-т үзүүлж буй улирлын хэлбэлзлийн нөлөө илэрхий буурах хандлагатай байгаа юм. Энэ нь бараг мөнгөний өсөлт улирлын нөлөөллөөс хамаарахгүй өсч буйн тод илрэл бөгөөд М1 мөнгөний улирлын нөлөөлөл суларч, эзлэх хувийн жин нь багасч байгаатай холбоотой юм.

Зураг Засварласан улирлын хэлбэлзлийн индексүүд

Бараг мөнгө

Тайлант онд бараг мөнгө 275.3 тэрбум төгрөг буюу 44.0 хувиар өсч 901.0 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 77.0 хувийг эзэлж байна. Тайлант онд төгрөгийн америк доллартай харьцах ханш чангарах хандлагатай байсан нь иргэдийн хувьд төгрөгийг илүүд үзэх сонирхлыг нэмэгдүүлж, улмаар төгрөгийн хугацаат хадгаламжийн өсөлт бараг мөнгөний өсөлтөд зонхилох болжээ. Мөн банкуудын төгрөгийн хадгаламжид төлдөг хүү валютын хадгаламжийнхаас өндөр байсан нь үүнд нөлөөлсөн байна. Өмнөх онд бараг мөнгөний өсөлтөд төгрөгийн хадгаламжийн өсөлтийн эзлэх хувь валютын хадгаламжийн өсөлтийн эзлэх хувиас бага байсан бол 2005 онд эсрэгээр өөрчлөгдсөн байна. 2005 онд бараг мөнгөний өсөлтийн 56.3 хувийг төгрөгийн хадгаламжийн өсөлт, 43.7 хувийг гадаад валютын харилцах, хадгаламжийн өсөлт тус тус эзэлж байна.

Төгрөгийн хадгаламж оны эхнээс 155.1 тэрбум төгрөгөөр өсч 456.0 тэрбум төгрөгт, гадаад валютын харилцах, хадгаламж 120.2 тэрбумаар өсч 445.0 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

Зураг Мөнгөний үзүүлэлтүүд, 12 сарын өсөлт, хувиар

Гадаад валютын хадгаламжийн өөрчлөлт нь ханшийн хэлбэлзэлтэй шууд холбоотой байв. Өмнөх оны турш тасралтгүй буурч байсан төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт 2005 онд 24.3 хувиас 51.5 хувь болтлоо өсчээ. Гадаад валютын хадгаламжийн жилийн өсөлт оны эхэнд харьцангуй тогтвортой байсан хэдий ч ханшийн хэлбэлзлийн нөлөөгөөр 3 дугаар улиралд өсч, 4 дүгээр улиралд бууран бараг мөнгөнд эзлэх хувь нь 48.9-52.8 орчим хувийн хооронд өөрчлөгдөж байв. Тайлант оны эцсийн байдлаар нийт хадгаламжийн 50.6 хувийг төгрөгийн хадгаламж, 49.4 хувийг гадаад валютын хадгаламж эзэлж байлаа. Үүнийг 2004 оны байдалтай харьцуулбал, төгрөгийн хадгаламж 2.5 нэгжээр өссөн бол валютын хадгаламж 2.5 нэгжээр буурчээ.

Мөнгөний эргэлтийн хурд, үржүүлэгч

Мөнгөний эргэлтийн хурд нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт хэдэн удаа эргэлтэнд орж эдийн засагт үйлдвэрлэгдэж буй шинэ үнэ өртөг болох ДНБ-ийг бий

болгож байгааг илэрхийлдэг. Тайлант оны эцсийн байдлаар мөнгөний эргэлтийн хурд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 нэгжээр буурч 1.94 болсон бөгөөд үүний гол шалтгаан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нэрлэсэн үнээр илэрхийлсэн ДНБ-ий өсөлтөөс өндөр байсан явдал юм. Мөнгөний эргэлтийн хурд өндөр байх нь мөнгөний гарал үүсэлтэй холбоотой инфляци гараагүй, бага хэмжээний санхүүгийн эх үүсвэрээр эдийн засгийн өндөр өсөлтийг бий болгож байгааг илэрхийлдэг чухал үзүүлэлт юм.

Харин мөнгөний үржүүлэгч нь нөөц мөнгө хэд дахин өсч эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг бий болж байгааг илэрхийлэх бөгөөд 2005 онд мөнгөний үржүүлэгч өмнөх оноос 0.55 нэгжээр өсч 4.16-д хүрчээ. Энэ нь манай оронд сүүлийн жилүүдэд гарсан хамгийн өндөр үзүүлэлт юм. Мөнгөний үржүүлэгчийн 2005 оны энэхүү огцом өсөлт нь инфляцийг хязгаарлах зорилгоор Төв банкнаас үнэт цаас их хэмжээгээр гаргаж нөөц мөнгөний өсөлтийг барьж байсантай холбоотой юм.

Мөнгөний зах зээл

Хөрвөх чадвар сайтай, эрсдэл багатай богино хугацааны санхүүгийн хэрэгслүүд арилжигдаж, дахин хуваарилах үйл ажиллагаа явагддаг зах нь мөнгөний зах зээл юм. Мөнгөний зах зээлийн үйл ажиллагаанд Төв банк, Засгийн газар болон банкууд голчлон оролцож байгаа бөгөөд бусад зах зээлтэй харьцуулахад үйл ажиллагаа нь тогтворжиж, хэмжээгээрээ хурдан томорч байгаа ил тод нээлттэй зах зээл юм.

Мөнгөний зах зээл нь санхүүгийн салбарт хөрөнгө зохистой хуваарилагдахад онцгой чухал үүрэгтэй бөгөөд манай оронд энэ зах зээл хөгжсөнөөр санхүүгийн гол зуучлагчид болох банкууд богино хугацаанд хөрөнгө дайчлах эсвэл байршуулах боломж нь нэмэгддэг. Энэ утгаараа банкууд нөөц хөрөнгөө оновчтой удирдах замаар заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаж, мөнгөн урсгалаа төлөвлөхөд тус зах чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

2005 онд банк хоорондын зах дээр Төрийн сангийн овернайт зээлийг оруулалгүйгээр 749.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оныхоос 23.9 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд энэ нь он дараалан банк хоорондын зах идэвхжиж байгааг илэрхийлж байна. Дээрх арилжааг ангилал тус бүрээр нь авч үзвэл, 490.1 тэрбум төгрөг буюу 65.3 хувь нь овернайт зээл, 154.6 тэрбум төгрөг буюу 21.1 хувь нь ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа, 88.6 тэрбум төгрөг буюу 11.8 хувь нь Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны репо хэлцэл, 12.8 тэрбум төгрөг буюу 1.7 хувь нь банк хоорондын зээл байлаа.

Зураг БХЗ-ын арилжааны бүтэц

2005 оны банк хоорондын арилжааны хөдөлгөөнийг ажиглавал 9 дүгээр сард огцом өсч 120.6 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарт урьд өмнө байгаагүй хамгийн дээд хэмжээ юм.

Өмнөх онтой харьцуулахад репо арилжаа 4.3 дахин буурч, харин овернайт зээл 4.7 дахин өссөн байна. Банкууд овернайт зээлийг илүүд үзэх болсон гол шалтгаан нь тухайн хэрэгслийн түргэн шуурхай байдал бөгөөд репо хэлцэл хийхэд ямар нэг актив хөрөнгө тухайлбал, эзэмшиж буй үнэт цаас шаардлагатай бол овернайт арилжааны хувьд тийм зүйл шаардлагагүй байдаг явдал юм. Түүнчлэн зээл авч буй банкуудын дийлэнх нь жижиг банкууд байгаа бөгөөд эдгээр банкуудад репо хэлцэлд ашиглах үнэт цаас тэр бүр байдаггүйгээс овернайт арилжааг сонгоход хүргэж байна. Үүнээс

гадна манай санхүүгийн зах зээл дээр Засгийн газрын бондын арилжаа тогтмол явагддаггүй явдал мөн нөлөөлдөг.

2005 онд банкууд Төрийн сангаас 30.0 тэрбум төгрөгийн овернайт зээлийг авсан нь өмнөх онтой харьцуулахад 4.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Түүнчлэн банкууд 2.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй Засгийн газрын бондыг өөр хоорондоо репо хэлцлээр арилжаалжээ.

2005 онд банк хоорондын зах дээр хийгдсэн нийт арилжааны жигнэсэн дундаж хүү 9.25 хувь байгаа нь өмнөх оныхоос 5.11 нэгж, 2003 оныхоос 1.0 нэгжээр тус тус доогуур байна. Энэ нь тайлант онд банкуудын илүүдэл нөөц хэт их байсан болон Төв банкны үнэт цаасны хүү буурсантай холбоотой юм.

Хүснэгт 2005 оны банк хоорондын арилжааны хэмжээ, хүү, сараар

Монголбанкнаас 2005 онд 4 төрлийн хугацаатай (7, 14, 28, 91 хоногийн) нийт 1.4 их наяд төгрөгийн үнэт цаас гаргаж, банкуудад борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 38.9 хувь буюу 395.0 тэрбум төгрөгөөр өсчээ.

2005 онд Засгийн газар нийт 2 удаа 8.9 тэрбум төгрөгийн богино хугацааны үнэт цаасыг банкууд болон аж ахуйн нэгжүүдэд арилжаалж 329.3 сая төгрөгийн хүүний төлбөрийг төлсөн байна. Мөн 2005 оны 4 дүгээр сард Хадгаламж банкны эзэмшиж байсан 8.5 тэрбум төгрөгийн Засгийн газрын энгийн өрийн бичгийг 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 85.0 мянган ширхэг, 28-315 хоногийн хугацаатай, 13.3-15.22 хувийн хямдруулалтын хүүтэй Засгийн газрын богино хугацааны хямдруулсан бонд болгож сольжээ. Засгийн газрын энгийн өрийн бичгийг сольсон дээрх бондоос 5,6,7 дугаар сард хуваарийн дагуу тус бүр 500.0 сая төгрөг, 9 дүгээр сард 1.0 тэрбум төгрөг, 10, 12 дугаар сард тус бүр 2.0 тэрбум төгрөг төлөгдсөн ба тайлант оны эцэст үлдэгдэл нь 2.0 тэрбум төгрөг байв.

Сүүлийн жилүүдэд банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хурдацтай өсөлт, төлбөрийн чадвар болон бие даасан байдал нь санхүүгийн зуучлалыг улам гүнзгийрүүлэн, хөрөнгийн үр ашигтай хуваарилалт банкны салбараар дамжих болж, бодит эдийн засгийн бүтээлч хэсгийг урамшуулан дэмжих зах зээлийн нөхцөл болсоор байна. Санхүүгийн салбар эдийн засгийг дэмжиж буйн илрэл нь банкнаас бодит секторт олгосон зээл болон банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт бөгөөд банкуудын зээлийн хүү тогтмол буурч ирсэн явдал юм.

Хөрөнгийн зах зээл

Тайлант оны эцсээр Монголын хөрөнгийн бирж (МХБ)-д нийт 392 хувьцаат компанийн 2.2 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байсан бөгөөд тухайн хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ нь 55.7 тэрбум төгрөг буюу сүүлийн 8 жилд байгаагүй хамгийн өндөр түвшинд хүрчээ. Энэ нь хувьцааны тооны өсөлттэй холбоотой боловч гол нь өмнөх 2 жилийн турш тасралтгүй буурч байсан хувьцааны үнийн бууралт тайлант онд зогсож, хувьцааны үнийн нийт үнэлгээ өсч эхэлснээс шалтгаалав. Нийт бүртгэлтэй компаниудын 16.8 хувь буюу 66 нь төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани байгаа бөгөөд 2005 онд нийт үнэт цаасны арилжаанд сард дунджаар 60-108 компани оролцож байжээ.

Зураг Хөрөнгийн зах зээлийн хувьцааны нийт үнэлгээ, сая төгрөгөөр

Үнэт цаасны арилжаа

2005 оны санхүүгийн жилд МХБ дээр үнэт цаасны 253 удаагийн арилжаагаар 25.9 сая ширхэг хувьцаа, 121 удаагийн арилжаагаар 305.3 мянган ширхэг компанийн бонд, 1 удаагийн арилжаагаар 70.0 мянган ширхэг Засгийн газрын бонд арилжаалагдаж, нийт 12.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Нийт үнийн дүнгийн 56.7 хувийг Засгийн газрын бондын арилжаа, 22.5 хувийг компанийн бондын арилжаа, 20.8 хувийг хувьцааны арилжаа тус тус эзэлж байна. Харин Засгийн газрын бондын арилжааны үнийн дүн өмнөх оныхоос 45.7 хувь, компанийн бондын арилжаа 4.1 хувиар тус тус буурсан бол хувьцааны арилжааны үнийн дүн 2.9 дахин өслөө.

Хүснэгт Арилжааны гүйлгээний дүн

Бондын арилжаа

МХБ 28, 56, 91, 147, 203 хоногийн хугацаатай нийт 6.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий 70 мянган ширхэг Засгийн газрын хямдруулсан бондын арилжааг 2005 оны 2 дугаар сарын 7-ны өдөр явуулсан байна. Арилжаанд зөвхөн банкууд оролцжээ. Компанийн бондын арилжаагаар “Шинэ зуун” бондоос 2.4 мянган ширхэгийг 237.5 сая төгрөгөөр, “Нийслэл өргөө” бондоос 8.2 мянган ширхэгийг 400.9 сая төгрөгөөр, “Пума” бондоос 46.6 мянган ширхэгийг 465.7 сая төгрөгөөр, “Анод” бондоос 12.2 мянган ширхэгийг 121.8 сая төгрөгөөр, “Говь” бондоос 100.0 мянган ширхэгийг 1.0 тэрбум төгрөгөөр, “Бүтээн байгуулалт” бондоос 37.2 мянган ширхэгийг 371.5 сая төгрөгөөр тус тус арилжаалсан нь дийлэнх хувийг эзэлж байна.

Хувьцааны арилжаа

Тайлант онд өдөрт дунджаар 102.6 мянган хувьцаа арилжаалагдаж, 10.1 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж байсан бөгөөд тоо ширхэгээр идэвхтэй арилжаалагдсан үнэт цаасанд Техник импорт, УБ БҮК, Нефть импорт концерн, Борнуур, Багануур зэрэг хувьцаат компаниудын хувьцаа орж байна. Үнийн дүнгээр УБ БҮК, Нефть импорт концерн, Техник импорт, Монголын цахилгаан холбоо, Борнуур зэрэг хувьцаат компаниудын үнэт цаас идэвхтэй арилжаалагджээ.

Зураг. Хөрөнгийн захын Top-20 индекс

Топ-20 индексийн дундаж оны эцсийн байдлаар 995.3 нэгжид хүрсэн нь өмнөх оны сүүлчээс 404.6 нэгж буюу 68.5 хувиар өссөн байна. Энэ нь Техник импорт, Спирт бал бурам, Борнуур, Эрдэнэт хивс, Монголын цахилгаан холбоо, Авто дизель зэрэг хувьцаат компаниудын үнэт цаасны ханш өссөнтэй холбоотой байна.

Хөдөө аж ахуйн салбарын индекс 28.7 хувь, худалдаа үйлчилгээний салбарын индекс 8.2 хувь, уул уурхайн салбарын индекс 7.7 хувь, нэгдсэн индекс 3.0 хувиар тус тус өсч, аж үйлдвэр, барилгын салбарын индексүүд өөрчлөлтгүй байлаа. Төрийн өмчийн хорооны 2005 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн тогтоолыг үндэслэн МХБ-ийн 2005 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн үнэт цаасны арилжаагаар “Бэрх-уул” ХК-ийн нийт хувьцааны 33.0 хувь буюу төрийн мэдлийн 6.3 сая ширхэг хувьцааг нэг багц болгон нийт 94.4 сая төгрөгөөр арилжаалжээ.

Хүснэгт 3. Үнэт цаасны бүртгэлд гарсан өөрчлөлт

2005 онд хөрөнгийн зах зээл унтаа байдлаасаа сэргэх нааштай хандлага ажиглагдах болсон. Энэ нь хөрөнгийн зах дээрх нийт үнэлгээний дүн өмнөх онд байсан хамгийн доод цэгээсээ өсч нэг жилийн дотор сүүлийн жилүүдэд байгаагүй хамгийн өндөр түвшиндээ хүрсэн явдал юм. Мөн Топ-20 индексийн зах зээлийн үнэлгээ нэмэгдэж байгаа нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт болон мөнгөний зах дээр нийлүүлэлтийн илүүдэл үүсэж байгаатай холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээл дээр хувьцаа, бондыг эрэлхийлэх болсон нь тэдгээрийн үнэ ханшийг өсгөсөн байж магадгүй.

4. БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

Улсын хэмжээгээр 2005 оны эцсийн байдлаар 17 банк үйл ажиллагаа явуулж, бүх аймаг, хотуудын нутаг дэвсгэрт нийт 732 салбар нэгж (107 салбар, 590 тооцооны төв, 31 хадгаламжийн касс)-ээр дамжуулан харилцагчдад банкны үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 1. Банкуудын салбар нэгжийн тоо

Хүснэгт Банкуудад ажиллагсдын тоо

2005 оны байдлаар төрийн өмчит 1, төрийн өмчийн бага хэмжээний оролцоотой 2, хувийн 14 банк үйл ажиллагаа явуулж байна. Хувийн банкуудаас гадаадын хөрөнгө оруулалттай 6 (үүнээс хяналтын багц нь гадаадын хөрөнгө оруулагчдын мэдэлд байгаа 5) банк байна. 2002 оны байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкуудад банкны салбарын хадгаламжийн үлдэгдлийн 28.0 хувь, харилцахын үлдэгдлийн 10.0 хувь нь төвлөрч байсан бол 2005 оны байдлаар эдгээр үзүүлэлтүүд 10.8 болон 8.5 хувь болж буурсан байна.

Банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаа идэвхжиж, зээл олголт эрчимтэй өсч байгаа боловч аж үйлдвэрийн бүтээгдэхүүн буурсан байгаа нь зээлийн дийлэнх хэсэг аж үйлдвэрийн бус салбарт олгогдож байгаатай тодорхой хэмжээгээр холбоотой гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд банкууд шинэ техник технологийг өргөнөөр нэвтрүүлж, бэлэн бус төлбөр тооцоо болон интернэт банкны үйлчилгээг нэвтрүүлэх талаар эрчимтэй ажиллаж байна. Үүнээс гадна, банкууд санхүүгийн уламжлалт бүтээгдэхүүн болон зээл хадгаламжийн үйлчилгээний нэр төрөл, хэлбэрийг олшруулж, улмаар зах зээлийн оролцогч бүрт хүрч ажиллах талаар дорвитой арга хэмжээг авсаар ирлээ. Банкуудын үйлчилгээ ийнхүү өргөжсөн нь бичил санхүүгийн хөгжилд түлхэц үзүүлж, ядуурал ажилгүйдлийг бууруулахад жинтэй хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Түүнчлэн, банкны харилцах, хадгаламж, зээлийн үйлчилгээний нэр төрөл, урамшуулал нэмэгдсэнээр тайлант онд харилцах данс эзэмшигчдийн тоо 29.9 хувиар өсч 899.6 мянга, хадгаламж эзэмшигчдийн тоо 19.5 хувиар өсч 627.6 мянга, зээлдэгчдийн тоо 33.2 хувиар өсч 322.7 мянгад хүрч санхүүгийн үйлчилгээ улам өргөн цар хүрээтэй болж, иргэдийн банкинд итгэх итгэл дээшилж байна.

Үүнээс гадна, банкнаас бусад төрлийн санхүүгийн зуучлагчдын тоо огцом өсч, үйл ажиллагаа нь идэвхжсэн болно. Тухайлбал, 2001 онд ББСБ-ын тоо 24, хадгаламж зээлийн хоршооны тоо 78 байсан бол 2005 оны эцсээр эдгээр үзүүлэлтүүд харгалзан 150, 700 гаруй болтлоо өссөн байна. Санхүүгийн зах зээл дээр өрсөлдөөн нэмэгдэж байгаа тул банкуудад маркетингийн бодлогоо эргэн харах, боловсронгуй болгох шаардлага гарч байна. Энэ нь зарим банкуудын хувьд хадгаламжийн хүүний өсөлт хэлбэрээр илэрч байгаа нь нэг талаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын мөнгөн хуримтлалын орлогыг нэмэгдүүлэх давуу талтай, нөгөө талаас зээлийн хүүний бууралтад саад тотгор болж байна.

Банкны салбар

Банкны хямралын он жилүүдэд хэрэгжүүлж байсан төрийн мөнгөний бодлого нь санхүүгийн салбарын өрсөлдөөнийг дэмжихээсээ илүү санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бий болгох, банкны салбарын дэд бүтцийг боловсронгуй болгох асуудалд үндсэндээ чиглэгдэж байв. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд банкны салбар тогтворжих хандлагатай болж, санхүүгийн салбарын үр ашиг сайжирч, эрсдэлийг даах чадвар нь дээшиллээ.

Хүснэгт Банк санхүүгийн системийн үзүүлэлтүүд

Тайлант онд М2 мөнгөний нийлүүлэлт 38.1 хувиар өссөн бөгөөд М2 мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь өмнөх оноос 7.3 нэгжээр нэмэгдэн, 51.6 хувьд хүрсэн байна. Зээл болон ДНБ-ий харьцаа 2000 оноос хойш тогтмол өсч 2005 онд 37.9 хувьд хүрчээ. Нэрлэсэн үнээр тооцсон ДНБ өссөнөөс банкны салбарын өөрийн хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ өмнөх оноос 0.4 нэгжээр өсч 9.1 хувь боллоо. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банкууд дүрмийн сангаа 2006 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор 8.0 тэрбум төгрөгт хүргэхтэй холбоотойгоор банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ цаашид нэмэгдэх төлөвтэй байна. Банкны дүрмийн сангийн доод хэмжээг өсгөснөөр банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, иргэдийн банкинд итгэх итгэлийг дээшлүүлэх, банкнаас нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ ихсэх, санхүүгийн зуучлалыг арай өргөн хүрээтэй явуулах зэрэг ач холбогдолтой юм. Банкнаас гадуурхи мөнгөний ДНБ-д эзлэх хувь хэмжээ сүүлийн 4 жилд буурсан нь иргэд, аж ахуйн нэгжээс банкинд итгэх итгэл дээшлэн мөнгөн хөрөнгөө банкинд байршуулж, санхүүгийн зуучлалын цар хүрээ өргөжин тэлж байгаагийн илрэл юм.

Тайлант онд банкны салбарын нийт активын хэмжээ 42.9 хувь буюу 476.2 тэрбум төгрөгөөр өсч ДНБ-д эзлэх хувийн жин нь өмнөх оныхоос 11.9 нэгжээр өсч 69.9 хувьд хүрчээ. Активын өсөлтөд нийт хадгаламжийн үлдэгдэл 34.1 хувь буюу 176.5 тэрбум төгрөг (үүнээс иргэдийн хадгаламж 134.7 тэрбум төгрөг), харилцах 69.8 хувь буюу 129.9 тэрбум төгрөг, бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 76.5 хувь буюу 53.6 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 23.9 хувь буюу 40.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Ийнхүү нэмэгдсэн эх үүсвэрийн дийлэнх хэсгийг зээл олголтод зарцуулсан бөгөөд нийт активын өсөлтийн 53.1 хувийг зээлийн өсөлт эзэлж байна. Банкуудын активын нэг хэсэг болох өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө нийт дүнгээрээ буурч, харин бусад төрлийн актив өсөлттэй гарчээ. Банкны салбарын нийт активын 52.0 хувийг цэвэр зээлийн өрийн үлдэгдэл, 16.4 хувийг дотоод болон гадаадын банкуудад байршуулсан

хөрөнгө, 7.9 хувийг бэлэн мөнгө болон Монголбанкинд байршуулсан хөрөнгө эзэлж байгаа нь өмнөх оны байдалтай харьцуулахад бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин 3.5 нэгжээр өсч, бусад хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин ерөнхийдөө тогтвортой байв.

Банкуудын үйл ажиллагааны байдлаас харахад тайлант онд харилцах, хадгаламж хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсгийг зээлд байршуулж байгаа нь өмнөх жилүүдийн үйл ажиллагааны чиглэл хандлагатай ижил байгаа ч, зээлийн нэр төрлийг олшруулах, зориулалтыг өргөжүүлэх, хугацааг уртасгах, хүүг бууруулах хандлагатай байгаа нь тухайн жилийн онцлог юм. Өнгөрсөн онд банкуудын зээлийн өрийн үлдэгдлийн 19.4 хувийг 1 жилээс дээш хугацаатай зээл эзэлж байсан бол тайлант онд энэ үзүүлэлт 5.4 нэгжээр нэмэгдэж, 24.8 хувь болжээ. Мөн банкууд шинэ үйлчилгээ болон санхүүгийн шинэ бүтээгдэхүүн гаргаж байгаа нь нэг талаас уг үйл ажиллагаанаас олох орлогын нэр төрлийг олшруулах, нөгөө талаас харилцагчдыг татаж эх үүсвэрээ нэмэгдүүлэх бодлого юм.

Хүснэгт Зээл, чанаргүй зээл, хадгаламж, банкнаас гадуурхи мөнгө

Өмнөх оноос банкуудын нийт орлого 27.9 хувь, нийт зардал 28.6 хувиар тус тус өсч, үүний үр дүнд татварын өмнөх нийт ашгийн хэмжээ 23.6 хувиар нэмэгдэж 28.9 тэрбум төгрөг болсон байна. Үүнээс, Худалдаа хөгжлийн банк 7.3 тэрбум, Хөдөө аж ахуйн банк 4.6 тэрбум, Голомт банк 2.0 тэрбум, Хас банк 1.5 тэрбум, Зоос банк 1.3 тэрбум төгрөгийн ашигтай, харин Менатеп банк 0.2 тэрбум төгрөгийн алдагдалтай тус тус ажиллажээ. Сүүлийн 2 жилийн хугацаанд банкуудын зээлийн зарласан хүүний жигнэсэн дундаж болон бодит орлогоор тооцсон зээлийн дундаж хүүний хэмжээ буурч байгаа ч эх үүсвэрт зарласан хүүний түвшин буурахгүй байгаа нь банкууд хүүгээрээ өрсөлдөн эх үүсвэрээ нэмэгдүүлж, улмаар санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа өргөжүүлэн бэхжүүлэх сонирхолтой байгаатай холбоотой. Улмаар банкны салбарын активын өгөөжийн үзүүлэлт 2004 оноос 0.3 нэгжээр буурч 1.5 хувь боллоо.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засгийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр тэдгээрт санхүүгийн олон талт үйлчилгээ хэрэгцээтэй байгаагаас хамааран банкууд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ өргөжүүлж, зээлийн хүүгээс гадна тэдгээрийн шимтгэл хураамжаар орлогоо нэмэгдүүлэхэд түлхүү анхааран ажиллаж байна. Тухайлбал, банкуудын шимтгэлийн орлого өмнөх оноос 6.2 тэрбум төгрөг буюу 44.2 хувиар өсч 20.1 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт Орлого, зарлага

Банк бус санхүүгийн байгууллага

Тайлант онд 37 ХХК-д Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгож, харин нэг ББСБ өөр санхүүгийн байгууллагатай нэгдсэн тул банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 129 тоот тушаалаар хүчингүй болгосноор нийт 150 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын тоо 31.6 хувь буюу 36 ББСБ-аар нэмэгдсэн байна.

Зураг Үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын тоон өсөлт

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагааг ББСБ-уудын эрхэлж буй төрлөөр нь ангилж үзэхэд давхардсан тоогоор зээлийн үйл ажиллагаа 144, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа 50, итгэлцлийн үйл ажиллагаа 16, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа 13, факторингийн 5, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 19, цахим төлбөр тооцооны үйлчилгээ 1, санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээг 1 ББСБ тус тус дангаар буюу нэмэлт зөвшөөрлөөр эрхэлж байна.

Зураг ББСБ-уудыг дүрмийн сангийн хэмжээгээр нь ангилсан байдал

Тайлант онд Орхон, Дорнод, Увс, Говь-Алтай, Хөвсгөл, Баянхонгор, Архангай зэрэг аймгуудад тус тус нэг ББСБ шинээр үүсгэн байгуулагдаж, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо 23 болж, тэдгээрийн нийт актив 888.3 сая төгрөгт хүрсэн нь нийт ББСБ-ын активын 2.3 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ыг байршлын хувьд авч үзвэл, Дорнод аймагт 7, Дархан-Уул аймагт 3, Завхан, Архангай, Хөвсгөл аймагт тус бүр 2, Төв, Сэлэнгэ, Сүхбаатар, Орхон, Говь-Алтай, Увс, Баянхонгор аймагт тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Харин Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Ховд, Хэнтий аймагт ББСБ байгуулагдаагүй байна. Түүнчлэн Монголбанк гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих замаар банк бус санхүүгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулах бодлого баримтлан Олон улсын санхүүгийн байгууллага гэсэн эрх зүйн тусгай статустай ББСБ-ыг байгуулах ажлыг зохион байгуулж Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 574 тоот тушаалаар Империаал гоулд ХХК-д Олон улсын санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгов.

Тайлант онд гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай Футур эволюшн ХХК-д банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосноор гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо 13 болж, тэдгээрийн нийт актив 11.3 тэрбум төгрөгт хүрсэн нь ББСБ-ын нийт активын 29.5 хувь, дүрмийн сангийн хэмжээ нь 7.3 тэрбум төгрөг байгаа нь ББСБ-ын нийт дүрмийн сангийн 28.6 хувийг тус тус эзэлж байна.

Дээрх ББСБ-уудыг харьяаллаар нь авч үзвэл, Европын Холбооны “ТАСИС” хөтөлбөр болон “Дэлхийн Зөн” Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 2, гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 10 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Мөн Япон улсын хөрөнгө оруулалттай 3, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хөрөнгө оруулалттай 2, БНХАУ-ын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 2, БНСУ, ОХУ болон Италийн 100 хувийн хөрөнгө оруулалттай 3 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Мөн ББСБ-ууд Монгол улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацитай хамтран хэрэгжүүлж буй Тогтвортой амьжиргаа төслийн Бичил санхүүгийн хөгжлийн сан, Япон улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах сангийн Гэр хорооллын нөхцөлийг сайжруулах зэрэг хөтөлбөр, төслүүд бичил санхүүгийн байгууллагуудаар дамжин нийгмийн эмзэг бүлгүүдийн өрхийн орлого болон ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллаж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан боловч үйл ажиллагаа явуулж эхлээгүй 22 ББСБ-ын тайлан тэнцлийн үзүүлэлтийг нэгтгэлд хамруулсан нь нийт ББСБ-ын 14.7 хувийг эзэлж байна.

Тайлант онд Улаанбаатар хот, орон нутаг дахь ББСБ-ын нийт салбар, нэгжийн тоо 34 болсон байна.

Хүснэгт Салбар, нэгжийн байршлын судалгаа

Тайлант оны эцэст ББСБ-уудын нийт хувь нийлүүлэгчдийн тоо 411, нийт ажиллагсдын тоо 546 гаруйд хүрчээ. Мөн давхардсан тоогоор 51.2 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээг үзүүлжээ.

ББСБ-уудын олгож буй зээлийн хүүний түвшин дунджаар сарын 3.0-3.5 хувь, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүний түвшин дунджаар сарын 0.5-2.0 хувь байна.

Тайлант онд нийт эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт актив өмнөх оны мөн үеэс 34.0 хувь буюу 9.8 тэрбум төгрөгөөр өсч 38.4 тэрбум төгрөгт хүрч, нийт активын бүтцэд дараахь өөрчлөлтүүд оржээ. Тухайлбал, нийт эх үүсвэр нэмэгдсэнээр хүүний орлого авчирдаг активын үлдэгдэл 17.1 тэрбум төгрөгөөс 19.3 тэрбум төгрөг болж өссөн ч хурдац нь нийт активын өсөлтийн хурдцаас бага байгаагаас нийт активт эзлэх хувийн жин нь 59.5 хувиас 50.2 хувь болж буурсан, харин мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж, нийт активт эзлэх хувийн жин 28.6 хувиас 37.4 хувь хүртэл өссөн байна. Түүнчлэн ББСБ-ууд үндсэн хөрөнгө нэмж бэлтгэсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгө 1.9 тэрбум төгрөгөөс 2.8 тэрбум төгрөг болж, түүний нийт активт эзлэх хувийн жин нь 6.9 хувиас 7.3 хувь, эрсдэлийн зардлын нийт активт эзлэх хувийн жин 2.7 хувиас 2.8 хувь болж тус тус өсөв.

ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 2.4 хувьтай тэнцэж байгаа ба нийт активын өгөөж 3.6 (ROA) хувь байна.

ББСБ-уудын тайлант жилийн нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараахь байдалтай байна.

Тайлант онд нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 34.0 хувь буюу 9.8 тэрбум төгрөгөөр өсч 38.4 тэрбум төгрөгт хүрсэн нь үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын тоо 150 болж өссөн, дүрмийн сангийн нийт хэмжээ 17.8 тэрбум төгрөгөөс 25.3 тэрбум төгрөгт хүрсэнтэй холбоотой байна.

Нийт эх үүсвэрийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараахь өөрчлөлтүүд орсон байна. Үүнд, өөрийн хөрөнгийн өсөлтийн хурд нийт эх үүсвэрийн өсөлтийн хурдаас их байгаагаас өөрийн хөрөнгийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 72.4 хувиас 79.1 хувь болж өссөн, харин нийт өр төлбөрийн үлдэгдэл дорвитой нэмэгдээгүйгээс нийт активт эзлэх хувийн жин 27.6 хувиас 20.9 хувь болж буурчээ.

Нийт эх үүсвэрийн 79.1 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж байгаа нь нэг талаас Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу ББСБ нь зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхэлнэ гэсэнтэй нийцэж байгаа, нөгөө талаас бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх явц нь зохистой түвшинд байгааг харуулж

байна. Өөрийн хөрөнгө нийт банкны салбарын 14.7 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн өгөөж 4.8 (ROE) хувь байна.

ББСБ-ууд зөвхөн өөрийн хөрөнгөөр төдийгүй бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөтгөхийн тулд банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, төсөлд хамрагдах, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх сонирхол өсч байгаагаас эх үүсвэрийн нийт хэмжээ цаашид өсөх хандлагатай байна. Энэ нь хэдийгээр санхүүгийн зуучлалыг нэмэгдүүлж буй боловч хүлээж болзошгүй эрсдэл үүсэх, нэмэгдэх, цаашид санхүүгийн хямралыг үүсгэж болзошгүй юм.

Мон-Арвиссан (321.6 сая төгрөг), Батс кредит (73.1 сая төгрөг), Дельтасан (427.6 сая төгрөг), Хатан сүлд (205.3 сая төгрөг) зэрэг 8 ББСБ нийт 1.1 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Гэвч итгэлцлийн үйл ажиллагааны хууль эрх зүйн орчин тодорхой бус байгаагаас ББСБ итгэлцлийн үйлчилгээг бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх хадгаламж хэлбэрт шилжүүлж байгаа зөрчил гарч байна.

ББСБ-уудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 461 тоот тушаалаар шинэчлэн Улаанбаатар хотод 200.0 сая төгрөг, Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр суманд 100.0 сая төгрөг, бусад аймгийн төвд 10.0 сая төгрөгөөр, мөн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ-ын хувьд дүрмийн сангийн доод хэмжээг 500.0 сая төгрөгөөр тогтоов.

Цаашид санхүүгийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалыг өргөжүүлэх, шударга өрсөлдөөнийг бий болгох асуудлыг төрөөс зохицуулснаар, санхүүгийн зуучлалыг олон улсын стандартын дагуу сонгодог утгаар нь гүнзгийрүүлэн хөгжүүлэх, санхүүгийн салбар дахь эрсдэлийг бууруулах чухал алхам болох юм.

ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 1.2 тэрбум төгрөгийн татварын дараахь цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.2 хувь буюу 160.6 сая төгрөгөөр буурчээ. Энэ нь ББСБ-уудын үйл ажиллагааны цар хүрээ өсч, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр нэмэгдэн, санхүүгийн зуучлалын хүрээ өргөжсөнөөр нийт зардал өссөнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, нийт орлогын өсөлтийн хурд нийт зардлын хурдаас бага байгааг харуулж байна.

Тайлант онд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 112 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 74.7 хувийг эзэлж байна. Тэдгээрийн ашиг 0.1 мянган төгрөгөөс 130.3 сая төгрөгийн хооронд хэлбэлзэв. Харин нийт ББСБ-уудын 16.0 хувь буюу 24 ББСБ нь алдагдалтай ажилласан байна. Эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамааран үйл ажиллагааны зардал өндөр, зээлийн чанар муудсанаар эрсдэлтэй холбоотой зардал өссөн, орлогын өсөлт зардлын өсөлтөөс бага, үйл ажиллагаа жигдрээгүй зэргээс алдагдалтай ажиллажээ.

ББСБ-ууд нийт 798.2 сая төгрөгийн ашгийг хуримтлуулан тооцсон ба тухайн үед ашигтай ажилласан нийт 112 ББСБ-уудын дундаж ашиг 12.0 сая төгрөг байна.

Нийт орлого тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 13.9 хувь буюу 0.9 тэрбум төгрөгөөр өсч 7.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 34.0

хувь буюу 9.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр хүүний орлого авчирдаг актив 19.3 тэрбум төгрөг болж өссөнөөс шалтгаалжээ.

Нийт орлогын 64.6 хувийг зээлийн хүүний орлого эзэлж байна. Гэвч өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогод зээлийн хүүний орлогын эзлэх хувийн жин 67.8 хувиас 64.6 хувь хүртэл буурч, харин гадаад валютын ханшийн тэгшитгэл, арилжааны орлого, мөнгөн гуйвуулгын болон бусад орлогын нийт орлогод эзлэх хувийн жин өсчээ. Энэ нь ББСБ-уудын эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, зээлийн үйл ажиллагаанаас гадна бусад орлогын эх үүсвэр нэмэгдсэнийг харуулж байна.

Нийт зардал өмнөх оны мөн үеэс үйл ажиллагааны цар хүрээ өргөжсөн, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор зардал зүйл тус бүрээр өсч 6.4 тэрбум төгрөгт хүрч, нийт зардал өмнөх оны мөн үеэс 20.4 хувь буюу 1.1 тэрбум төгрөгөөр өсөв.

Нийт зардлын өсөлтийн шалтгаан нь нэгдүгээрт, ББСБ-ууд итгэлцлийн үйлчилгээгээр санхүүгийн эх үүсвэр бусдаас татан төвлөрүүлж байгаа, банк, санхүүгийн байгууллагаас зээл авах хандлага нэмэгдсэн, дамжуулан зээлдүүлэх төсөлд хамрагдах ББСБ-уудын тоо өссөн зэрэг обьектив хүчин зүйлээс шалтгаалж хүүний зардал өссөн, хоёрдугаарт, үйлчилгээний цар хүрээ өргөжсөн болон ББСБ-уудын механик тоон өсөлттэй уялдан үйл ажиллагааны болон боловсон хүчинтэй холбоотой зардал нэмэгдсэн, гуравдугаарт, гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж ханшийн тэгшитгэл, гадаад валютын арилжаанаас хүлээх алдагдал нэмэгдсэн, дөрөвдүгээрт, зээл болон зээлтэй адилтган тооцох активын хэмжээ нэмэгдсэн, активын чанар муудаж байгаагаас болзошгүй эрсдэлийн сангийн зардал өссөн зэрэгтэй холбоотой байна. ББСБ-ууд 285.7 сая төгрөгийн татвар төлжээ.

5. ТӨВ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мөнгөний бодлогын хэрэгжилт

2005 онд мөнгөний зах зээл дээр бий болсон нөхцөл байдлыг бүхэлд нь тоймлож хэлбэл банкны салбар дахь хадгаламжийн хэмжээ асар хурдтай нэмэгдэж, банкуудын активт хувиргах чадварын хурдаас давж гарсны улмаас мөнгөний зах зээл дээр гол үүрэг гүйцэтгэгч банкны салбар байнгын илүүдэл нөөцтэй байснаараа өмнөх жилүүдтэй харьцуулахад онцлог байлаа. Нөгөө талаас, шатахууны үнийн өсөлтөөс үүдэлтэй хэрэглээний барааны үнийн өсөлт эхний хагас жилд эрчимтэй явагдсан, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш харьцангуй тогтвортой хэрнээ чангарах талдаа байсан, зээлийн хүүний ерөнхий түвшин буурсан зэрэг нь тайлант жилийг улам сонирхолтой болголоо.

Хэрэглээний барааны үнэ өсч 6 дугаар сард хамгийн өндөр түвшинд буюу жилд шилжүүлснээр 17.8 хувьд хүрсэн нь сүүлийн 5 жилд байгаагүй өндөр хувь байв. Энэ үед Төв банкнаас мөнгөний хатуу бодлого явуулж байсан хэдий ч мөнгөний зах зээл дээрх бэлэн нөөцийн хэмжээ их, банкууд тогтмол илүүдэл нөөцтэй байх болсон нь Төв банкиг үүссэн нөхцөл байдалд тохируулан арай өөрөөр хандахад хүргэсэн юм. Өөрөөр хэлбэл бодлогоо чангаруулахын тулд өөрийн үнэт цаасны хүүгээ өсгөх ёстой хэдий ч илүүдэл нөөц зах зээл дээр их хэмжээгээр байх болсноос ТБҮЦ-ны хүү нь үнэт цаасны өндөр эрэлтээс үүдэн эрчимтэй буурах болсон билээ. Иймээс Монголбанк нь мөнгөний бодлогыг тухайн үеийн мөнгөний агрегатуудын хэмжээн дээр

тулгуурлан уян хатан хэлбэрээр явууллаа. Банкууд заавал байлгах нөөцийн шаардлагаа хангаад, илүүдэл нөөцтэй үлдэж байсан тул ТБҮЦ-ны эрэлт өсч, улмаар ТБҮЦ-ны хүү ихээхэн хувиар буурсан. Үүний зэрэгцээ ТБҮЦ-ны хүү нь мөнгөний зах зээл дээрх бусад арилжааны суурь хүү болж байдгаас хүүний энэхүү бууралт нь банк хоорондын мөнгөний зах зээлийн хүүний түвшинг мөн л ихээхэн хэмжээгээр буурахад хүргэсэн билээ.

Инфляцид хамгийн нөлөөтэй мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсэг болох банкнаас гадуурхи мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувийн жин тогтвортой буурч оны эцэст 54.2 хувьд хүрчээ. Банкнаас гадуурхи мөнгөний өсөлт буурахын хэрээр банкуудын нөөцийн өсөлт нэмэгдэж, тайлант оны эцэст нөөц мөнгөний 45.8 хувийг эзлэх болов. Монголбанк нөөц мөнгөний хөдөлгөөнийг богино хугацаанд оновчтой зохицуулах үүднээс банкны салбарын илүүдэл нөөцийн хэмжээнд хяналт тавин, богино хугацаанд төлөвлөж ажилладаг. Ийнхүү илүүдэл нөөцийн хэмжээг төлөвлөх нь нөөц мөнгийг хянах, улмаар мөнгөний үржүүлэгчээр дамжуулан нийт мөнгөний нийлүүлэлтийг төлөвлөх боломжтой болдог.

Нөөц мөнгө

2005 онд нөөц мөнгөний өсөлт өмнөх оныхоос 2.7 нэгжээр өсч жилийн 19.7 хувьд хүрчээ. Банкнаас гадуурхи мөнгөний өсөлт 6.2 хувь болж, 3.0 нэгжээр буурав. Банкнаас гадуурхи мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувийн жин 1996 оноос эхлэн тогтвортой буурч байгаа бөгөөд 2005 онд энэхүү хандлага мөн үргэлжилж 1996 оны түвшингээс 27.3 нэгжээр бууран оны эцэст 54.2 хувьд хүрчээ. Банкнаас гадуурхи мөнгөний өсөлт буурахын хэрээр банкуудын нөөцийн өсөлт нэмэгдэж, тайлант онд нөөц мөнгөний өсөлтийн дийлэнх буюу 81.0 хувийг эзлэх боллоо.

Зураг Засварласан улирлын хэлбэлзлийн индексүүд

Санхүүгийн зуучлалын цар хүрээ тэлж, улмаар банкуудын нөөцийн өсөлт нэмэгдэн, банкнаас гадуурхи мөнгөний өсөлт буурахын хэрээр нөөц мөнгөний улирлын хэлбэлзлийн хандлага сүүлийн жилүүдэд ерөнхийдөө буурсаар байгааг эхний зургаас харж болох юм. Тайлант онд ч мөн энэ байдал хадгалагдлаа. Гэхдээ банкуудын нөөцийн хувьд улирлын нөлөөллөөс үүдэлтэй хэлбэлзэл 2000 оноос хойш ихэссэн дүр зураг ажиглагдаж байна. 2000 оноос эхлэлтэй тэрхүү хэлбэлзлийн гол шалтгаан нь банкуудын зээл олголт буурдаг 1, 2 дугаар сард илүүдэл нөөц хэт их байсан явдал юм. 2005 оны 2 дугаар сард энэхүү нөлөөлөл сүүлийн 9 жилд байгаагүй хамгийн өндөр түвшинд хүрсэн нь өмнө бид 2005 оныг илүүдэл нөөц ихтэй онцлог цаг хугацаа хэмээн дүгнэж байсныг нотолно.

Банкнаас гадуурхи мөнгөний гол онцлог бол жил бүрийн 4 дүгээр сараас эхэлж өссөөр 8 дугаар сард оргилдоо хүрдэг бөгөөд энэ байдал сүүлийн 8 жилийн турш давтагдаж тайлант оныг ч мөн хамарлаа.

2005 онд банкнаас гадуурхи мөнгөний улирлын хэлбэлзлийг даган нөөц мөнгө жилийн эхний 3 сард дундаж түвшингээсээ 4.1-6.0 хувиар доогуур, 4-6 дугаар саруудад дундаж түвшнийхээ орчимд, 7-9 дүгээр саруудад дунджаасаа 4.7-8.1 хувиар өсч, оны сүүлийн 3 сард дунджаасаа 2.1-7.9 хувиар доор түвшинд хүрч хэлбэлзсэн байна.

Тайлант онд Монголбанк нөөц мөнгөний төлөвлөлтийг сайжруулах, түүний мэдээллийн эх үүсвэрийг тогтмолжуулах чиглэлд үргэлжлүүлэн анхаарч ажилласны үр дүнд нөөц мөнгөний жилийн өсөлтийг 20 хувь дотор барих өөрийн зорилтдоо хүрч чадсан юм.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг сааруулах үүднээс Монголбанк оны туршид өдөрт дунджаар 77.0 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг банкуудад байршуулж байсан нь өнгөрсөн оны дунджаас 53.1 хувиар өсчээ.

Монголбанк нь өөрийн үнэт цаасны арилжааг дуудлага худалдааны зарчмаар буюу банкуудын худалдан авах захиалга өгсөн үнэт цаасны хамгийн бага хүүний саналаас эхлэн нийт гаргасан хэмжээ хүртэл хуваарилах замаар явуулж банк тус бүрт өөр өөрсдийн захиалсан үнийн дүнгээр үнэт цаасыг худалдаж байлаа.

2005 онд нийт 97 удаа ТБҮЦ-ны арилжаа явуулж, 1.4 их наяд төгрөгийн нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 1409.5 тэрбум төгрөгөөр борлуулсан байна. Оны эцэст Монголбанкнаас худалдсан үнэт цаасны хэмжээ 126.0 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайлант оны туршид Монголбанкнаас зарласан ТБҮЦ-ны гаргах хэмжээ өдөрт дунджаар 81.3 тэрбум төгрөг байсан бол банкуудын ирүүлсэн саналын өдрийн дундаж нь 96.4 тэрбум төгрөг байв.

ТБҮЦ-ны хүүний түвшин ямар байхаас шалтгаалж мөнгөний зах зээлд оролцогчид санхүүгийн шийдвэрээ гаргадаг тул уг хүү нь мөнгөний зах зээл дээр чухал үүрэг гүйцэтгэдэг. 2005 онд ТБҮЦ-ны өдрийн жигнэсэн дундаж хүү 8.58 хувь байсан нь өмнөх онтой харьцуулахад 4.1 нэгжээр буюу 1.5 дахин буурчээ. 2005 оны эцсийн байдлаар ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 4.75 хувь байсан нь 2004 оныхтой харьцуулахад 11.0 нэгжээр буюу 3.3 дахин, 2003 оныхоос 6.7 нэгжээр буюу 2.4 дахин доогуур түвшинд байна. Тайлант онд Монголбанк өөрийнхөө үнэт цаасны хүүд нийт 6.0 тэрбум төгрөг төллөө.

2005 онд ТБҮЦ-ны хоёрдогч зах дээр нийт 214 удаа 327.8 тэрбум төгрөгийн арилжаа хийгджээ. Үүнээс 115 удаагийн арилжаагаар 190.6 тэрбум төгрөгийн үнэт цаасыг банкууд хоорондоо арилжиж, 99 удаагийн арилжаагаар 137.2 тэрбум төгрөгийн үнэт цаасыг репо нөхцлөөр арилжааллаа. Өмнөх онтой харьцуулбал банкуудын хооронд арилжаалсан үнэт цаасны хэмжээ 72.0 хувь буюу 79.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, репо нөхцлөөр арилжаалсан үнэт цаас 62.5 хувь буюу 228.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү

Зураг Монголбанкнаас зарласан гаргах хэмжээ болон банкуудын ирүүлсэн санал

Заавал байлгах нөөц

Монголбанк нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, нөөц мөнгөөр дамжуулан мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах зорилгоор банкуудын бусдаас татан

төвлөрүүлсэн хөрөнгийн 14.0 хувийг заавал байлгах бэлэн нөөц хэлбэрээр байршуулах шаардлагыг тавьж биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Монголбанк нь 2005 оныг хүртэл заавал байлгах нөөцийг тооцож хяналт тавих, нөөц дутагдуулсанд ногдуулах торгуулийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2001 онд баталсан журмын дагуу явуулж байсан бөгөөд 2005 онд уг журмын заалтыг улам тодорхой, боловсронгуй болгож зарим заалтуудын хоёрдмол утгыг арилгах зэргээр тодорхой өөрчлөлтүүдийг оруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 397 тоот тушаалаар шинэчлэн мөрдөх боллоо. Шинэчилсэн журмын дагуу банкны салбарын хэмжээгээр банкуудын заавал байлгах нөөц 2005 онд сар бүр хангагдаж байсан бөгөөд банкууд Монголбанк дахь харилцах дансандаа өдөрт дунджаар 43.3 тэрбум төгрөг байлгахад 58.9 тэрбум төгрөгийг байлгаж салбарын хэмжээнд өдөр бүр дунджаар 15.6 тэрбум төгрөгийн илүүдэл нөөцтэй байв. Энэ нь урд оныхоос 8.4 тэрбум төгрөгөөр илүү байлаа. Тайлант онд заавал байлгах нөөцийг дутагдуулсан 6 банкинд 14 удаа нийт 16.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан.

Зураг Заавал байлгах нөөцийн хангалт 2005 он

2005 онд заавал байлгах нөөцийн хэмжээ 2004 оны дундажтай харьцуулахад 25.0 хувь, банкуудын байгаа нөөц 41.0 хувь, харин илүүдэл нөөц 2 дахин өсчээ. Энэ нь банкууд дахь харилцах, хадгаламжийн хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөн нэмэгдэж байгаатай шууд холбоотой буюу бүр тодруулбал манай улсын иргэд, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө нэмэгдэж, үйл ажиллагаа нь томорч буйн тод илрэл юм. Нөгөө талаас, илүүдэл нөөц ийнхүү их хэмжээтэй байсан нь банкууд нөөцөө үр ашигтай байршуулж чадахгүй байгааг илэрхийлэхийн зэрэгцээ манай орны санхүүгийн зах зээл дээр боловсронгуй найдвартай хэрэгсэл болон бүтээгдэхүүн дутагдаж байгааг гэрчилж байна. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн сул байдал ч үүнтэй холбоотой. Иймд дотоодод бий болсон нөөц бололцоогоо бүрэн ашиглах, санхүүгийн зах зээлийг гүнзгийрүүлэн хөгжүүлж боловсронгуй болгох тал дээр Монголбанк, Засгийн газар болон банкууд идэвх санаачилга гарган ажиллах шаардлагатай байна.

Зураг Заавал байлгах нөөцийн хангалт 2003, 2004, 2005 онуудад

Төв банкны санхүүжилт

Төв банкны санхүүжилт нь мөнгөний бодлогын нэг гол хэрэгслийн хувьд уг санхүүжилтийнхээ хүүгээр дамжуулж зах зээлд дохио өгөх зарчмаар нөөц мөнгө, улмаар мөнгөний нийлүүлэлтийг зохицуулж байдаг. Гэвч сүүлийн жилүүдэд манай орны банк, санхүүгийн салбарт үүссэн байдал нь энэхүү хэрэгсэл ашиглагдахгүй байх нөхцлийг бий болгоод байна. Тодруулж хэлбэл, банкинд байршуулах хадгаламжийн хэмжээ асар хурдтай өсөн нэмэгдэж улмаар банкуудын зээлжүүлэх чадварын хурдаас давж гарсан нь тэдэнд илүүдэл нөөцийг бий болгож банкуудад эх үүсвэрийн дутагдал үүсэхээргүй болсон юм. Иймээс богино хугацаанд түр зуурын дутагдалд орсон банк нь бусад илүүдэл нөөцтэй банкнаасаа зээл авах замаар банк хоорондын захаас дутагдлаа хялбархан нөхөж байсан тул Монголбанкнаас санхүүжилт авах шаардлага тэдэнд огт байгаагүй юм. Нөгөө талаар, Монголбанк ч салбарын хэмжээгээр илүүдэл нөөц ихтэй нөхцөлд Төв банкнаас санхүүжилт хийхгүй байх бодлого баримталж, аль болох банк хоорондын захаас шаардлагатай эх үүсвэрээ олж авах нөхцлийг бүрдүүлэх

зорилгоор өөрийн санхүүжилтийн хүүгээ өндөр түвшинд байлгаж байв. Ийнхүү 2005 онд Төв банкны аливаа санхүүжилт хийгдээгүй бөгөөд үүний оронд банк хоорондын мөнгөний зах идэвхтэй ажиллаж овернайт, репо, ТБҮЦ-ны хоёрдогч хэлцэл зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг түлхүү хэрэглэсэн байна.

Банкны салбар дахь Засгийн газрын цэвэр зээл

Тайлант оны эцэст банкны салбарын нэгдсэн дүнгээр Засгийн газраас авах авлага 102.5 тэрбум төгрөг, Засгийн газрын хадгаламж 146.4 тэрбум төгрөг болж, цэвэр зээлийн хэмжээ сөрөг 43.8 тэрбум төгрөгт хүрэв. Өнгөрсөн оныхоос Засгийн газрын хадгаламж 50.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, харин Засгийн газраас авах авлага 34.0 тэрбум төгрөг, цэвэр зээл 84.4 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Засгийн газраас авах авлага

Засгийн газраас авах авлагын 96.9 хувь буюу 99.4 тэрбум төгрөгийг Монголбанкны авлага, үлдэх 3.1 хувь буюу 3.1 тэрбум төгрөгийг банкуудын авлага эзэлж байна.

Бүтцийн хувьд 92.0 хувь нь Оросын Холбооны Улсад төлөх их өрийг барагдуулахад зориулан олгосон зээлийн Сангийн яамнаас авах Монголбанкны авлага, 4.9 хувь нь Монголбанкны 2003 оны цэвэр орлогын тооцооноос үүссэн авлага, 2.0 хувь нь Хадгаламж банкинд байршиж буй банкны бүтцийн өөрчлөлтийн өрийн бичгийг сольсон богино хугацааны хямдруулсан бонд, 0.6 хувь нь банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн татвар, 0.4 хувь нь Худалдаа хөгжлийн банкинд байршиж буй банкны бүтцийн өөрчлөлтийн Засгийн газрын энгийн өрийн бичиг, 0.2 хувь нь банкуудын Засгийн газраас авах авлагад хуримтлуулж тооцсон хүү байна.

(1) Их өрийг барагдуулахад зориулан олгосон зээлийн тооцоогоор Засгийн газраас авах Монголбанкны авлага

Оросын Холбооны Улсад төлөх их өрийг хөнгөлөлттэй нөхцлөөр барагдуулахад Монголбанкнаас Засгийн газарт 2003 оны 12 дугаар сард олгосон 137.0 сая ам. долларын зээлээс 2004 онд 37.0 сая ам. доллар, 11.7 тэрбум төгрөг төлөгдсөн бол 2005 онд 11.2 сая ам. доллар төлөгдлөө. 2005 оны жилийн эцсийн байдлаар уг зээлийн үлдэгдэл 77.29 сая ам. доллар (94.4 тэрбум төгрөг) болж буурав. Хүүгүй байсан уг авлагыг Улсын Их Хурлын 2005 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор жилийн 1 хувийн хүүтэй болгосон байна.

(2) Монголбанкны цэвэр орлогын тооцооноос үүссэн авлага

Монголбанк 2003 оны үйл ажиллагаагаар ашиггүй гарч байсан хэдий ч тухайн жилийн улсын төсвийн төлөвлөгөөнд тусгагдсан байдлыг харгалзан цэвэр орлогын урьдчилгаа болгон 5.0 тэрбум төгрөгийг 2003 оны 12 дугаар сард Сангийн яаманд шилжүүлсэн байна. Үүнтэй холбогдуулан уг 5.0 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Монголбанкнд буцаан өгөхөөр шийдвэрлэсэн бөгөөд 2005 оны жилийн тайланд Монголбанк Засгийн газраас авах авлагад бүртгэв.

(3) Банкны бүтцийн өөрчлөлтийн Засгийн газрын энгийн өрийн бичиг (ББӨЗГЭӨБ) ба түүнийг сольсон богино хугацааны хямдруулсан бонд

2005 оны жилийн эцэст ББӨЭӨБ-ийг сольсон богино хугацааны хямдруулсан бондын хэмжээ 2.0 (Хадгаламж банк эзэмшиж байгаа) тэрбум төгрөг, банкны бүтцийн өөрчлөлтийн Засгийн газрын энгийн өрийн бичгийн дүн 372.8 сая төгрөг (Худалдаа хөгжлийн банкинд байршиж байгаа) байна.

А/ Хадгаламж банкны эзэмшиж буй ББӨЗГЭӨБ-ийг сольсон богино хугацааны хямдруулсан бонд

Сангийн сайдын 2005 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 82 тоот тушаалаар Хадгаламж банкны эзэмшиж байсан 8.5 тэрбум төгрөгийн Засгийн газрын энгийн өрийн бичгийг Засгийн газрын богино хугацааны хямдруулсан бондоор сольжээ. Энэхүү бонд нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 85,000 ширхэг, 28-315 хоногийн хугацаатай, 13.3-15.22 хувийн хямдруулалтын нөхцөлтэй байв.

Засгийн газрын энгийн өрийн бичгийг сольсон дээрх бондоос тайлант онд 6.5 тэрбум төгрөг төлөгдөн жилийн эцэст үлдэгдэл нь 2.0 тэрбум төгрөг болж буурлаа.

Б/ Худалдаа хөгжлийн банкинд байршиж буй энгийн өрийн бичиг

Худалдаа хөгжлийн банкинд банкны хуучин системээс шилжсэн болон зах зээлийн өмнөх тогтолцооны үед Засгийн газрын шийдвэрээр олгосон 1.7 тэрбум төгрөгийн зээлийг 1997 оны 7 дугаар сарын 14-ний өдөр Сангийн сайдын 234 тоот тушаалаар ББӨЭӨБ-ээр сольж тус банкинд байршуулжээ.

Худалдаа хөгжлийн банкны дээрх өрийн бичгээс өнгөрсөн хугацаанд 1237.5 сая төгрөг төлөгдсөн бөгөөд тус банкны тайлан тэнцлээс үзэхэд 2005 оны жилийн эцсийн байдлаар үлдэгдэл нь 372.8 сая төгрөг байна.

(4) Банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн татвар, Засгийн газраас авах авлагад хуримтлуулж тооцсон хүү

Улсын төсөвт урьдчилж төлсөн татварын дүн 2005 оны жилийн эцсийн байдлаар 6 банкны нэр дээр 580.8 сая төгрөг, Засгийн газраас авах авлагад хуримтлуулж тооцсон хүүний авлагын хэмжээ 3 банкны нэр дээр 213.4 сая төгрөг байна.

Тайлант оны эцсийн байдлаар банкуудын Засгийн газраас авах авлага 0.8 тэрбум төгрөг болжээ. Үүний 73.1 хувийг урьдчилж төлсөн татварын авлага, 26.9 хувийг хуримтлуулж тооцсон хүүний авлага эзэлж байна. Урьдчилж төлсөн татварын авлагын ихэнх хэсэг (80.1 хувь) Хадгаламжийн банкинд, хуримтлуулж тооцсон хүүний авлагын ихэнх хэсэг (55.8 хувь) нь Худалдаа хөгжлийн банкинд тус тус ногдож байна.

Засгийн газрын хадгаламж

Засгийн газрын хадгаламж тайлант оны эцэст 146.4 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны эцсийнхээс 52.5 хувиар өсчээ. Үүний 61.7 хувь нь Монголбанкинд, 38.3 хувь нь банкуудад байршиж байна.

Нийт хадгаламжийн дийлэнх хэсэг буюу 69.8 хувь нь Төрийн сангийн нэгдсэн данс болон Засгийн газрын харилцах дансны хөрөнгө, 18.1 хувь нь хугацаатай болон хугацаагүй хадгаламж, 12.1 хувь нь Засгийн газрын санхүүжилтийн хөрөнгө байна.

Дамжуулан олгосон зээл

1. Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх (ХААСХ) төсөл

Азийн хөгжлийн банкны ХААСХ 1822-МОН төслийн хүрээнд 2005 онд Монголбанк 7.1 тэрбум төгрөгийн зээлийг банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байгаа, баруун аймгуудад салбартай ХААН, Монгол Шуудан, Зоос, Анод, ХАС банкуудад дамжуулан олгож, оны эцэст 5.1 тэрбум төгрөгийн зээлийн авлагатай гарлаа.

Тайлант онд Монголбанк дамжуулан олгосон зээлийн эх үүсвэрт Сангийн яамнаас 5.6 сая ам. долларыг хүлээн авсан бөгөөд оны эцэст 753.4 сая ам. долларын авлагатай гарав. Монголбанк Сангийн яаманд 88.1 сая төгрөгийн хүү төлсөн байна.

Төсөлд оролцогч банкууд хуваарийн дагуу 7.1 тэрбум төгрөгийн зээлийг Монголбанкинд буцаан төлсөн ба ашигласан зээлийнхээ хүүд 236.4 сая төгрөгийг төлжээ.

2005 онд банкууд энэ төслийн хүрээнд 9384 зээлдэгчид 9.6 тэрбум төгрөгийн зээл олгон, 8.9 тэрбум төгрөгийн зээлийг эргүүлэн төлүүлж, оны эцэст 6.5 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй гарчээ. Банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 216.4 сая төгрөг буюу 3.3 хувийг чанаргүй зээл эзэлж байгаагийн дотор Монгол Шуудан банкных голлох хэсэг (132.2 сая төгрөг буюу 61.1 хувь) нь байна.

Монголбанкнаас авсан эх үүсвэрийг банкууд 100 хувь ашигласан бөгөөд эцсийн зээлдэгчдэд олгосон зээлийн хүү сарын 1.5-3.8 хувь байв.

Төсөлд чөлөөт өрсөлдөөний зарчмаар оролцох боломжийг банкуудад жигд олгох, ялангуяа, Монгол орны бүх сумдад өөрийн салбар нэгжтэй бөгөөд хөдөө аж ахуйн салбарыг илүү хамарч ажилладаг банкуудыг оролцуулах талаар анхаарч ажиллалаа.

2. Ажлын байр нэмэгдүүлэх төсөл

Тайлант онд Азийн хөгжлийн банкны "Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН төсөл"-д Голомт, Зоос, Эрэл, Анод, ХАС, Улаанбаатар хотын, Тээвэр хөгжлийн банкууд оролцлоо.

2005 оны жилийн эцсийн байдлаар ажлын байр нэмэгдүүлэх төслийн эх үүсвэр 3.2 тэрбум төгрөг байна. Үүний 86.9 хувь буюу 2.8 тэрбум төгрөгийг банкуудад дамжуулан байршуулаад байна. Тухайлбал, Голомт банкинд 1018.1 сая төгрөг, Зоос банкинд 975.0 сая, Эрэл банкинд 560.0 сая, Анод банкинд 150.4 сая, ХАС банкинд 42.2 сая, Улаанбаатар хотын банкинд 19.0 сая төгрөгийг олгожээ.

Эх үүсвэрийг гүйцэд ашиглаагүй шалтгаан нь зарим банк тайлант хугацааны сүүлчээр буюу зарим үед сүүлчийн өдөр Монголбанкинд эх үүсвэрийг буцаан төлж байгаатай холбоотой юм. Эх үүсвэрийн буцаан төлөлт графикийн дагуу хийгдэж байгаа бөгөөд цаашид аль болох цаг хугацааны алдагдалгүй бүрэн ашиглах талаар оролцогч банкуудтай хамтран ажиллаж байна.

2005 онд Зоос банк 459, Голомт банк 395, Эрэл банк 258, Анод банк 202, ХАС банк 37, Улаанбаатар хотын банк 6, Тээвэр хөгжлийн банк 4, нийт 1361 ажлын байрыг шинээр бий болгосон байна.

Уг төслөөр Монгол Улс 2154.0 мянган зээлжих тусгай эрх (ЗТЭ)-тэй тэнцэх валютыг АХБ-нд буцаан төлөх ёстой. Үүнээс 2004, 2005 онд тус бүр 43 мянган ЗТЭ-тэй тэнцэх валют төлж, 2005 оны жилийн эцэст 2068.0 мянган ЗТЭ-тэй тэнцэх валютын өртэй гарлаа.

Тайлант онд хуваарийн дагуу Азийн хөгжлийн банкинд Монголбанкнаас 30.6 мянган ам. долларын, банкуудаас Монголбанкинд 288.4 сая төгрөгийн хүү төлөв.

2005 онд ХАС, Улаанбаатар хотын банк энэ төсөлд шинээр хамрагдлаа.

3. КфВ төслийн зээл

Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүгийн салбарыг дэмжих зорилго бүхий хоёр хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна.

Эхний хөтөлбөрийн хувьд Монгол улсаас ХБНГУ-д эргүүлэн төлөх зээлийн төлбөр хуваарийн дагуу 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс хийгдэж эхэллээ. Харин 2 дахь хөтөлбөрийн эргэн төлөлт 2012 оноос эхлэх юм.

2005 оны эцсийн байдлаар Худалдаа хөгжил, Монгол шуудан, Капитрон банкуудад олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2 хөтөлбөрийн хувьд нийлээд 9.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Үүний 46.4 хувь буюу 4.5 тэрбум төгрөгийг Монгол шуудан банкинд, 38.1 хувь буюу 3.7 тэрбум төгрөгийг Худалдаа хөгжлийн банкинд, 15.5 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг Капитрон банкинд олгожээ.

Тайлант онд банкуудын буцаан төлсөн зээл болон урьдчилан төлсөн зарим зээлээр эргэлтийн сан бүрдүүлж хуримтлуулан, 485.6 сая төгрөгтэй тэнцэх зээлийг тус эргэлтийн сангаас төсөлд оролцогч банкуудаар дамжуулан дахин зээлдүүлээд байна.

Тайлант онд энэ төслийн хүрээнд буцалтгүй тусламжийн хөрөнгөөр банкуудын аудит хийлгэсний зардал болох нийт 45.6 мянган ам.долларыг санхүүжүүлээ. Үүнээс, Монгол шуудан болон Худалдаа хөгжлийн банкинд ХБНГУ-ын захиалгаар хийлгэсэн аудитын зардалд тус бүр 8.0 мянган ам.доллар, Монгол шуудан банкинд 2004 оны зардлын 30 хувь буюу нийт 9.6 мянган ам.долларыг санхүүжүүлэв. Капитрон банкны 2004 оны аудитын зардлын 30.0 хувь буюу 7.5 мянган ам.долларыг төслөөс санхүүжүүлж байгаа бөгөөд 2003 оны зардлын 50.0 хувь буюу 12.5 мянган ам.долларыг энэ зорилгоор тус банкинд нөхөн олгожээ.

Валютын бодлого, нөөцийн удирдлага

Гадаад валютын нөөцийн удирдлага

Төгрөгийн ханш суларсан, дэлхийн зах зээлийн түүхий эдийн үнэ өссөн болон алт олборлолт нэмэгдсэн зэрэг нь манай улсын экспортыг нэмэгдүүлж улмаар гадаад валютын нийт нөөц оны эцсийн байдлаар 333.2 сая ам. доллар, цэвэр нөөц 298.0 сая

ам. доллар буюу 1992 оноос хойшхи хамгийн өндөр түвшинд хүрчээ. Монголбанк 2005 онд валютын нөөцөө 2003 оны ОХУ-д их өрийн төлбөр хийхээс өмнөх үеийн түвшинд хүргэн нөхөн бүрэлдүүлж чадлаа. Нийт нөөц 2004 оны эцэстэй харьцуулбал 125.3 сая ам. доллар, цэвэр нөөц 134.4 сая ам. доллараар өссөн байна. Гадаад валютын цэвэр нөөц импортын барааны 13.5 долоо хоног буюу 3 сарын хэрэгцээг хангахуйц хэмжээнд хүрлээ.

Зураг Гадаад цэвэр нөөцийн өөрчлөлт

Энэ онд улсын валютын нөөцөд 253.0 сая ам. долларын орлого орж, нөөцөөс 118.6 сая ам. долларыг гадаад төлбөрт зарцуулжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад гадаад валютын орлого 7.1 хувиар өсч, зарлага 41.1 хувиар буурч, цэвэр орлого 99.7 сая ам. доллараар нэмэгдсэн байна.

Нөөцийн удирдлагын ашиг 2005 онд 17.2 сая ам. доллар, үр өгөөж 7.0 хувьд хүрчээ. Үүнд дэлхийн зах зээл дээрх алтны үнэ өссөн, цэвэршүүлж мөнгөжүүлсэн алтыг зах зээлийн тааламжтай үед арилжсан зэрэг нь гол үүрэг гүйцэтгэсэн байна. Үүний зэрэгцээ ам. долларын хадгаламжийн хүү удаа дараа өсч 4.25 хувьд хүрсэн, нийт валютын нөөц нэмэгдсэн зэрэг эерэг өөрчлөлт нөлөөлжээ.

2005 оны эцсийн дүнгээр Монголбанк 194.9 сая ам. долларын мөнгөжсөн алтаар валютын нөөцийг нэмэгдүүлсэн байна. Мөнгөжсөн алтны хэмжээ өнгөрсөн оноос 2.9 тонноор нэмэгдэж 13.1 тонн болжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад Монголбанкнаас банкуудад худалдсан валютын хэмжээ эрс багассан байна. Энэ нь иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээг хангахуйц валютын арилжааг банкууд хийх болсонтой холбоотой байна.

2005 онд 133 алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, 858 гаруй иргэдээс (давхардсан тоогоор) бохир жингээр 15.2 тонн, цэвэрт шилжүүлснээр 13.4 тонн алт хүлээн авч, түүний үнэд 229.9 тэрбум төгрөг төлсөн байна. Цэвэрт шилжүүлсэн алтыг өнгөрсөн онтой харьцуулахад 3228 кг-аар, алтанд төлсөн үнэ 72.6 тэрбум төгрөгөөр илүү байна. Алт олборлогчид 2005 оны 3 дугаар сард хамгийн бага буюу 203.9 кг, 6 дугаар сард хамгийн их буюу 2654 кг алт тушаасан байна. Алт тушаагч иргэдийн хувьд 8 дугаар сард хамгийн ихийг буюу 465.6 кг алт тушаажээ. Монголбанкны худалдаж авсан нийт алтны жилийн дундаж сорьц 2004 онд 881 байсан бол 2005 онд 883 болов.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тушаасан бохир алтыг Монголбанк хүлээн авч хадгалж хамгаалах, тээвэрлэх, цэвэршүүлэхэд гарах зардлыг унц алт бүрт 2 ам. доллар байсныг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1 ам. доллар 50 цент, 2005 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1 ам. доллар хүртэл бууруулж алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдаж авах алтны үнийг унц тутам нэмэгдүүллээ.

Төгрөгийн нэрлэсэн ханш

2005 оны эхэнд 1 америк доллар 1209 төгрөгтэй тэнцэж байсан бол 2005 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1221 төгрөгтэй тэнцэж жилийн хугацаанд 1 хувиар суларсан нь сүүлийн жилүүдийн хамгийн бага хэмжээ байв.

Зураг Төгрөгийн ханшийн хөдөлгөөн

Төгрөгийн америк доллартай харьцах Монголбанкнаас зарласан жилийн дундаж ханш 1205.27 төгрөг, банк хоорондын захын жилийн дундаж ханш 1207.10 төгрөг, валют солих цэгүүдийн арилжааны дундаж ханш 1208.88 төгрөг байв.

2005 оны эхэнд нэг америк доллар 1209 төгрөгтэй тэнцэж байсан бол 1 дүгээр улирлын эцэст 1192 төгрөг болж төгрөг америк долларын эсрэг 1.4 хувиар чангарчээ. Нэгдүгээр улиралд төгрөгийн америк доллартай харьцах дундаж ханш 1207.38 төгрөг байв.

Нэгдүгээр улирлын эхний хоёр сард манай улсын эдийн засгийн салбаруудын идэвхтэй үйл ажиллагаа ерөнхийдөө буурч, хувь хүний хэрэгцээ аливаа үнийн тогтолцоонд илүүтэйгээр нөлөөлдөг. Энэ улиралд дотоодын валютын зах дээр Цагаан сарын баяртай холбогдуулан америк доллар, юаний эрэлт харьцангуй ихсэж, харин баярын дараа буурдаг. Энэ жилийн хувьд төгрөгийн ханш сулраагүй, харин жилийн эхний 4 сарын туршид чангарсан байна.

Монголын экспортын чухал бүтээгдэхүүн болох ноолуур бэлтгэх ажил 3 дугаар сараас эхэлдэг бөгөөд үүнтэй холбогдон их хэмжээний валют гаднаас орж ирж валютын нийлүүлэлт нэмэгдэн, төгрөг америк долларын эсрэг чангардаг. Харин 2005 оны 2 дугаар улиралд төгрөгийн америк доллартай харьцах ханш аажмаар суларсан байна.

2005 оны эцсийн байдлаар банкууд дахь нийт хадгаламжийн хэмжээ 693.4 тэрбум төгрөгт хүрч 2004 онтой харьцуулбал 176.5 тэрбум төгрөг буюу 34.2 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс төгрөгийн хадгаламжийн хэмжээ 448.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 147.2 тэрбум төгрөг буюу 48.9 хувь, валютын хадгаламж 245.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 29.3 тэрбум төгрөг буюу 13.6 хувиар тус тус өссөн байна.

Банкуудад байршуулсан валютын хадгаламжийн хэмжээ америк доллараар 200.9 сая ам.доллар болж, нийт хадгаламжийн 35.4 хувьтай тэнцсэн байна. Үүнээс хугацаатай хадгаламжийн хэмжээ 126.9 сая ам.доллар буюу нийт валютын хадгаламжийн 63.2 хувь, хугацаагүй хадгаламжийн хэмжээ 74.0 сая ам.доллар буюу нийт валютын хадгаламжийн 36.8 хувийг тус тус бүрдүүлж байна.

Валютын хадгаламжийн 36.6 хувийг бүрдүүлдэг иргэдийн хугацаагүй валютын хадгаламж 23.2 сая ам. доллар буюу 46.2 хувиар өсчээ. Харин иргэдийн хугацаатай хадгаламж 0.1 хувиар буурсан байна. 2005 онд валютын хадгаламжийн хэмжээ ийнхүү нэмэгдсэн нь нэг талаас иргэд валютаар хадгаламж байршуулах сонирхолтой хэвээр байгааг харуулж, энэ нь эргээд валютын зах дээр валютын эрэлт хэрэгцээг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж, төгрөгийн америк доллартай харьцах ханшинд нөлөөлж байлаа. Нөгөө талаас, банкууд дахь валютын хадгаламжийн өсөлт банкуудын валютын зах зээл дээрх валютын нийлүүлэлтийг зохих хэмжээгээр нэмэгдүүлж байв.

Төгрөгийн бодит ханш

Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийг худалдааны гол түнш орнуудын валютын ханш болон инфляцитай харьцуулж тооцдог. Тус ханш нь төгрөгийн бодит худалдан авах чадварыг илтгэдэг. Тайлант оны эцэст төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 85.35, бодит үйлчилж буй ханшийн индекс 86.18 болж, суурь 2000

оноос төгрөг худалдааны түнш орнуудын валютын эсрэг нэрлэсэн үнээр 14.65 хувь, бодит үнээр 13.82 хувиар тус тус суларлаа.

Зураг Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй хани

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн 2005 оны индекс 86.51 гарсан нь өнгөрсөн оныхоос 2.3 хувиар суларсан байна. Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш Хятадын юаний эсрэг 1.7 хувь, Солонгосын воны эсрэг 1.1 хувь, Оросын рублийн эсрэг 0.9 хувь, Америк долларын эсрэг 0.1 хувиар тус тус суларч, харин Англи, Герман, Япон, Швейцарь, Сингапурын валютын эсрэг чангарсан байна. Төгрөгийн ханшийн сулралтад манай орны гадаад худалдааны том түншүүдийн нэг Хятад улс 2005 оны 7 дугаар сард валютын ханшийн тогтолцоогоо өөрчилж хөвөх ханшинд шилжсэнээр юаний ханш 2.3 хувиар чангарсан, мөн нефтийн дэлхийн зах зээлийн үнийн огцом өсөлтөөс импорт нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ.

Хүснэгт NEER, REER

Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн 2005 оны индекс 92.27 гарсан нь төгрөгийн худалдан авах чадвар 2000 оноос хойш 7.73 хувиар суларсныг харуулж байна. Өмнөх онтой харьцуулбал 3.1 хувиар суларчээ. 2005 онд дотоодын үнийн өсөлт өмнөх оноос буурсан нь бодит ханшийг сулрахад нөлөөллөө. Төгрөгийн ханшийн энэхүү сулралт Монгол улсын экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх өрсөлдөх чадвар сайжирсныг харуулж байна. Үүний үр дүнд Монгол улсын валютын нийлүүлэлт нэмэгдэж улмаар валютын нөөц өсч, урсгал данс ашигтай гарлаа.

Банк санхүүгийн байгууллагын хяналт шалгалт

Тайлант онд санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд нэмэгдэхийн зэрэгцээ тэдгээрийн үйл ажиллагаа нь харьцангуй идэвхтэй болж ирлээ. Тухайлбал, банк бус санхүүгийн байгууллагууд олноор нэмэгдэж, тэдгээрийн үйл ажиллагаа эрчимжиж байгаагийн зэрэгцээ банкуудын үйл ажиллагаа улам өргөжиж, хурдацтай өсч байна. Манай улсын санхүүгийн салбарыг бүрдүүлж байгаа үндсэн байгууллагууд нь банк, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршоод бөгөөд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд эдгээр байгууллагад Монголбанкнаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавин ажиллалаа.

Банкуудын үйл ажиллагааны хүрээ өргөжихийн хэрээр тэдгээрт тавих хяналт шалгалтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох асуудал тулгарч байгаа бөгөөд банкууд өөрсдийн үйл ажиллагаанд учирч болзошгүй гол эрсдэлийг сүүлийн үеийн аргуудаар тооцож, цаашдын үйл ажиллагааныхаа чиг хандлагыг тодорхойлох асуудал зүй ёсоор тавигдаж байна.

2001-2005 онд “Банкны салбарын бүтцийн өөрчлөлт, хөгжлийн талаархи богино хугацааны үзэл баримтлал”-д тусгасан стратегийн шинж чанартай зорилтууд болох санхүүгийн зуучлалын цар хүрээ болон чанарыг дээшлүүлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, цаашид санхүүгийн зах зээлд хямрал гарахгүй байх нөхцөл байдлыг бүрдүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкны салбарт итгэх итгэлийг хөхүүлэн дэмжих, банк санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах

арга замыг боловсронгуй болгох, банк санхүүгийн байгууллагаар дамжуулан хууль бус үйл ажиллагаа явуулах боломжийг хаах нөхцлийг бүрдүүлэх зэрэг асуудалд анхаарч ажиллав.

2003-2005 онд банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний үр дүнд банкны салбарын актив, хадгаламж, зээлийн хэмжээ ихээхэн нэмэгджээ. Энэ нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны салбарт итгэх итгэл дээшилснийг харуулж байна.

Хяналт шалгалтын хүрээнд зохистой удирдлага, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг хангаагүй банкинд албадлагын арга хэмжээ авах асуудалд зохицуулалт хийх, активын ангилал, эрсдэлийн сангийн хүрэлцээ хангамжийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах, банкны үйл ажиллагааны эрсдэлийг тооцож, эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх талаар зөвлөмж гаргах зэргээр хяналт шалгалтын бодлого, хяналт тавих механизмыг боловсронгуй болгож, цаашид санхүүгийн зах зээл хямралд өртөхгүй байх нөхцөл боломжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Зорилтот хугацаанд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банк, санхүүгийн байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эрсдэлээ үүрэх чадварыг дээшлүүлэх үүднээс банк, банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн санг үе шаттайгаар нэмэгдүүлэхэд чиглүүлсэн арга хэмжээний үр дүнд банкны дүрмийн санг 2 тэрбум төгрөгөөс 4 тэрбум төгрөгт, банк бус санхүүгийн байгууллага 30.0 сая төгрөгөөс 100.0 сая төгрөгт хүргэх шаардлагыг банк, санхүүгийн байгууллагууд ханган ажиллаж байгаа бөгөөд Монголбанкнаас шинээр банкны дүрмийн санг 8.0 тэрбум төгрөг, банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн санг 200.0 сая төгрөгөөр тогтоож, уг шаардлагыг заасан хугацаанд хангуулах ажилд хяналт тавин ажиллаж байна.

Банкны салбарын бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд банкны салбарын бүтцийн өөрчлөлт, хөгжлийн талаархи богино хугацааны үзэл баримтлалын гүйцэтгэлийн зорилт хангагдан биелэгдсэнтэй холбоотойгоор Хяналт шалгалтын газраас дараагийн шатны төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлэн хийж байна. Энэхүү шинэ стратегийн гол зорилго нь эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг хангахад банкны салбарын гүйцэтгэж байгаа үүргийг нэмэгдүүлэхэд орших бөгөөд чанарын үзүүлэлтүүдийн хүрээнд банкууд нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн санхүүгийн хэрэгцээг хангасан бүхий л төрлийн үйлчилгээг цогц хэлбэрээр үзүүлэх чадвартай болох, үүнтэй холбоотой эрх зүйн болон эдийн засгийн орчинг төрөөс бүрдүүлсэн байх зорилтыг тавьж байна. Шинэ стратеги нь манай улсын банкны салбарын онцлог талуудыг илүүтэй харгалзаж үзсэн, институциональ бус функциональ бүтцийг санал болгосноороо өмнөх стратегиас ялгаатай болно.

Хяналт шалгалтын тогтолцоо

Монголбанкны Хяналт шалгалтын газар нь Төв банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, Төрийн мөнгөний бодлогын хүрээнд тусгагдсан зорилтуудыг биелүүлэх үндсэн зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг билээ. Улсын Их Хурлаас батлан гаргасан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэлд банк, банк бус

санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодод Төв банкнаас тавих хяналт болон банкны дотоод хяналтыг сайжруулах, банкны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнээс сэргийлэхэд хяналт шалгалтын үйл ажиллагааг чиглүүлэх, хяналт шалгалтын ажилд олон улсын практикт хэрэглэж байгаа шинэлэг арга хэлбэрийг өргөнөөр ашиглахаар тусгагдсан байдаг.

Банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад хяналт шалгалт хийж байгаа өнөөгийн тогтолцоо нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудад тавигддаг хяналтын нийтлэг, хүлээн зөвшөөрөгдсөн үр ашигтай бүтцээр явагдаж байгаа бөгөөд цаашид боловсронгуй болгох зорилгоор Монголбанкнаас тухайн нөхцөл байдалд нь тохируулан зарим тодорхой өөрчлөлтүүдийг хийж ирлээ. Сүүлийн жилүүдэд банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны хүрээ өргөжин, шинэ техник технологи нэвтрэхийн хэрээр банкинд учирч болзошгүй эрсдэл нэмэгдэж байна. Иймээс хяналт шалгалтыг үр дүнтэй явуулахын тулд заавар журмын хэрэгжилтийн хяналтаас эрсдэл дээр тулгуурласан хяналт шалгалтад чиглүүлж, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, тодорхойлох арга хэрэгслийг боловсруулах, банкинд харилцагчдын зүгээс тавих хяналтыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна. Уг ажлын хүрээнд банкны үйл ажиллагаанд мөрдөх Монголбанкнаас баталсан дүрэм, журмыг олон улсын, ялангуяа Базелийн хяналт шалгалтын хорооноос гаргасан стандартад нийцүүлэх ажил хийгдэж байна. Базелийн II зарчим 2004 оны 6 дугаар сард батлагдаж, гишүүн орны банкууд эрсдэлийг удирдах эхний шатны системийг 2006 оны сүүл гэхэд боловсруулж, нэвтрүүлсэн байх шаардлага тавигдаж байна. Базелийн II зарчим нь Базель I-д үндэслэн эрсдэлийн удирдлагыг илүү боловсронгуй болгох, өөрийн хөрөнгийн зохистой хуваарилалтыг бий болгох, илүү олон төрлийн эрсдэлийг хамрах зорилготойгоор боловсруулжээ. Базель II-ыг банкуудад нэвтрүүлснээр рейтингийн өрсөлдөөнийг дэмжих, зээлийн багцын идэвхтэй удирдлагыг бий болгох, чанаргүй активын үр ашигтай удирдлагыг бий болгох, банкуудын эрсдэлийн удирдлагыг өөрийн хөрөнгийн удирдлагатай уялдуулах зэрэг нөлөө үзүүлэх юм.

Банкуудад хийгдэж байгаа хяналт шалгалтын талаар

Тайлант онд газар дээрх шалгалтын хүрээнд батлагдсан хуваарийн дагуу банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын санхүү, төлбөрийн чадварын байдал, үйл ажиллагаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан шалгалтын удирдамжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа 17 банкинд иж бүрэн шалгалтыг хугацаанд нь хийж гүйцэтгэн, шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, түүний биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Банкинд зайнаас хяналт тавих үйл ажиллагаагаар банкнаас ирүүлсэн мэдээлэл, тэдгээрийн динамик үзүүлэлт болон ашигт ажиллагаа, активын чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүдэд үндэслэн санхүү төлбөрийн чадварын байдалд дүгнэлт өгч, санхүү төлбөрийн чадвар нь хүндрэлд орсон банкуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу цаг алдалгүй арга хэмжээ авч ажиллалаа.

Түүнчлэн шалгалтын явцад банкны үйл ажиллагаанд тавих дотоод, гадаад аудитын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, удирдлагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, боловсон хүчний сургалтын системийг сайжруулах зэрэгт онцгой анхаарал тавин ажиллаж байна.

Хяналт шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авсан арга хэмжээ

Хяналт шалгалтын газар нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд банк болон банк бус санхүүгийн байгууллагад газар дээр болон зайнаас хяналт шалгалт хийн, холбогдох журам заавруудыг шинэчлэн боловсронгуй болгохын зэрэгцээ тэдгээрийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн, зохистой түвшинд хүргэхийн тулд тодорхой чиглэлүүдээр зөвлөмж, аргачлалуудыг гарган хүргүүлээ. Үүнээс гадна Олон улсын санхүүгийн байгууллага болон хандивлагч орнуудаас манай орны эдийн засгийн өсөлтийг хангах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, орон сууцаар хангах зэрэг чиглэлээр хэрэгжүүлэх төслийн хөрөнгийг банк болон банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан олгох талаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүрэлдэхүүнд орон ажиллаж байна.

Хяналт шалгалтын газар нь олон улсын стандарт, зааврыг дагаж мөрдөхөөс гадна тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүрт холбогдох хууль, журамд тусгаж байдаг. Тайлант онд санхүүгийн тайлангийн олон улсын стандартад (IFRS) орсон нэмэлт өөрчлөлтийг “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д тусгах зорилгоор уг журмыг шинэчлэн боловсруулсан ба нэмэлт, өөрчлөлтийн төслийг Сангийн яаманд танилцуулж, дэмжлэг авав.

Санхүүгийн байгууллагуудын өрсөлдөөн нэмэгдэж, үйл ажиллагааны цар хүрээ нь өргөжих хандлагатай байгаа өнөөгийн нөхцөлд тэдгээрийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага урган гарч байна. Үүнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хороог байгуулж, санхүүгийн нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог бий болгох үүднээс “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Азийн хөгжлийн банк болон Монголбанкнаас хамтран боловсруулж, батлууллаа. Үүний үр дүнд банкны хяналт шалгалтыг Монголбанк, санхүүгийн бусад байгууллагын хяналт шалгалтыг Санхүүгийн зохицуулах хороо тус тус хариуцах болж байна. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран ажиллаж, мэдээлэл солилцох зайлшгүй шаардлага байгаа бөгөөд үүний дагуу “Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам”-ын төслийг боловсрууллаа.

Банкны хяналт шалгалтын үндсэн зорилго нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагчдын хөрөнгийг хамгаалах явдал юм. 2005 онд харилцагчдын хөрөнгийг хамгаалах зорилготой “Хадгаламжийн даатгал”-ын хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн бөгөөд УИХ-д өргөн барихаар төлөвлөгдсөн байгаа.

Сүүлийн үед хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа идэвхжиж, улмаар гишүүн бус иргэдээс хөрөнгө татах, зар сурталчилгаа явуулах зэргээр хууль тогтоомжийг ихээр зөрчих болсонтой холбогдон хадгаламж зээлийн хоршоодын эрхзүйн орчинг сайжруулах зайлшгүй шаардлага гарч байна. Азийн хөгжлийн банкнаас Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийн төслийг боловсруулж ирүүлсэн бөгөөд уг хуулийн төслийг Монголбанкнаас шинэчлэн найруулж, холбогдох байгууллагуудаас санал авч байна.

Монгол улсад санхүүгийн тогтвортой байдлын асуудлыг хариуцсан зөвлөл байгуулах талаар судалгаа хийж, энэ асуудлыг Сангийн яаманд танилцуулж, дэмжлэг авлаа. Зөвлөл нь санхүүгийн салбарын эрүүл, тогтвортой байдлыг магадлан хянах, учирч болзошгүй санхүүгийн хямралаас урьдчилан сэрэмжлүүлэх дохиог олон нийтэд өгөх, шаардлагатай тохиолдолд санхүүгийн байгууллагын удирдлагад зөвлөлгөө өгөх, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааг улам үр дүнтэй болгох зорилготой. Үүнтэй холбоотойгоор банк, санхүүгийн салбарын эрсдэл (хямрал)-ийг урьдчилан таамаглах үзүүлэлтүүдийг дохиоллын аргачлалаар тооцоолох аргыг боловсруулав.

Мөн Хяналт шалгалтын газраас 2005 онд “Татварын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, “Лизингийн тухай хуулийн төсөл”, “Демпингийн эрх зүйн зохицуулалтын журам”, “Санхүүгийн маргаан шийдвэрлэх дүрэм болон холбогдох хураамжийн хувь хэмжээг тооцох журам” зэрэг хууль тогтоомжид санал өгч, хамтран ажиллалаа.

Тайлант онд эдгээрээс гадна дараахь журам, заавар, судалгааг Хяналт шалгалтын газраас хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Азийн хөгжлийн банкны Санхүүгийн салбарын хөгжлийн 3 дахь шатны хөтөлбөрийн хүрээнд тавигдаж буй шаардлагын дагуу “Банкны зохистой удирдлагын зарчмын тухай журам”-ыг боловсруулсан,
- Олон улсын валютын сангаас өгсөн зөвлөмжийн дагуу “Банкуудын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам”-ыг боловсронгуй болгосон,
- “Зээлийн мэдээллийн сангийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан,
- “Банкны зээлийн хувийн хэрэг хөтлөх заавар”-т нэмэлт, өөрчлөлт оруулсан.

2004 онд Монгол улс “Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүлэг” (Asia/Pacific Group)-т элссэн бөгөөд холбогдох хуулийн үзэл баримтлалыг батлуулан, хуулийн төслийг эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн бариад байна. 2005 онд “Financial Action Task Force”-оос гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх үүднээс банк болон банк бус санхүүгийн байгууллагын зөвшөөрлийн асуудлын хүрээнд анхаарах зүйлийн талаархи зөвлөмж”-ийг боловсруулан батлууллаа.

Өөрийн хөрөнгө

2005 оны эцсийн байдлаар банкны салбарын өөрийн хөрөнгийн дүн (албан татварын урьдчилгааг хассан дүнгээр) 207.2 тэрбум төгрөг болсон нь өмнөх оноос 23.7 хувь буюу 39.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Эрсдэлээр жигнэсэн нийт активын хэмжээ 1.1 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны байдлаас 36.1 хувь буюу 301.8 тэрбум төгрөгөөр илүү байна. Эдгээр өөрчлөлтийн дүнд тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 18.2 хувьтай гарсан бөгөөд энэ нь өмнөх оны байдлаас 1.8 нэгжээр буурсан ба Монголбанкнаас тогтоосон доод хэмжээнээс 8.2 нэгжээр их байна.

Зураг Банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалд зааснаар банкууд 2006 оны 3-р сарын 31-ний дотор дүрмийн сангаа 8 тэрбум төгрөгт хүргэх ёстой. 2005 оны эцсийн байдлаар дөрвөн банк дээрх шаардлагыг ханган ажилласан байна. Тайлант онд банкны салбарын өөрийн хөрөнгө 23.7 хувь буюу 36.7 тэрбум төгрөгөөр өссөн боловч банкууд татан төвлөрүүлсэн хөрөнгөө харьцангуй өндөр эрсдэлтэй актив буюу зээл болон бусад гадаад дотоодын банкуудад байршуулах хандлагатай байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх оноос буурсан байна. Тайлант оны эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг бүх банкууд ханган ажилласан байна.

Сүүлийн жилүүдэд банкууд зээлийн үйл ажиллагаагаа цөөн тооны найдвартай зээлдэгчдэд төвлөрүүлэх, эрсдэл багатай гэж тооцогдох Монголбанк болон Засгийн газрын үнэт цаас худалдан авах нь өөрчлөгдөж, олон тооны харилцагч, зээлдэгчдийг хамруулан зээлийг тархаан байршуулж зах зээлд эзлэх байр сууриа өргөжүүлж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын механик тоон өсөлт болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 461 тоот тушаалаар ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор ББСБ-уудын нийт өөрийн хөрөнгө 30.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 46.2 хувь буюу 9.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Эрсдэлтэй активын өсөлтөөс шалтгаалж эрсдэлээр жигнэсэн нийт активын хэмжээ 24.1 тэрбум төгрөг болж өссөн, өөрийн хөрөнгийн өсөлтийн хурд, эрсдэлээр жигнэсэн активын өсөлтийн хурдаас өндөр байгаа зэргээс шалтгаалж нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн активын харьцаа 116.1 хувь, өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн активын харьцаа 124.79 хувь байгаа нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 637 тоот тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам"-д заасан зохистой харьцааны үзүүлэлтийг нийт ББСБ-ууд хангаж ажилласан байна.

ББСБ-ууд бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар нийт эх үүсвэрээ нэмэгдүүлснээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 6.9 тэрбум төгрөг, харин түргэн борлогдох актив 14.4 тэрбум төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (ТТГЧ)-ын шалгуур үзүүлэлт нэгтгэлээр 208.5 хувь байгаа нь журамд заасан хязгаарлалтыг хангаж байна. Гэвч санхүүгийн бусад эх үүсвэрийг их хэмжээгээр татан төвлөрүүлж байгаа, ялангуяа итгэлцлийн үйл ажиллагаа явуулж буй ББСБ ТТГЧ-ын үзүүлэлтийг хангахгүй байх эрсдэл үүсэх хандлагатай байна.

Түргэн борлогдох активын бүтцийг судлахад 81.5 орчим хувь буюу 11.7 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, бусад хувь нь банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл байна.

Харин бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15.9 хувь буюу 1.1 тэрбум төгрөг нь итгэлцлийн үйлчилгээний өглөг, 52.1 хувь буюу 3.6 тэрбум төгрөг нь банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, үлдсэн хувь нь зарим эх үүсвэр, бусад пассив эзэлж байна.

Хөрвөх чадвар

Хүснэгт 5. Актив пассивын зөрүү

Дээрх хүснэгтээс харахад банкуудын богино хугацаатай актив, пассивын цэвэр зөрүү (өссөн дүнгээр) хасах утгатай байгаа ч ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөр уг зөрүүг арилгах боломжтой байна.

Банкны ТТГЧ-ыг илэрхийлдэг энгийн үзүүлэлтүүд болох түргэн борлогдох актив болон түргэн борлогдох пассивын харьцаа, зээл болон хадгаламжийн харьцааг үзүүлсэн графикаас харахад сүүлийн хоёр жилийн хугацаанд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа салбарын хэмжээгээр буурах хандлагатай болж байна.

Зураг Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Олон улсын практикт түргэн борлогдох актив болон түргэн борлогдох пассивын харьцаа ерөнхийдөө 1-ээс дээш байвал зохимжтой гэж үздэг бөгөөд Монголын банкуудын хувьд энэ үзүүлэлт 0.8 байгаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл анхаарал татах түвшинд байгааг илэрхийлж байна. Зарим банкуудын хувьд энэхүү үзүүлэлт ихээхэн доогуур байгаа бөгөөд нэг банкинд гарсан хүндрэл нийт банкны салбарт нөлөөлж болзошгүй учраас энэхүү эрсдэлд банкууд анхаарлаа хандуулж, эрсдэлийг цаг тухайд нь илрүүлж удирдах тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Зээлийн үйл ажиллагаа ба зээлийн багцын чанар

Зураг Зээл, чанаргүй зээл, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь

Банкуудын зарласан төгрөгийн зээлийн жилийн дундаж хүү өмнөх оны мөн үеийн байдлаас 1.7 нэгжээр бууран 28.3 хувь болсон байна. Банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл тайлант онд 41.7 хувь буюу 253.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 859.8 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт Банкуудын зарласан хүү

Үүнийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 44.6 хувь буюу 243.4 тэрбум төгрөг, чанаргүй зээлийн үлдэгдэл 26.5 хувь буюу 10.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 3.2 хувь буюу 0.7 тэрбум төгрөгөөр буурч, чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.7 нэгжээр доошлон 5.7 хувьд хүрчээ.

Зураг Зээлийн зориулалт

2005 онд хөдөө аж ахуйн болон тээвэр холбооны салбарт олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ ихээхэн өссөн байна. Он дараалсан зүдэд нэрвэгдэж доройтсон хөдөө аж ахуйн салбар сэргэж байгаатай уялдан хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хэмжээ өмнөх оноос 104.1 хувиар өсч, 57.3 тэрбум төгрөгт хүрчээ. Мэдээлэл, холбоо технологийн салбарт өсөлт явагдаж, “Цахим Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс голлон шалтгаалж тээвэр, холбооны салбарт олгосон зээлийн хэмжээ өмнөх оноос 2.2 дахин өсч, 36.7 тэрбум төгрөг боллоо.

Зураг Чанаргүй зээл, салбараар

Чанаргүй зээлийн өөрчлөлтийг салбараар нь авч үзвэл, бөөний болон жижиглэн худалдаанд 7.1 тэрбум төгрөг, хөдөө аж ахуйн салбарт 5.2 тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрт 1.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ. Боловсруулах салбарт олгосон зээлийн 12.3 хувь, хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн 12.0 хувийг чанаргүй зээл эзэлж байгаа нь хамгийн эрсдэл өндөртэй салбарууд болж байна.

Өмнөх онтой харьцуулахад уул уурхайн салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 3.0 нэгжээр буурч 3.0 хувь, хөдөө аж ахуйн салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 5.9 нэгжээр өсч 12.0 хувь тус тус болсон нь чанаргүй зээлийн хувьд гарсан томоохон өөрчлөлтүүд болж байна.

ББСБ-уудын нийт эх үүсвэр нэмэгдсэнээр зээл, түүнтэй адилтгах актив (*хүүний орлого авчирдаг актив*) 19.3 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 50.2 хувийг эзэлж байна. Энэ нь банкны салбарын нийт олгосон зээлийн 2.2 орчим хувьтай тэнцэж байна.

Зураг 3ээл, түүнтэй адилтгах активын бүтэц

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад активын чанарт дараахь өөрчлөлт орсон байна. Нийт зээл, түүнтэй адилтгах активын өсөлтөөс чанаргүй зээл, түүнтэй адилтгах активын өсөлт их байгаагаас хэвийн болон хугацаа хэтэрсэн зээл, түүнтэй адилтгах активын нийт зээл, түүнтэй адилтгах активт эзлэх хувийн жин буурсан, харин хэвийн бус, эргэлзээтэй ба муу зээл, түүнтэй адилтгах активын нийт зээл, түүнтэй адилтгах активт эзлэх хувийн жин өссөн байна.

Эрсдэлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан 2004 оны 207/459 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу 1,099.1 сая төгрөгөөр байгуулахаас 1.8 сая төгрөгөөр дутуу буюу 1,097.3 сая төгрөгөөр байгуулсан байна.

Монгол улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг ББСБ-ууд хангаж ажиллаж байна.

Зах зээлийн эрсдэл

Тайлант онд төгрөгийн гол валютуудтай харьцах ханш буурсан ба банкуудын гадаад валютын урт позици өмнөх оноос 26.4 хувиар өсч 56.9 тэрбум төгрөгт хүрлээ. Эдгээр өөрчлөлтүүдээс голчлон шалтгаалж гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт банкны салбарын хэмжээгээр 6.1 нэгжээр буурч 27.4 хувьд хүрсэн нь Монголбанкнаас тавьж буй шаардлагыг хангасан буюу +/-40 хувийн хязгаарт багтаж байна (энд гадаад валютын эрсдэлийг Хамгийн их эрсдэлийн аргаар тооцох зөвшөөрөл авсан Худалдаа хөгжлийн банкны позициг хасч тооцсон. Тус банк нь Хамгийн их эрсдэлийн хязгаар болох 10 хувийн журмын шаардлагыг ханган ажиллаж байгаа болно).

Зураг Гол валютын ханш

Сүүлийн жилүүдэд хүүний хэлбэлзэл буурч, банкуудын өөрийн хөрөнгө тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаагаас хүүний эрсдэлээс хүлээж болзошгүй алдагдлын өөрийн хөрөнгөд эзлэх хувь хэмжээ буурах хандлагатай байна. Харин сүүлийн хоёр жилд хэрэглээний үнийн индексээр тодорхойлогдсон инфляцийн түвшин өндөр

байсан, дэлхийн зах зээлд нефтийн үнэ тогтмол өсч байгаатай холбоотойгоор бараа бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс хүлээж болзошгүй алдагдал өндөр байгаа юм.

Зарим банкууд харьцангуй боловсронгуй аргууд (тухайлбал “Value at risk”)-аар эрсдэлийг тодохойлж эхэлсэн боловч цаашид эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох үүднээс зах зээлийн огцом хэлбэлзэл, тухайлбал хямрал гарсан үед хүлээж болзошгүй алдагдлын талаар нэмэлт тооцоо, судалгааг (тухайлбал “*stress-testing, scenario analysis*”) хийх шаардлагатай байна.

Тайлант хугацааны эцэст гадаад валютын позици нийт валютаар 16.38 хувь байгаа нь журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг нэгтгэлээр болон дийлэнх ББСБ-уудын хувьд хангаж байгаа ч гадаад валютын ханшийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор гадаад валютаар зээл олгох сонирхол давамгайлснаар уг үзүүлэлтийг хангахгүй байх эрсдэл ББСБ-уудад үүсч байна.

Гадаад валютаар олгосон зээл, санхүүгийн түрээс болон факторингийн авлагын үлдэгдэл ББСБ-ын хувьд 3.8 тэрбум төгрөг байгаа нь нийт хүүний орлого олдог активын багцын (19.3 тэрбум төгрөг) 19.7 хувийг, харин нийт бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрийн (6.9 тэрбум төгрөг) 28.5 хувийг гадаад валютаар бүрдүүлсэн байна.

Бүртгэл тооцоо, мэдээллийн технологи

Нягтлан бодох бүртгэл

Тайлант онд Монголбанкны нягтлан бодох бүртгэлийг Олон Улсын стандартад нийцүүлэн бүртгэлийн сахилга батыг сахих, төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, 2004 оны Монголбанкны "Нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг Монголбанк болон салбаруудад мөрдүүлж цаашид улам боловсронгуй болгоход анхааран ажиллаж ирлээ.

Монголбанкны БТМТГ нь КPMG аудитын компанийн зөвлөмжийг хэрэгжүүлэх, санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг нэгтгэх ажлыг боловсронгуй болгоход анхаарч ирлээ. Тайлант онд тус аудитын компанийн зөвлөмжийн дагуу 2003-2004 оны санхүүгийн тайланд хийх тохируулгын гүйлгээг хийж гүйцэтгэлээ.

Банк хоорондын төлбөр тооцоо

Манай улсын эдийн засаг, банк санхүүгийн салбар өргөжин тэлж байгаа өнөө үед банк хоорондын тооцоогоор дамжих гүйлгээний дүн жилээс жилд өсч байна. Банк хоорондын тооцоонд оролцож буй нийт төлбөрийн дүн болон ДНБ-ий харьцаа нь эдийн засаг дахь нийт мөнгө ямар хурдтайгаар банк хооронд эргэлтэд орж буйг харуулдаг.

Энэ үзүүлэлт нь 2001 онд 1.7, 2002 онд 2.2, 2003 онд 2.8, 2004 онд 3.1, 2005 онд 3.3 болон хурдасчээ. Ийнхүү хурдассан нь мөн иргэдийн банкинд итгэх итгэл сайжирч, банкаар хийгдэх гүйлгээ эрс нэмэгдэж буйг илтгэж байна.

Зураг Банк хоорондын төлбөр тооцоо, ДНБ

Банк хоорондын гүйлгээний тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа хэдий ч 2005 онд нийт гүйлгээний тоо 2.3 сая байгаа нь өмнөх оныхоос 13.7 хувиар буурсан байна.

Хүснэгт Банк хоорондын гүйлгээний тоо, улирлаар

Өмнөх онуудын 8, 9, 12 дугаар саруудад гүйлгээний тоо өсч гардаг байсан бол 2005 оны 1, 6, 9, 10, 11, 12 дугаар саруудад буурч, бусад саруудад ялангуяа 5 дугаар сард гүйлгээний тоо хамгийн их байна.

Зураг Банк хоорондын гүйлгээний тоо, сараар

2002 оны жилийн эцсийн байдлаар нийт гүйлгээний дүн өмнөх оныхоос 45.9 хувь, 2003 онд 48.9 хувь, 2004 онд 38.5 хувь, 2005 онд 33.7 хувиар тус тус өсчээ. Улирлын байдлаар авч үзвэл, 2005 оны 4 дүгээр улиралд хамгийн их буюу 2.2 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн бол 1 дүгээр улиралд хамгийн бага буюу 1.5 их наяд төгрөгийн гүйлгээ хийгджээ. 2005 оны 1 дүгээр улиралд гүйлгээний нийт дүн өмнөх оны мөн үеийнхээс 36.4 хувь, 2 дугаар улиралд 26.6 хувь, 3 дугаар улиралд 46.9 хувь, 4 дүгээр улиралд 27.3 хувь тус тус өссөн байна.

Хүснэгт Банк хоорондын гүйлгээний дүн, улирлаар

2005 оны 2, 7, 11 дүгээр саруудад гүйлгээний дүн буурсан нь ажлын хоног бусад сарынхаас бага байсантай холбоотой байв. Жил бүрийн 3, 4, 6, 9, 12 дугаар саруудад гүйлгээний дүн нэмэгддэг байна.

Зураг Банк хоорондын гүйлгээний дүн, сараар

2004 оны банк хоорондын гүйлгээний дүнгийн 27.3 хувийг Төрийн сангийн гүйлгээ эзэлж байв. 2005 оны банк хоорондын гүйлгээний дүнгийн хамгийн их буюу 24.2 хувь нь Төрийн сан, 16.3 хувь ХХБ, 11.1 хувь ХААН банк, 10.2 хувь Голомт банкинд тус тус ногдож байна. Гүйлгээний дүнгээрээ хамгийн томд тооцогдож байсан ХХБ-ны гүйлгээний дүн өнгөрсөн оныхоос 1.1 хувь, Анод банкных 2.2 хувь, Төрийн сангийнх 3.1 хувь, ХААН банкных 0.5 хувиар тус тус буурсан байхад Хадгаламжийн банкных 0.6 хувь, Монгол шуудан банкных 1.6 хувь, Голомт банкных 2.7 хувь, Улаанбаатар хотын банкных 1.9 хувь, бусад банкуудынх 0.6 хувиар нэмэгдсэн байна.

Зураг Банк хоорондын гүйлгээний дүнд эзлэх хувь, банкуудаар

Мэдээллийн технологи

Орчин үед банк, санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаа мэдээллийн технологийг хэрэгжүүлэхгүйгээр явуулах боломжгүй болсон байна. Мэдээлэл холбооны технологийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлснээр цаг хугацаа, хүн хүч, орон зай, мөнгө хөрөнгийг хэмнэж хөгжлийг хурдасгаж байгаа билээ. Үүний тулд шинэ техник, технологи нэвтрүүлэх, программ хангамж, техник хангамжийн хэвийн ажиллагааг хангах, мэдээллийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, боловсон хүчнийг сургаж, мэргэшүүлэх талаар байнга анхаарал хандуулж ажиллах нь чухал байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэж буй “Санхүүгийн чадавхийг хөгжүүлэх төсөл” -ийн хүрээнд бага дүнтэй гүйлгээний болон төлбөрийн картын клирингийн төв

("Төлбөр тооцооны төв") нь техник технологи, харилцаа холбоо, боловсон хүчний хувьд бэхжин үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Энэхүү төсөл бүрэн хэрэгжсэнээр Монгол улсын бүх банк Төлбөр тооцооны төвтэй онлайн зарчмаар холбогдож бага дүнтэй болон төлбөрийн картын гүйлгээ түргэн шуурхай дамжих төдийгүй цаашид санхүүгийн хоёрдогч зах зээл бүрэн утгаар хөгжих, бизнесийн орчин интернэт төлбөр тооцоо, электрон худалдаанд шилжих таатай орчин бүрдэж байгаа юм. Банк хоорондын том дүнтэй гүйлгээнүүдийн клирингийн үйл ажиллагааг явуулах орчин үеийн систем (RTGS)-ийг хэрэгжүүлэх талаар судалгаа хийж байна.

Өдөр тутмын үйл ажиллагаа явуулах нэг хэрэгсэл болсон интернэтийн ачаалал нэмэгдэж байгаа тул үйлчилгээгээр хангагч байгууллагатай хамтран технологийн өөрчлөлт хийж, мэдээлэл дамжуулах хурдыг 4 дахин нэмэгдүүллээ. Электрон шуудангийн программ хангамжийн шинэчилсэн хувилбарыг туршиж, нэвтрүүлснээр байгууллагын гадна хаанаас ч электрон шуудангаа шалгах боломжтой болсон ба хүсээгүй, сэжиг бүхий шуудангуудыг шалгах фильтр ажиллуулсан нь үр дүнгээ өгч байна. Дотоод сүлжээ болон интернэтийн хэрэглээг үр ашигтай, дэг журамтай болгох үүднээс орлогч (PROXY) сервэрийг ашиглалтанд орууллаа.

Өдөр бүр өсөн нэмэгдэж байгаа мэдээллийг зохимжтой байршуулах, мэдээлэл дамжуулах хурдыг нэмэгдүүлэх, орчин үеийн бусад системтэй харилцан ажиллах боломжийг нэмэгдүүлэх үүднээс мэдээллийн сангийн программ хангамжийг шинэчилсэн хувилбар (Oracle9i,10G)-т шилжүүлэх тал дээр туршилт хийсэн нь сайн үр дүн өглөө. "Хүний нөөц", "Цалин хөлс", "Үндсэн хөрөнгө", "Үнэт металл", "Нягтлан бодох бүртгэл", "Төв банкны үнэт цаас", "Олон улсын банк санхүүгийн байгууллагын нэгдсэн сан", "Зээлийн мэдээллийн сан", "Банк хоорондын төлбөр тооцооны систем" гэх зэрэг программ хангамжийг шинээр буюу шинэчлэн сайжруулж, тогтвортой ажиллагаагаар ханган ажиллалаа.

Үйлдлийн системүүдийн вирусын эсрэг программ, мэдээллийн сангийн үйлдвэрлэгч компаниудаас гаргасан өөрчлөлт, алдааны залруулга, өгөгдлийн шинэчлэлтийг цаг бүрд нь хийж байгаа нь электрон системийг вирус болон халдлага, бусад аливаа техникийн болон программын доголдоос хамгаалах чухал үйл ажиллагаа гэж үздэг. Цаашид дотоод ба гадны сүлжээний хэрэглэгчдийг мэдээллээр хангах, нууцлалын түвшинг сайжруулах, сүлжээний зохион байгуулалт, сахилга батыг сайжруулах тал дээр системүүдийг (Public Web, Intranet Web, Active Directory, Secure DigiPass, MultiTire System) ирэх тайлангийн жилд шинээр нэвтрүүлэхээр төлөвлөөд байна.

Олон улсын банк хоорондын төлбөр тооцооны SWIFT системийн хүрээнд холбогдох компанитай хамтран ажиллаж төлбөр тооцоог онлайн горимоор гүйцэтгэх холболтын шинэ технологид төлөвлөгөөний дагуу шилжиж байна.

Банкуудын нягтлан бодогч, эдийн засагч, мэргэжилтнүүдийг шаардлагатай мэдээлэл, сургалтаар ханган ажиллаж байна. Мөн Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг Германы Төв банкны Мэдээллийн технологийн бүтэц зохион байгуулалттай танилцуулах, арга туршлагаас нь сурах ажлыг газар дээр нь зохион байгууллаа.

Төлбөр тооцооны төв

Монгол улс Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд 2002 оны 9-р сарын 5-ны өдөр байгуулагдсан Хөгжлийн зээлийн гэрээний дагуу "Санхүүгийн чадавхийг

хөгжүүлэх төсөл”-ийн 2-р хэсэг буюу Төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох хэсгийг Монголбанк удирдан хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл бүрэн хэрэгжиж 2005 оны 7 дугаар сараас Төлбөр тооцооны төв нь үйл ажиллагаагаа эхэллээ. Тус төвийг нийт 16 банкны төв, Сангийн яамны Төрийн сангийн газар, Монголбанкны төвтэй шилэн болон физик кабелиар холбон санхүүгийн дундын сүлжээ байгуулав. Одоогийн байдлаар сүлжээ хэвийн ажиллаж байгаа бөгөөд банк хоорондын гүйлгээний мэдээллийг туршилтын журмаар дамжуулах ажил хийгдэж байна. Нөөц төвийг байгуулаад байгаа бөгөөд үндсэн болон нөөц төвийн хооронд холболт хэвийн ажиллаж байна. Нөөц төв нь үндсэн төвийн ажиллагаа гэмтэн зогсоход түүний тасралтгүй ажиллагааг ханган ажиллуулах үүрэгтэй байдаг. Дундын сүлжээг найдвартай ажиллуулахад шаардлагатай холбогдох бүхий л гэрээ хэлэлцээр хийсэн байна.

Энэхүү сүлжээ ашиглалтанд орсноор Монголбанк нь банкуудын төв болон Сангийн яамны Төрийн сангийн газартай бодит цагийн горимд онлайн холбоотой болж санхүүгийн аливаа үйлчилгээг тухайн мөчид түргэн шуурхай явуулах боломжтой болж байгаа юм. Үүний зэрэгцээ тус сүлжээг ашиглан Зээлийн мэдээллийн сан зэрэг байнга мэдээлэл солилцох системд нэмэлт техникийн болон холбооны системийн хамааралгүйгээр, нэмэлт зардалгүйгээр мэдээлэл чөлөөтэй солилцох боломжтой болж байна. Банкууд уг сүлжээний тусламжтайгаар Төв банкны үнэт цаасны арилжаа буюу мөнгөний захын үйл ажиллагаанд оролцох, тайлан мэдээллээ солилцох зэрэг нэмэлт үйлчилгээ хийх боломж бүрдэж байна. Цаашид, энэхүү дэд бүтцийг ашиглан банкны үйл ажиллагааг боловсронгуй болгох олон төрлийн үйл ажиллагаа явуулах өргөн боломж нээгдэж байна.

Төлбөр тооцооны төв, түүний нөөц төвийн техник болон программ хангамжийг суурилуулан ашиглалтанд оруулав. Энэ төв дараахь үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

- Банк хоорондын бага дүнтэй төлбөрийн клиринг (real time, on-line payment)
- Монголбанкттай үр дүнгийн тооцоо хийх
- Картын клиринг (switching), картын төвийн үйлчилгээ (processing)
- Банк хоорондын их дүнтэй гүйлгээ, зээлийн мэдээллийн сан болон бусад шаардагдах мэдээллийг Монголбанк руу дамжуулах шугам авах

Төв нь техникийн болон цахим хөрөнгийн шилжүүлгийн Олон улсын нууцлалын стандартыг мөрдөнө. Ингэснээр олон улсын Виза (Visa), Мастер (Master) зэрэг сүлжээтэй нэгдсэн стандартын үндсэн дээр хамтран ажиллах бөгөөд нэгэнт нэвтрээд байгаа банкны картуудтай ажиллах боломжийг мөн олгоно. Түүнчлэн гар утас, компьютер болон бусад төхөөрөмжөөс олон улсын стандарт (ISO8583)-д нийцсэн бүх төрлийн цахим мэдээг хүлээн авч дамжуулах боломжтой юм. Нэгдсэн стандартад шилжсэнээр худалдааны цэгүүд нэгэн зэрэг олон тооны карт уншигчтай байхаа больж зөвхөн нэг карт уншигчийн тусламжтайгаар бусад бүх банкны картыг унших, тооцоог бэлэн бусаар түргэн шуурхай гүйцэтгэх боломж бүрдэнэ. Карт эзэмшигчид нь картаар үйлчлэх өөрийн сонгосон байгууллагаас түргэн шуурхай үйлчилгээ авах ба бэлэн мөнгө тоолох, биедээ авч явах эрсдэлээс чөлөөлөгдөнө.

Тус төв нь төлбөрийн картын хэрэглээг дэмжих зорилгоор банкуудад төлбөрийн картын удирдлагын системийн үйлчилгээ үзүүлэхээр ажиллаж байна. Эхний шатанд энэ системээр үйлчлүүлэх банкуудтай хийх гэрээ, шимтгэл хураамжийн төслийг боловсруулан зөвшилцөөд байна.

Бусад үйл ажиллагаа

Удирдлага, зохион байгуулалт

Тайлант онд ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх, санал бодлоо чөлөөтэй, ил тод илэрхийлэх, ухамсраар нь ажиллуулах чөлөөт итгэлцлийн зарчим дээр тулгуурласан, шагнал урамшуулал, нийгмийн асуудлыг хангах механизмыг хүний нөөцийн бодлогодоо тусган ажиллалаа.

Төв банк нь удирдлага, 6 газар, 11 хэлтэс, 9 алба, 1 тусгай тасаг, 1 төлбөр тооцооны төв, орон нутаг дахь 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц, зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж тэдгээрт нийт 321 гаруй төрийн албан хаагч ажиллаж байна.

Монголбанкны Төв аппаратад 228 ажилтан ажиллаж байгаагаас эмэгтэй 114, эрэгтэй 114, орон нутаг дахь салбарт нийт 93 ажилтан, эдгээрээс эмэгтэй 49, эрэгтэй 44 ажилтан ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, санхүү банкны салбарын тогтвортой байдлыг хангах, банкны бүтцийн өөрчлөлтийг өргөжүүлэн гүнзгийрүүлэх бодлогын чанартай арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн залуу боловсон хүчнийг дайчлан ажиллуулах боломжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тэдгээрийн боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд хүргэх, сурч боловсрох эрхээ чөлөөтэй эдлэх боломж олгохын тулд Дэлхийн банк, ОУВС, бусад олон улсын байгууллагаас зохион байгуулж буй тэтгэлэгт сургалт, семинаруудад байнга оролцуулж, түүний үр дүнд оюуны хөрөнгө оруулалт, мэдлэг боловсролыг чанаржуулж тэдгээрээс нийлүүлэх бүтээгдэхүүний гарцыг байнга дээшлүүлж ирлээ. Тухайлбал, 2005 онд гадаад, дотоодын сургалтад 79 ажилтан давхардсан тоогоор 117 сургууль, курс семинарт хамрагдаж, удирдах болон бусад ажилтнууд гадаад, дотоодын нийт 55 хурал уулзалт, зөвлөлгөөнд оролцжээ.

Тайлант онд тус банкинд магистрын зэргийг АНУ, Австрали, Япон улсуудад 6 ажилтан хамгаалснаар байгууллагын хэмжээгээр нийт 3 доктор, 55 магистрын зэрэгтэй ажилтнууд ажиллаж байна. 2005-2006 онд докторын сургалтанд 3 ажилтан, магистрын сургалтанд Олон улсын валютын сан болон гадаад орнуудын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн шугамаар Австрали, Япон, Люксембургийн вант улсын их, дээд сургуульд 11 ажилтан суралцаж, 1 ажилтан Америкт суугаа Элчин сайдын яаманд мэргэжлийн дадлага хийж байна.

Бүх ажиллагсдын 75.0 хувь нь банк, санхүү, нарийн мэргэжлийн инженер, эдийн засагч мэргэжилтэй мэргэжлийн боловсон хүчин байгаа бол үйлчилгээний албан тушаалтнуудын 38.0 орчим хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.

Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд тэдгээрийн ажиллаж амьдрах тав тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор ихээхэн анхаарал тавьж ажиллалаа. Тухайлбал, бүх ажиллагсдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 2 удаа хамруулсан, 15 ажилтны орон сууцны болон сууц хувьчлалын асуудлыг шийдвэрлэсэн, Монголбанкны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, нэмэгдэл тэтгэвэр тэтгэмж олгох

тухай журмын дагуу ахмадуудаа 2 удаа хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн зэрэг арга хэмжээг зохион байгуулав.

Дотоод аудит

Монголбанкны Дотоод аудитын газар нь үндсэн чиг үүргийнхээ дагуу дотоод аудитын 2002-2006 оны урт хугацааны хөтөлбөр болон 2005 оны төлөвлөгөөнд үндэслэн Монголбанкны газар, хэлтэс, алба болон орон нутаг дахь салбар (нэгжүүд)-т шалгалт хийж эдгээр нэгжүүдийн Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллав.

Тайлант онд Монголбанкны 5 газар, орон нутаг дахь 17 салбарт бүрэн, хэсэгчилсэн, гэнэтийн шалгалтыг нийт 64 удаа хийж, үр дүнг нь Монголбанкны Захирлуудын Зөвлөлд танилцуулан илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, үйл ажиллагаагаа боловсронгуй болгон дотоод хяналтыг сайжруулж, эрсдэлийг бууруулах талаар үүрэг даалгавар, санал зөвлөмж өгч, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал гаргуулан ажиллалаа. Түүнчлэн Монголбанкны Дотоод аудитын дүрэмд зааснаар дотоод аудитын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, Монголбанкны Ерөнхийлөгч болон Хяналтын Зөвлөлд цаг тухайд нь тайлагнасан болно.

Дотоод аудитын газар нь Олон улсын валютын сангийн зөвлөмжийн дагуу үйл ажиллагаагаа боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2005 онд "Монголбанкны дотоод аудитын дүрэм", "Дотоод аудитын үйл ажиллагааны ерөнхий заавар", "Дотоод аудитын газрын хянан шалгагчийн гарын авлага"-ыг тус тус боловсронгуй болгон шинээр боловсруулж, батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн нь хяналт шалгалтыг чанартай, оновчтой гүйцэтгэх, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой баримт бичиг болсон юм.

Хөндлөнгийн аудитын байгууллага, Монголбанкны Хяналтын Зөвлөлөөс Монголбанкинд өгсөн зөвлөмжийн биелэлт, үр дүнд хяналт тавин ажиллахын зэрэгцээ эдгээр байгууллага болон Захирлуудын Зөвлөлийн гишүүдэд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргууллаа.

Дотоод аудитын газар нь тайлант онд Монголбанкны 2004 оны санхүүгийн тайланг баталгаажуулах, ОУВС-гийн хүсэлтээр "КПМЖ" хөндлөнгийн аудитын байгууллагаар Монголбанкны гадаад нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд тусгай аудит хийлгэх ажлыг тус тус зохион байгуулж, Монголбанкинд өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин мөрөөр нь холбогдох арга хэмжээ авч ажиллав.

Түүнчлэн Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх талаар төрөөс явуулж буй бодлогод нийцүүлэн Монголбанкны зүүн бүсийн салбаруудын байршлыг оновчтой тогтоож, бүтэц зохион байгуулалтыг нь боловсронгуй болгох талаар судалгаа хийн, уг асуудлыг Монголбанкны Захирлуудын Зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, улмаар Монгол Улсын УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахаар хүргүүлсэн болно.

Дотоод аудитын газар нь ОУВС, хөндлөнгийн аудитын байгууллагын зөвлөмжөөр Олон улсын аудитын байгууллагын жишигт ойртуулах үүднээс газрын бүтэц, орон

тоонд өөрчлөлт оруулж, аудит хариуцсан ахлах менежер, нууцлал хариуцсан хянан шалгагч гэсэн 2 орон тоог шинээр бий болгосон юм. Энэ нь газрын доторх ажлын уялдаа холбоо, хяналт сайжрахад чухал нөлөө үзүүлсэн.

Бэлэн мөнгөний хангалт

Тайлант онд Монголбанкнаас мөнгөн тэмдэгттэй холбоотой дараахь үйл ажиллагааг эрхлэн явуулав. Үүнд:

Жижиг дэвсгэртүүдийн нөөц багассан тул 2004 онд 10-т, 20-тын дэвсгэртийг нэмж хэвлүүлэх гэрээг Английн пүүстэй байгуулсны дагуу 2005 оны 1 дүгээр улиралд татан авав.

Түүнчлэн аймаг, орон нутгийн салбар банкуудаар дамжуулан бэлэн мөнгөөр хангах, муудсан мөнгөн тэмдэгтийг татаж устгах, давтан тоолох, хянах үйл ажиллагааг тогтмол явуулж ирлээ.

Монголбанк муудсан мөнгөн тэмдэгтийг гүйлгээнээс татаж устгах үйл ажиллагааг сайжруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор 2004 онд Германы пүүсээс мөнгө устгах зориулалтын Би Ди Эс 400 (BDS-400) төхөөрөмжийг худалдан авах гэрээ байгуулсны дагуу 2004 оны 4 дүгээр улиралд татан авав.

Гүйлгээн дэх дэвсгэртийн нөөцийн судалгаан дээр үндэслэн 2004 онд Германы пүүстэй 10000-тын дэвсгэртийг нэмж хэвлүүлэх гэрээ байгуулсны дагуу 2005 оны 4 дүгээр улиралд татан авав.

2005 онд 37 тэрбум төгрөгийн 33.4 сая ширхэг муу дэвсгэртийг устгаж, тайлант оны эцэст 191.7 тэрбум төгрөг гүйлгээнд байлаа.

Гүйлгээний эрэлт хэрэгцээ, шаардлага болон дэвсгэртийн зохистой бүтцийг судалж үзсэний үндсэн дээр 20000 төгрөгийн цаасан мөнгөн тэмдэгтийг чанар, үзэмж, нууцлалын маш өндөр төвшинд гүйцэтгэж шинээр гүйлгээнд гаргах мөн Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан шинээр 20000-тын дурсгалын мөнгөн тэмдэгтийг гаргах төслийг УИХ-д өргөн бариад байна.

Монголбанкны дэргэдэх Сургалтын төв

Банкны сургалтын төв (БСТ) нь 2005 онд өөрийн гол үүрэг болох сургалт семинарыг төлөвлөгөөний дагуу тогтмол явуулж ирсэн ба сургалт семинарыг чанартай зохион байгуулахад гол анхаарлаа хандуулан ажиллаа. Ингэснээр энэ онд төлөвлөгдсөн дотоод, гадаад сургалт семинарт болон бусад үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 1453 хүн хамрагдан оролцсон байна. Энэ нь банкны салбарт ажиллагсдын 25 хувийг эзэлж байна.

БСТ нь энэ онд 34 сэдэв бүхий 34 удаагийн дотоод, гадаад сургалт семинарыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 32 сэдвээр 38 удаагийн сургалт семинар зохион байгууллаа. БСТ 2005 онд өмнөө тавьсан зорилтоо амжилттай биелүүлсэн нь Монголбанк болон банкууд, мөн зарим ББСБ тус сургалтын төвийн үйл ажиллагааг байнга дэмжин туслалцаа үзүүлэн, сургалт семинарт өөрсдийн ажиллагсдыг идэвхтэй оролцуулж байгаатай холбоотой юм.

БСТ нь банкуудын ажилтнуудын эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангахуйц сургалт, семинарыг зохион байгуулж явуулахын тулд сүүлийн жилүүдэд тогтоод байгаа уламжлалын дагуу оны эхэнд банкуудаас санал авч, 2005 оны сургалтын төлөвлөгөөг хамтран боловсруулж, уг төлөвлөгөөний дагуу сургалт семинарыг зохион байгуулж явуулсны үр дүнд банкуудаас сургалтанд хамрагдах идэвх сайн байгаа ба энэ онд 30 сэдэв бүхий 35 удаагийн сургалт семинарыг дотооддоо зохион байгуулж, нийт 1424 хүнийг хамруулав. БСТ нь энэ онд сургалт семинарыг чанартай, өгөөжтэй, үр дүнтэй аль болох сонирхолтой байхаар зохион байгуулахад гол анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

БСТ нь тайлангийн хугацаанд өөрийн гишүүн байгууллагуудаас ирүүлсэн 46 санал хүсэлтийг хүлээн авч цаг хугацаанд нь шуурхай барагдуулж ажилласан ба зарим банкуудын хүсэлтийн дагуу төлөвлөгөөнөөс гадуурхи сургалтыг зохион байгуулснаас гадна, өөрийн сургалтын танхим, тоног төхөөрөмж, сургалтын программ хангамжаа үнэгүй ашиглуулах, багш олж өгөх зэргээр туслалцаа үзүүллээ. Мөн олон улсын банк санхүүгийн салбарт ашиглаж байгаа шинэ бүтээгдэхүүн, шинэ технологи, шинэ үйлчилгээ, өндөр хөгжилтэй орнуудын банкны үйл ажиллагааг танилцуулах, туршлагаас нь суралцуулах, урьд нь тус төв дээр огт орж байгаагүй шинэ сэдвээр сургалт семинарыг зохион байгуулж явуулах зорилгоор энэ онд өөрийн гадаад түнш байгууллагуудын туслалцаа дэмжлэгээр Англи, Хонг Конг, Герман, Люксембург, Бельги, Франц, Малайз зэрэг орнуудаас банкны мэргэжилтнүүдийг урин ирүүлж, гадаад багштай 16 удаагийн сургалт семинарыг зохион байгуулав.

БСТ анх удаа бүсчилсэн сургалт семинарыг Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудын банкны ажилтнуудыг хамруулж энэ оны 9 дүгээр сард Өндөрхаан хотод зохион байгууллаа. Уг семинараар хөдөө орон нутагт ялангуяа алслагдсан сум багийн иргэдэд банкны үйлчилгээ бүтээгдэхүүнийг шуурхай хүргэх, өргөжүүлэх үйл ажиллагаанд гарч байгаа бэрхшээл, Монголбанкны салбар болон олон улсын банк санхүүгийн салбарт гарч байгаа өөрчлөлтүүд, шинэ бүтээгдэхүүн, шинэ технологи, цаашдын хөгжлийн хандлага, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх хуулийн төсөл, банкны хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, түүнийг боловсронгуй болгох талаар ярилцаж өөрсдийн санал бодлоо солилцов. Мөн бичил санхүүгийн хөгжил, ядуурал, ажилгүйдлийг бууруулахад банкны үүрэг оролцоо зэрэг сэдвээр хөтөлбөр боловсруулж, сургалт явуулав.

Банкны ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор банк санхүүгийн англи хэлний дамжааг 2 удаа зохион байгуулсан ба нийт 28 хүн дээрх дамжаанд хамрагдав. Эдгээр хүмүүсээс хичээлийн программыг хангаж шалгалтанд тэнцсэн 17 хүнд сертификат олгов. Мөн банкуудад ажиллаж буй мэргэжлийн бус ажилтнуудад зориулж “Банкны нягтлан бодох бүртгэл” сэдвээр 2 сарын дунд шатны дамжааг зохион байгуулж 41 хүнийг хамруулсан ба сургалтын программыг хангаж шалгалтад тэнцсэн 36 хүнд сертификат олголоо.

2005 онд 2 удаагийн гадаад сургалт семинарыг ГТХАН-ийн төсөл, "Inwent" зэрэг гадаадын байгууллагын тусламж санхүүжилтээр зохион байгуулсан ба эдгээрт 29 хүн хамрагдав. БСТ нь ХБНГУ-ын сургалт хөгжлийн "Inwent" төвтэй хамтран 2004 онд Монголын банкны ажилтнуудыг сургах 250 мянган еврогийн төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсоны дагуу 2-р ээлжийн 18 хүн Франкфуртын банк академи дээр 45 хоногийн хугацаагаар суралцаад ирлээ. БСТ нь энэ оноос эхлэн ГТХАН (GTZ)-тэй хамтран “Банкны сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжих” нэг сая еврогийн өртөг бүхий 2 жилийн хугацаатай төслийг хэрэгжүүлж байгаа ба энэхүү төслийн хүрээнд тус төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, сургалт семинарын чанарыг улам дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, БСТ-ийн ажиллагсдыг сургаж дадлагажуулах, туршлага судлуулах, сургалтын тоног төхөөрөмж болон ажлын байрыг шинэчлэн тоноглох зэрэг ажлууд хийгдэж байна. Мөн банкуудын хүний нөөцийн удирдлагыг сайжруулах, ажилтнуудыг нь сургаж дадлагажуулах, банкуудад ажилтан сонгон шалгаруулах шинэ систем нэвтрүүлэх зэрэг асуудалд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна. Монголын банкуудын холбооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор түүний удирдах ажилтнуудыг гадаадын ижил төрлийн байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж, туршлагаас нь суралцахад төслөөс тодорхой хэмжээний зардал гаргаж туслалцаа үзүүлсэн. Ирэх онд тус холбоонд зарим тоног төхөөрөмж нийлүүлэх асуудлыг шийдвэрлээд байна.

2005 онд тус сургалтын төвийн санхүүгийн үйл ажиллагаа, чадавхи урьд жилүүдээс эрс сайжрав. Банкууд сургалтын гишүүнчлэлийн татварыг хугацаандаа төлж байгаа нь сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжиж байгаагийн нэг илрэл бөгөөд энэ нь сургалт семинар хэвийн явагдах гол нөхцөл мөн.

Гишүүнчлэлийн татвараас орсон орлогыг зөв зохистой, хэмнэлттэй зарцуулах, зарлага аль болох явуулж буй үйл ажиллагаагаар олж байгаа орлогоороо нөхөх зарчмыг баримтлан ажиллаж байна. Ингэж ажилласны үр дүнд тайлант хугацаанд орлогын төлөвлөгөөгөө давуулан биелүүлж, зардлаа үзүүлэлт тус бүрээр нь хэмнэсэн. Энэ онд нийт орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 76.1 сая төгрөг (2004 оны орлогын дүнтэй харьцуулахад 13.9 сая төгрөг буюу 23 хувиар өссөн), зарлага 50.4 сая төгрөг (2004 оны зарлагын дүнтэй харьцуулахад 10.2 сая төгрөгөөр өссөн) байна. Нийт орлогын 31.8 сая төгрөг нь Монголбанк, банкууд болон ББСБ-ын гишүүнчлэлийн татвар, 44.3 сая төгрөг нь тус төвийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд олсон орлого эзэлж байгаа ба энэ нь нийт орлогын 58.2 хувь, зарлагын 87.9 хувьтай тус тус тэнцэж байна.

Гадаад хамтын ажиллагаа

2005 оны 1 дүгээр сард Швейцарын Давос хотноо зохиогдсон Дэлхийн эдийн засгийн форумд зориулж Монгол улсын эдийн засгийн сүүлийн үеийн төлөв байдал, банк санхүүгийн зах зээлийг гадаадын бизнесийн орчинд таниулж сурталчлах, гадаадын

хөрөнгө оруулалт татах зорилгоор тус форумын албан ёсны сэтгүүлд Монгол улсын тухай тусгай дугаарыг хавсралтаар гаргаж, олон улсад нэр хүнд бүхий сэтгүүлд Монгол улсын тухай нийтлэлүүдийг хэвлүүллээ.

1999 оны 12 дугаар сарын 23-нд “Стандарт энд Пүэрс” компани нь Монгол улсын анхны зэрэглэлийг “Тогтвортой Б”-ээр тогтоосон байна. Олон улсын санхүүгийн зах зээлд Монгол улс зээлжих зэрэглэлтэй болсноор Монголын Засгийн газар болон аж ахуйн нэгж, байгууллагууд аль нэг оронтой эдийн засгийн ба хамтын ажиллагааны асуудлаар харилцахад хамгийн түрүүнд хэрэглэгдэх Монгол орны эдийн засгийн байдал, хэтийн төлөвийг үнэлсэн дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээтэй болсон юм.

Үүнээс хойш “Стандарт энд Пүэрс” зэрэглэл тогтоогч компанийн тогтоосон зээлжих зэрэглэл нь 2001 оны 6 дугаар сарын 14-нд “Б эерэг Б”, 2002 оны 9 дүгээр сарын 6-нд “Б тогтвортой Б” болж, 2004 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар “Б тогтвортой Б” хэвээр тогтоогдсон байгаа билээ.

Өнөөгийн эдийн засгийн шинэ нөхцөл байдалд Монгол улсад олон улсын санхүүгийн зах зээлээс өөрийн төсвийн хэрэгцээнд зориулж урт хугацааны болон хямд санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх онц шаардлага байгаа тул Монголбанкны зүгээс энэ чиглэлээр холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийсний үр дүнд эхний ээлжинд зээлжих зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд зөвлөгч “Сити групп” компанийг сонгон зохих албан бичигт гарын үсэг зурж, хамтран ажиллах нарийвчилсан тодорхой ажлын төлөвлөгөөг баталсан болно.

Энэхүү ажлын хүрээнд одоогийн байдлаар “Фич” болон “Мүүдийз” зээлжих зэрэглэл тогтоогч компаниуд Монгол улсын зээлжих зэрэглэлийг ахиулж, “Б нэмэх” зэрэглэлтэй болгосон бөгөөд “Стандарт энд Пүэрс” компани нь урт хугацааны хэтийн төлөвийг “эерэг”, богино хугацаанд “Б” зэрэглэл хэвээр тогтоосон байна. Зэрэглэл ахиулахад гол нөлөөлсөн хүчин зүйлсийн хувьд нэгдүгээрт, Монгол улсын бодит үндэсний нийт бүтэгдэхүүн нь 10.6 хувиар өссөн, хоёрдугаарт, гадаадын түүхий эдийн тааламжтай (зэс болон алтны үнэ өндөр байгаа явдал) нөхцөл байдал үүссэнтэй холбоотой юм.

Монгол улс өөрийн зээлжих зэрэглэлийг ахиулж Индонез, Филиппин, Пакистан зэрэг орнуудтай ижил зэрэглэлтэй болсноор гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг зүй ёсоор татаж байгаа байдал харагдаж байна.

Англи улсын Лондон хот дахь Монголбанкны төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа

Монгол улсын валютын нөөцийн удирдагыг мэдээллээр хангах, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай холбоо тогтоон Монголбанкны гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын санхүүгийн зах зээл, түүний шинэ бүтээгдэхүүний судалгаа хийж, Монголбанкны ажилтнуудыг мэдээллээр хангах, сургалтанд хамруулахад үндсэн ажил чиглэгдэв.

Англи, Люксембург, Герман, Итали, Япон, Энэтхэгийн төв банкууд зэрэг гадаадын болон олон улсын банк санхүүгийн 100 гаруй байгууллагатай холбоо тогтоон ажиллаж байна. Их Британийн харьяалалд байдаг Гибралтар дахь санхүүгийн төв, Английн Санхүүгийн үйлчилгээний хороо, Италийн Экспортын даатгалын улсын

байгууллагын үйл ажиллагаатай Монголбанк, Сангийн Яамны ажилтнуудыг танилцуулан хамтын ажиллагаа тогтоов.

Монгол улсыг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк (ЕСБХБ)- ны зээлжих бүрэн эрхтэй гишүүн болгуулах, экспорт, импортын санхүүжилт, орон сууцны урт хугацааны зээл, жижиг дунд үйлдвэрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зээлийн хөнгөлттэй хямд эх үүсвэр авах, банкуудад мэргэжилтэн зөвлөхийг техникийн туслалцаа хэлбэрээр ажиллуулах, банкуудад ЕСБХБ-ийг хөрөнгө оруулах чиглэлээр хамтран ажиллуулахаар бэлтгэл хийж байна. ЕСБХБ-тай хамтран Монголбанк, банкуудын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн “Банкны сургалтын программ” нэртэй төслийг хэрэгжүүлж дуусгав. Төслийн санхүүжилтээр төв болон бусад банкны 50 гаруй ажилтан Англи, Люксембургийн Төв банк, Санхүүгийн технологи дамжуулах агентлагийн сургалтанд хамрагдав. Сургалтанд оролцсон ажилтнууд гадаадын банкуудын дэвшилтэт техник технологос суралцаж үйл ажиллагаандаа идэвхтэй хэрэгжүүлж эхэлсэн байна. Экспорт, импортын зээл санхүүжилт, олон улсын санхүүгийн гэмт хэрэг, мөнгө угаах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн, эрсдэлийн удирдлага зэрэг сэдвээр сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулав. Сургалтанд төв болон банкны 265 ажилтан үнэ төлбөргүй хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүллээ. Сургалтын зардлыг Япон, Нидерланд, Люксембург, Тайваны Засгийн газрын буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн байна.

Олон улсын санхүүгийн зах зээлийн туршлагыг судлан, Монгол улсыг бүсийн санхүүгийн төв болгон хөгжүүлэх боломжийн талаар судалгаа хийж байна. Монгол улсын хөрөнгө оруулалтын зэрэглэлийг тогтоолгох, дэлхийн үнэт цаасны зах зээлд Монгол улсын байр суурийг бий болгох, олон улсын санхүүгийн зах зээлээс хямд эх үүсвэрийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх талаар дэлхийд нэртэй банкуудтай хамтран ажиллах ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Английн Төв банктай хамтран “Санхүүгийн тогтвортой байдал” бүсийн олон улсын семинарыг Монголд зохион байгуулж, семинарт Хятад, Тажикстан, Киргиз, Казахстаны Төв банкуудын төлөөлөгчид оролцжээ. Английн төв банкны 2004-2005 оны сургалтанд Монголбанкнаас 20 гаруй хүнийг оролцуулж, Хяналтын Зөвлөлийн гишүүдийг Английн төв банкны удирдлагын туршлагаас судлуулав.

Германы Төв банкны техник туслалцаатайгаар 2005 онд төлбөр тооцоо, банкны автоматжуулалт, хяналт шалгалт, гадаад валютын нөөцийн удирдлага, ББСБ-ын асуудлаар 20 хүн, сүүлийн 2 жилд нийдтээ 40 гаруй хүнийг туршлага судлуулах курс, олон улсын семинарт Франкфурт хотноо сургав.

Люксембургийн төв банкны Ерөнхийлөгчийн Монголд хийх айлчлалыг зохион байгуулж, тус банкны туршлагаас Монголбанкны газар хэлтэс бүр өөр өөрсдийн чиглэлээр явж судлав. Люксембургийн Засгийн газрын 100 хувийн тэтгэмжээр Монголбанкнаас 2, ХХБ-наас нэг ажилтанг Люксембургийн Их сургуулийн банк санхүүгийн магистрийн сургалтанд, банкуудаас 6 ажилтанг удирдах ажилтны сургалтанд хамруулав. 2006 оны хувьд сургалтын хэлбэр тоо хэмжээг нэмж, Люксембургэд 6 төрлийн, Монголд 3 төрлийн сургалтыг банкны ажилтнуудад зориулан зохион байгуулах, магистрийн сургалтанд 4 ажилтанг явуулахаар хэлэлцээр хийж байна.

Монгол улсын валютын нөөцийг үр ашигтай, зохистой байршуулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, нөөцийн удирдлагыг сайжруулж боловсронгуй болгохтой холбогдсон мэдээлэл цуглуулах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүний судалгаа хийх, Монголбанкны ажилтнуудыг мэдээллээр хангах, гадаадын мэргэжилтнүүдийг Монголд уулзуулах зэрэг ажил нь валютын нөөц, Монголбанкны ашиг орлого өсөн нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлж байна. Англид ажиллаж, сурч, амьдарч байгаа монголчуудын дунд жил бүр судалгаа хийж холбогдох мэдээллийг төлбөрийн тэнцэлд тусгадаг.

Монголбанкны төлөөлөгч нь зөвхөн Монголбанкаар хязгаарлагдахгүй, Сангийн яам, Үнэт цаасны хороо, Хөрөнгийн бирж, Даатгал, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газруудыг ижил төстэй байгууллагуудтай холбоо тогтоож хамтран ажиллахад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлж байна.

6. БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛ

Банк, банк бус санхүүгийн байгууллагатай зээл, барьцааны гэрээ байгуулсан зээлдэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцаанд тавьсан ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах замаар үүргийн биелэлтийг хангуулах харилцааг зохицуулж, “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль”-ийг 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хурал баталлаа.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийг 2005 оны 11 дүгээр сарын 17-нд УИХ-аас баталснаар даатгал, банк бус санхүүгийн болон үнэт цаасны үйл ажиллагаа эрхлэх, хадгаламж, зээлийн хоршоодыг байгуулан ажиллуулахад төрийн зохицуулалт хийж, энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа санхүүгийн байгууллагад шалгуур үзүүлэлт тогтоож, хяналт тавих замаар хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий Санхүүгийн зохицуулах хороог байгуулан хорооны эрх зүйн байдлыг тодорхойлов.

МОНГОЛБАНКНААС 2005 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ

Сар, өдөр	Дугаар	Нэр	Агуулга
1-03	01	Монголбанкны Улсын байцаагчийн эрх зүйн байдлын тухай журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Банк бус санхүүгийн байгууллага болон Хоршооны тухай хуулийн дагуу эдгээр байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх зохистой харьцааны үзүүлэлтийг Монголбанк тогтоож, Монголбанкны улсын байцаагч хяналт тавих болсонтой холбогдуулан журмын 1.1, 2.1.2, 2.1.4, 2.2.1, 2.5.4, 4.1.1.а, 4.1.1.б заалтуудыг өөрчлөн найрууллаа.
1-12	22	Алтны үнийг өөрчлөн тогтоох тухай	Аж ахуй нэгж, байгууллага, иргэдээс Монголбанкинд тушаасан бохир алтыг хадгалж, хамгаалах, тээвэрлэх, даатгуулах, цэвэршүүлэхтэй холбогдон гарах зардлыг унц алт бүрт 1 доллар 50 цент байхаар

			шинэчлэн тогтоов.
2-22	83	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Гадаадын иргэн, хуулийн этгээд итгэлцлийн гэрээгээр хөрөнгийн эх үүсвэр татаж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тэдэнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрөл олгохоос татгалзах зэрэг харилцааг зохицуулав.
2-22	84	Дүрмийн сангийн доод хэмжээ тогтоох тухай	Олон улсын санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг 1 500 000 000.00 төгрөгөөс доошгүй байхаар тогтоов.
03.11	104	Банк хоорондын төлбөр тооцооны журамд өөрчлөлт оруулах тухай	Журмын хавсралт “Банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ”-ний 1.5.2 дахь заалтад өөрчлөлт оруулснаар банкны Монголбанкин дахь гадаад валютын харилцах дансаар (баримтаар) дамжин хийгдэх гүйлгээг зөвхөн тухайн өдрийн 12:00 цаг хүртэл хүлээн авч, гүйлгээ тус бүрийн үнэлгээг 1 ам. доллар байхаар тогтоов.
3-25	123	Төлбөр тооцооны төв байгуулах тухай	Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан Хөгжлийн зээлийн гэрээний “Төлбөрийн системийг шинэчлэх” төслийн баримт бичгийг үндэслэн Бүртгэл тооцоо, мэдээллийн технологийн газрын бүтцэд Төлбөр тооцооны төвийг нэмж байгуулав.
3-28	128	Зөвлөмж батлах тухай	Монголбанк хууль бус болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүднээс санхүүгийн үйлчилгээг үзүүлэхдээ анхааран ажиллавал зохих зарим зүйлийг банк, банк бус санхүүгийн байгууллагад зөвлөв.
3-29	131	Зээлийн мэдээллийн сангийн журам батлах тухай	Энэ тушаалаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 565 тоот тушаалаар батлагдсан “Зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг хүчингүй болгож, санд ирүүлэх мэдээллийг дэлгэрүүлж, мэдээллийг зүй бусаар ашигласан, санд буруу мэдээлэл ирүүлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгав.
4-06	147	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 553 тоот тушаалаар баталсан “Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын

			журам"-ын 3.5, 3.6, 3.11 дэх заалтуудыг өөрчилж, нээлттэй позицийг тооцох арга, Монголбанкны гадаад арилжааны лимитийг тогтоов.
08-30	397	Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Журмын заалтыг тодорхой, боловсронгуй болгох, хоёрдмол утгыг арилгах зорилгоор 13, 16 дахь заалт болон журмын хавсралтад зарим нэмэлт, өөрчлөлт оруулав.
10-11	461	ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Энэ тушаалаар банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн хэмжээг шинэчилж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7, 7.1.9-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг Улаанбаатар хотод 200.0 сая төгрөг, Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр суманд 100.0 сая, төгрөг, бусад аймгийн төвд 10.0 сая төгрөг, мөн хуулийн 7.1.6,7.1.8-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг 500.0 сая төгрөгөөс доошгүй байхаар тус тус тогтоов.
10-14	483	Журам батлах тухай	Энэ журмаар Монгол Улсын эрдэнэсийн санд эрдэнэс худалдан авах, сангаас худалдахад эрдэнэсийг үнэлэх, төлбөр тооцоог нь гүйцэтгэх, хяналт тавих зарчмыг тогтоолоо.
10-18	487	Жухам батлах тухай	Журмаар “Овернайт зээлийн журам батлах тухай” Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 284 тоот тушаалыг хүчингүй болгож, банк хооронд овернайт зээл олгох, мөн Монголбанкнаас банкинд овернайт зээл олгоход тус тус баримтлах журмыг баталлаа.
11-15	535	Журамд өөрчлөлт оруулах тухай	Банк хоорондын төлбөр тооцоонд баримталж байгаа журам, банк хооронд төлбөр тооцоо гүйцэтгэх ажлын гэрээгээр тохиролцсон үйлчилгээний шимтгэлийн хэмжээ, гүйлгээ хүлээн авах цагийн хуваарьт өөрчлөлт оруулав.
11-24	550	Журамд өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 167 тоот тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн багц журам”-ын хавсралтаар дансны нэгдсэн төлөвлөгөөний актив талын 4, 5, 7 дугаар бүлгийн санхүүгийн түрээс, факторингийн

			үйлчилгээ, бусад актив, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө гэсэн бүлэгт хэвийн, хугацаа хэтэрсэн, хэвийн бус эргэлзээтэй, муу гэсэн дансдыг шинээр нэмж, мөн шаардлагагүй зарим дансдыг хаав.
12-15	588	“Монголбанкны Дотоод аудитын үйл ажиллагааны ерөнхий заавар”, “Дотоод аудитын газрын хянан шалгагчийн гарын авлага”-ыг батлах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны А/03 тоот тушаалаар батлагдсан “Дотоод аудитын газрын хянан шалгагчийн гарын авлага”-ыг батлах тухай журмыг өөрчилж, Монголбанкны үйл ажиллагааны эрсдэлийг хянахад хянан шалгагчдын дагаж мөрдөх зарчим, арга зүйн зөвлөгөөг шинэчлэн тусгав.
12-15	600	“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам” батлах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 136 тоот тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох жухам”-ыг боловсронгуй болгож, банк бус санхүүгийн байгууллага, түүний нэгжийг байгуулах, нэмэлт үйл ажиллагаа эрхлэх, дүрмийн сангийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах, оноосон нэр солих зөвшөөрөл олгох, баримт бичгийг хянах, олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон бусад зохицуулалтын асуудлыг цогцоор нь зохицуулахаар журмыг шинэчиллээ.